



Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс

# ХҮНИЙ ЭРХ

ОНОЛ, АРГА ЗҮЙН СЭТГҮҮЛ

UIN.MN  
СУДАЛГААНЫ САН

“Хүний эрх, эрх чөлөөг орон даяар,  
цаг ямагт, хүн бүрт”  
[19 дэх жилдээ]

2020/02

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс

# ХҮНИЙ ЭРХ

---

Онол, арга зүйн сэтгүүл

“Хүний эрх, эрх чөлөөг орон даяар,  
цаг ямагт, хүн бүрт”

---

[19 дэх жилдээ]

**2020/02**

ХҮНИЙ ЭРХ сэтгүүл  
2020/02 (56)  
Улсын бүртгэлийн дугаар 244  
19 дэх жилдээ

- П.Оюунчимэг *Ерөнхий редактор (Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн, Хууль зүйн ухааны доктор, дэд профессор)*
- З.Өнөржаргал *Хариуцлагатай нарийн бичгийн дарга (Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын Ахлах референт)*

UIN.MN  
СУДАЛГААНЫ САН

**© Сэтгүүлд нийтлэгдсэн бүтээл нь Хүний эрхийн Үндэсний Комиссын бодлогыг илэрхийлэхгүй, зөвхөн зохиогчийн үзэл бодол болно.**

ISSN: 2617-9288

**ӨГҮҮЛЭЛ, НИЙТЛЭЛ***В.Амарсанаа*

Оросын Холбооны Улс болон Монгол Улсын Эрүүгийн  
хуульд заасан хууль сахиулагчдын амь биед халдах  
гэмт хэргийн хариуцлагын талаарх эрх зүйн журам . . . . . 5

*С.Гантулга**Б.Энхболд*

Бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэргийн  
шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх асуудал. . . . . 17

*Л.Галбаатар*

Интернэтийн хандалтыг хязгаарлах, нийгмийн  
сүлжээгээр тархи угаах, хувийн өгөгдлийг задруулахаас  
хүний эрхийг хамгаалах нь . . . . . 34

*Б.Лхагварাগчаа*

Хүний эрх ба цагдаагийн байгууллагийн үүрэг, хариуцлага . . . . . 43

*П.Намуун*

Авлига, албан тушаалын гэмт хэрэг ба хүний эрх . . . . . 58

*Я.Цэлмэн*

Хуулийн этгээдийн эрхийн баталгаажилт ба хязгаарлалт. . . . . 72

**МОНГОЛ ХЭЛЭЭР ЗӨВХӨН МАНАЙ ХУУДАСНАА***Сара Пульман**Ричард Вильшо**Жеми Грэйс*

Цагдаагийн хууль сахиулах ажиллагаан дахь  
хүний эрх: Өнгөрсөн, одоо, ирээдүй . . . . . 98

**ЗОЧНЫ ЯРИА***Цагдаагийн Ерөнхий газрын Соён гэгээрүүлэх албаны дарга,**цагдаагийн хурандаа Д.Долгорсүрэнтэй хийсэн ярилцлага*

“Цагдаагийн албаны онцлог нь саад бэрхшээлийг  
гомдоллохгүйгээр даван туулах, ажлын ачаалал даах,  
бие болоод сэтгэл зүйн хат суулгадаг” . . . . . 111



## CONTENT

### ARTICLES

*Amarsanaa.V (Ph.D)*

Legal regulation of liability for assaulting law enforcers  
in the criminal legislation of the Russian Federation and Mongolia . . . . . 5

*Gantulga.B (Ph.D)*

*Enkhbold.S (Ph.D)*

Causes of crimes of murder and rape against children and issue of prevention . . . 17

*Galbaatar.L*

Protecting human rights from internet shutdown,  
social media manipulation and data breaches . . . . . 34

*Lkhagvaragchaа.B (Ph.D)*

Human rights and roles and responsibilities of the police. . . . . 43

*Namuun.P*

Corruption and white collar crimes and human rights . . . . . 58

*Tselmen.Ya*

Guarantees and restrictions on the rights of legal entities . . . . . 72

### ONLY IN MONGOLIAN

*Poolman Sarah*

*Wilshaw Richard*

*Grace Jamie*

Human rights in policing: The past, present and future . . . . . 98

### GUEST INTERVIEW

*Ms.D.Dolgorsuren, colonel of police, Head of Public Awareness  
and Training Division of the National Police Agency*

“Police service is peculiar as it builds for its service persons  
physical and mental strength to overcome any obstacles  
without question and to bear burden” . . . . . 111





## В.АМАРСАНАА

Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн  
Мөрдөх арга зүйн тэнхимийн багш, доктор, цагдаагийн ахмад

### ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС БОЛОН МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬД ЗААСАН ХУУЛЬ САХИУЛАГЧДЫН АМЬ БИЕД ХАЛДАХ ГЭМТ ХЭРГИЙН ХАРИУЦЛАГЫН ТАЛААРХ ЭРХ ЗҮЙН ЖУРАМ

### LEGAL REGULATION OF LIABILITY FOR CRIME OF ASSUALTING LAW ENFORCERS IN THE CRIMINAL LEGISLATION OF THE RUSSIAN FEDERATION AND MONGOLIA

**Хураангуй:** Хууль сахиулах байгууллагын ажилтнууд нь ямагт хүний эрхийг дээдэлж хуульд захирагдах бөгөөд хуулиар өөрсдөд хүлээлгэсэн өндөр хариуцлагын хүрээнд гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдлыг хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлэх замаар хүн бүрийг гэмт халдлагаас хамгаалдаг. Ингэхдээ гүйцэтгэж буй үүргээсээ хамаарч өдөр тутамд гадны хүчин зүйлээс шалтгаалан тэд эрсдэл, аюул, заналхийлэлд өртөх явдал цөөнгүй гардаг. Хүн бүр эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ гагцхүү хуулиар тогтоосон хязгаарлалтад захирагдах бөгөөд эдгээр хязгаарлалт нь бусдын эрхийг хүлээн зөвшөөрөх, хүндэтгэх, зан суртахуун, нийгмийн дэг журам, ардчилсан нийгэм дэх нийтийн сайн сайхны шудрага шаардлагыг хангахад

чиглэсэн байх ёстой. Хууль сахиулах байгууллагуудын тэргүүн зорилтуудын нэг болох ард иргэдийн амгалан тайван, аюулгүй байдлыг хамгаалах үүргээ хэрэгжүүлэхдээ нийгмийн олон бүлгийн хүмүүстэй харилцахын хэрээр хуулиар тогтоосон хэм хэмжээг дагаж мөрдүүлэх үйл ажиллагааны явцад тэд амь бие, эрүүл мэндээрээ хохирох явдал сүүлийн жилүүдэд нэмэгдэх хандлагатай байна. Иймд ОХУ болон Монгол Улсын хууль сахиулагчдын амь биед халдах үйлдлийг Эрүүгийн хуулиар зохицуулсан байдалд дүн шинжилгээ хийж, бодит байдлыг харьцуулан судалж, адил төстэй болон ялгаатай талыг гаргахыг зорилоо.

**Түлхүүр үг:** Нийтийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдал, хууль сахиулагч, Эрүүгийн хууль, ерөнхий бүрэлдэхүүн, тусгай бүрэлдэхүүн.

**Abstract:** *Employees and officers of the law enforcement institutes always respect human rights, laws, carry out special tasks and missions in combating crimes, ensuring public orders, securing public safety and preventing crimes within their own high responsibilities. Every person shall enjoy the rights and freedom within limits stipulated in the laws and legislations and these limits must be focused to recognize the freedom of other people, respect them and provide the behavioral and social orders and fair requirements for public wellbeing in the term of democratic society. One of the priorities of law enforcement institutes must be safe and quiet for the society.*

*The likeliness of these officers to be exposed to risks, dangers and threats from external factors on a daily basis is very high. The law enforcement officers in other countries than Mongolia have increasingly involved in law enforcement actions in recent years, interacting with people from all classes of society, putting their lives and health in high risk while enforcing legal norms. Therefore, it is targeted to analyze and make comparisons on the realization of the criminal code, which is a source of a legal protection for the lives of law enforcement officers in the Russian Federation and Mongolia, and to determine the similarities and differences.*

**Keywords:** *Public order, public safety, law enforcement officer, criminal code, main staff members, special staff members.*

ОИХ.МН  
СУДАЛГААНЫ САН

## I. Оршил

Аливаа улс орон нь Эрүүгийн хуулиа төгөлдөржүүлэхийн тулд гадаад улс орнуудын гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр явуулж буй эрүүгийн эрх зүйн нөлөөллийн туршлагыг судлах нь эргэлзээгүй чухал билээ. Энэ талаар эрдэмтэн М.Ансель “Гадаад улс орны туршлагыг судлах явдал нь хуульч, судлаачдад шинэ, далайцтай мэдлэг олгохоос гадна, өөрийн улсын эрх зүйн талаар гүнзгий мэдлэг эзэмших үүд хаалгыг нээдэг. Хуулийн өвөрмөц онцлог нь бусад системтэй харьцуулсан шинжилгээний үр дүнд илэрдэг. Харьцуулсан судалгаа нь хуульчийг зөвхөн өөрийн улсын эрх зүйн тогтолцоог сайн судалснаар олж авах боломжгүй үзэл санаа болон аргументаар зэвсэглэх хүчтэй байна”<sup>1</sup> гэж тодорхойлжээ. Тиймээс хууль сахиулагчийн амь биед халдах гэмт хэрэгт хүлээлгэх хариуцлагын талаарх ОХУ-ын хууль, эрх зүйн зохицуулалтын талаар судалгаа явуулж, энэхүү зүйл ангийн тухай дэс дараатай харьцуулалт явуулах нь чухал гэж үзлээ. Судалж буй асуудлыг Монгол Улсын Эрүүгийн хуулийг бодвол ОХУ-ын Эрүүгийн хуульд харьцангуй их ач холбогдол өгч зохицуулжээ. Түүнээс гадна ОХУ болон Монгол Улсын орчин үеийн Эрүүгийн хуулийг харьцуулах явдал нь хууль сахиулагчдын амь биед халдах гэмт хэргийн эрүүгийн хариуцлагын талаарх журмын ялгаа болон онцлогийг нээн илрүүлж, энэ чиглэлээр эрүүгийн эрх зүйн харилцааг сайжруулах цаашдын боломжийг тодорхойлоход чухал юм. Хууль сахиулагчдын амь биеийг хамгаалах талаар эрүүгийн эрх зүйн харилцааг ОХУ-ын Эрүүгийн хуульд харьцангуй дэс дараатай, бүх талаас нь тусгасан болох нь үндсэн зорилтын нэг хууль сахиулагчдын амь биеийг хамгаалах харилцаанд онцгой анхаарал хандуулж, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 32 дугаар бүлэг (Захиргааны журмын эсрэг гэмт хэрэг)-т тусгай бүрэлдэхүүнт (специальный состав) гурван зүйл ангийг хуульчилсныг харьцуулан судаллаа.

## II. ОХУ болон Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан хууль сахиулагчдын амь биед халдах гэмт хэргийн харьцуулалт

Өгүүллийн үндсэн судлагдахуун болох нийтийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдлыг хамгаалах чиглэлээр албан үүргээ гүйцэтгэж байгаатай нь холбогдуулан хууль сахиулагчдын амь биед халдах гэмт хэрэг (ОХУ-ын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 317 дугаар зүйл) нь Захиргааны журмын эсрэг гэмт хэргийн бүлэгт багтсан хэргүүдээс цаазын ялтай цор ганц зүйл анги юм. Энэ гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүн нь ОХУ-ын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 317 дугаар зүйлд “Хууль сахиулагч болон цэргийн алба хаагчийн хууль ёсны үйл ажиллагаанд саад учруулах зорилгоор нийтийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдлыг хамгаалах чиглэлээр албан үүргээ гүйцэтгэж байгаатай нь холбогдуулан тэдний амь биед халдсан, эсхүл тэднийг үйл ажиллагаа явуулсантай нь холбогдуулан

1 Ансель М. Методологические проблемы сравнительного права // Очерки сравнительного права: сб. М., 1981, с. 38.



өс хонзонгийн сэдлээр ойр дотны хүмүүсийн амь биед халдсан бол арван хоёроос хорин жилийн хугацаатай хорих ялаар шийтгэж, хоёр жилийн хугацаатай эрх чөлөөг хязгаарлах, эсхүл бүх насаар нь хорих, эсхүл цаазаар авах ялаар шийтгэнэ” гэж заасан байна.

Монгол Улсын одоогийн Эрүүгийн хууль нь өөрчлөлтийн үетэй нүүр тулаад байна. Тодруулбал 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжиж буй шинэ Эрүүгийн хуулиар олон төрлийн өөрчлөлтүүд хийгдсэн хэдий ч судлаж буй гэмт хэргийн бүрэлдэхүүнд өргөн хэмжээний өөрчлөлт ороогүй байна. Тухайлбал Эрүүгийн хуулийн тусгай ангийн 23 дугаар бүлэг (Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг)-т хууль сахиулагчдын эрүүл мэндэд халдах үйлдлийг тусгай бүрэлдэхүүнт нэг зүйл ангиар зүйлчилдэг байна. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 23.1 дүгээр зүйлд “Хууль сахиулагчийг албан үүргээ биелүүлэхтэй нь холбогдуулан хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлж эсэргүүцсэн бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэжээ. Хэдийгээр хууль сахиулагчийн эрүүл мэндэд хохирол учруулах гэмт халдлагыг тусгай бүрэлдэхүүнээр хуульчилсан боловч тэдгээрийн амь биед халдах гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд бусдыг санаатай алах гэмт хэргийн хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар зүйлчилсэн байна. Өөрөөр хэлбэл Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.9-д “Эрхэлж байгаа ажил, албан үүрэгтэй нь холбогдуулж өөрийг нь, түүний ойр дотны хүнийг алсан бол арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар нь хорих ял шийтгэнэ” гэжээ. Хууль сахиулагчийг эрхэлж байгаа ажил, албан үүрэгтэй нь холбогдуулж санаатай алах гэмт хэрэг нь нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэргийн хүрээнээс гарч, хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэргийн бүлэгт хамрагдаж байна. Энэхүү ангилал нь гэмт хэргийн үндсэн объектоос шууд хамааралтай бөгөөд хууль сахиулагчдын амь биед халдах гэмт хэрэг нь ердийн болон хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр бусдыг санаатай алах гэмт хэргийн бүрэлдэхүүнд багтаж, хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр бусдыг санаатай алах бусад хэрэгтэй нэгэн адил хариуцлага оногдуулахаар зохицуулжээ.

Тэгэхээр ОХУ-ын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 32 дугаар бүлэгт “Хууль сахиулагчийн амь биед халдах” гэмт хэргийг тусгайлан (специальный состав) зааснаар Монгол Улсын Эрүүгийн хуулиас ялгаатай тал нь хууль сахиулагчдын амь биед халдах гэмт үйлдлийн эрүүгийн эрх зүйн хамгаалалтын харилцааг хангалттай зохицуулж өгчээ. ОХУ-ын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 317 дугаар зүйлийн диспозицод “Хууль сахиулагч болон цэргийн алба хаагчийн хууль ёсны үйл ажиллагаанд саад учруулах зорилгоор нийтийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдлыг хамгаалах

чиглэлээр албан үүргээ гүйцэтгэж байгаатай нь холбогдуулан тэдний амь биед халдсан, эсхүл тэдний үйл ажиллагаа явуулсантай нь холбогдуулан өс хонзонгийн сэдлээр ойр дотны хүмүүсийн амь биед халдсан бол”<sup>2</sup> гэж заажээ. Хууль тогтоогчийн зүгээс энэ зүйл ангийг хуульчлахдаа гэмт хэрэг нь эрт үе шатанд төгсөх, өөрөөр хэлбэл хэлбэрийн бүрэлдэхүүнтэй байх тал дээр ихээхэн анхаарал хандуулжээ. Энэ зүйл ангийн хэлбэрийн бүрэлдэхүүний шинж нь объектив талын шинжээрээ (амь биед халдах) илэрхийлэгдэж байна.

Монгол Улсын Эрүүгийн хуулийг ОХУ-ын Эрүүгийн хуультай харьцуулахад бага зэрэг өөр үзэл баримтлалтай байгаа нь хууль сахиулагчдын амь биед халдах гэмт хэргийг зөвхөн ерөнхий бүрэлдэхүүнд тусгаснаар илэрч байна. Монгол Улсын эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаанд “Бусдыг санаатай алах” нэр томъёог эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл бүхий бусдын амь насыг санаатай хохироосон үйлдэл хэмээн тодорхойлжээ. Мөн Монгол Улсын Дээд шүүхийн тайлбарт “Хүний амь бие, эрүүл мэндэд хууль бусаар халдах замаар хохирол учруулах нь онц аюултай гэмт хэрэг мөн. Энэ төрлийн гэмт хэрэгтэй хийх шийдэмгий тэмцэл нь хууль, шүүхийн байгууллагын үндсэн зорилгын нэг мөн”<sup>3</sup> гэжээ.

Дээр дурдсаны дагуу Монгол Улсын Эрүүгийн хуульд ОХУ-ын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 317 дугаар зүйлтэй адил тусгай бүрэлдэхүүнт зүйл анги хуульчлагдаагүй ажээ. Гэхдээ Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлтэй адил агуулгатай зүйл анги ОХУ-ын Эрүүгийн хуульд тусгалаа олжээ. Энэ нь тус улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 105 дугаар зүйл (Хүнийг санаатай алах) анги юм. Үүнээс үзэхэд ОХУ болон Монгол Улсын Эрүүгийн хуульд бусдыг санаатай алах ойлголт адил, төсөөтэй тайлбарлагдаж байна.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлийн 2.9 дэх хэсэгт заасан хууль сахиулагчийг эрхэлж байгаа ажил, албан үүрэгтэй нь холбогдуулж өөрийг нь бөгөөд түүний ойр дотны хүнийг алах гэмт хэрэг нь идэвхтэй, санаатай үйлдэл ба эс үйлдэхүйгээр илэрдэг. Хохирогч нас барсан үеэс эхлэн хүнийг санаатай алсан үйлдлийг төгссөн гэмт хэрэг гэж үзнэ. Үүнээс үзэхэд ОХУ болон Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан хууль сахиулагчийн амь биед халдах гэмт хэргийн үйлдэл нь төгсөх үе шатаараа ялгагдаж байна.

2 Уголовный кодекс Российской Федерации. М, 2016, С. 229.

3 Сборник постановлений Пленума Верховного Суда Монголии. Улаанбаатар, 2001, С. 59.

### III. “Нийтийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдлыг хамгаалах” тодорхойлолтын талаар

ОХУ-ын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 317 дугаар зүйлд заасны дагуу хууль сахиулагч болон цэргийн алба хаагчийн хууль ёсны үйл ажиллагаанд саад учруулах зорилгоор нийтийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдлыг хамгаалах чиглэлээр албан үүргээ гүйцэтгэж байгаатай нь холбогдуулан тэдний амь биед халдсан, эсхүл тэдний үйл ажиллагаа явуулсантай нь холбогдуулан өс хонзонгийн сэдлээр ойр дотны хүмүүсийн амь биед халдсан үйлдэл нь эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл болдог. Түүнчлэн ОХУ-ын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 317 дугаар зүйлийн диспозицод хууль сахиулагч нь ямар төрлийн үйл ажиллагаа явуулсны төлөө гэмт халдлагаас хамгаалагдах ёстой талаар тодорхой заажээ. Энэ нь нийтийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдлыг хамгаалах хууль ёсны үйл ажиллагаа явуулсан байхыг шаардаж байна.

Харин Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлийн 2.9 дэх хэсэгт хууль сахиулагчийг эрхэлж байгаа ажил, албан үүрэгтэй нь холбогдуулж өөрийг нь, түүний ойр дотны хүнийг санаатай алсан нөхцөлд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нь ОХУ-ын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 317 дугаар зүйлийн диспозицтой төстэй боловч Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлийн 2.9 дэх хэсэгт “нийтийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдал” заасан тодорхойлох шинжийг тусгаагүй явдал нь уг зүйл, заалтыг практикт хэрэглэхэд хүндрэл учруулж байна. Энэ байдлаар хууль сахиулагч субъектын хүрээг хязгаарлаагүй нь хангалттай өргөн хүрээний субъектыг хамруулах бодлого баримталж буй явдал гэж үзэхээр байна.

ОХУ-ын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 317 дугаар зүйлийн диспозицод уг гэмт хэргийн хохирогч (объект)-ийг тодорхой тусгасан байдаг. Тухайн үеийн Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын (РСФСР) 1960 оны Эрүүгийн хуульдаа 191.2, 191.5 гэсэн хоёр зүйл ангийг нэгтгэсэн байсан бол одоо хүчин төгөлдөр хэрэгжиж буй Эрүүгийн хууль (1996 оны Эрүүгийн хууль)-д хууль сахиулагчдын амь биед халдах гэмт хэргийн хохирогчийг дараах гурван төрөлд хуваажээ. Үүнд: Хууль сахиулагч, цэргийн алба хаагч болон тэдгээрийн төрөл садны хүмүүс<sup>4</sup> багтаж байна.

Гэхдээ ОХУ-ын Эрүүгийн хуульд “Хууль сахиулагч” гэх нэр томъёог албан ёсоор тайлбарлаагүй байна. Хууль сахиулагч гэх нэр томъёоны тайлбарыг 1995 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 45 дугаартай “Шүүгч, хууль сахиулах болон хяналтын байгууллагын алба хаагчдын улсын хамгаалалтын тухай”<sup>5</sup> хуулиас олж болох хэдий ч энэ хуульд дурдсан бүх албан

4 Щербачков А. В. Преступления против порядка управления: научно-практический комментарий к главе 32 УК РФ. М, 2011, С. 58.

5 URL: [http://www.consultant.ru/document/cons\\_doc\\_LAW\\_6425/](http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_6425/)

тушаалтнууд гүйцэтгэж буй албан үүргийн онцлогоос хамаарч Эрүүгийн хуулийн тусгай ангийн 317 дугаар зүйлд заасан гэмт хэргийн хохирогч байх үндэсгүй болохыг тэмдэглэх нь зүйтэй. Тэгэхээр 317 дугаар зүйлийн диспозицод заасан “Нийтийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдал” гэсэн элемент нь гэмт хэргийг энэ зүйл ангиар зүйлчлэхэд үндсэн бөгөөд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж байна. ОХУ-ын эрдэмтэн С.Л.Скутин: “Хэрэв энэхүү элемент (Нийтийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдал) нь диспозицод тусгалаа олоогүй тохиолдолд 317 дугаар зүйлийн шууд объект өөрчлөгдөнө”<sup>6</sup> гэсэн бол А.Р.Саруханян: “Магадгүй (Нийтийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдал) нэр томъёог хассан тохиолдолд эдгээр үйлдэл, эс үйлдэхүйг ОХУ-ын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 105 (Хүнийг санаатай алах) дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “б” пунктээр зүйлчилж болох юм”<sup>7</sup> гэжээ. Хууль сахиулах байгууллагын алба хаагчдад хамаарахгүй бусад албаны албан хаагчид нь нийтийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдлыг хамгаалах чиглэлээр үүрэг гүйцэтгэсэн нөхцөлд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 317 дугаар зүйлийн хохирогч (объект)-ийн статустай байж болох талаар мартаж болохгүй юм. Эндээс үзэхэд ОХУ-ын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 317 дугаар зүйлд заасан гэмт хэрэгт хохирогчоор тооцогдох үндэслэл, онцлог нь хэрэг гарах үед хохирогч нийтийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдлыг хамгаалах чиг үүргээ гүйцэтгэж байсантай шууд хамааралтай байна.

Тэгэхээр Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлийн 2.9 дэх хэсэг нь ОХУ-ын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 317 дугаар зүйлтэй харьцуулахад хохирогчийн хүрээ тодорхой, гэмт хэргийн бүрэлдэхүүн болон гэмт хэрэг төгсөх үе шатны хувьд харилцан адилгүй байна. Юуны түрүүнд энэ ялгаа нь Монгол Улсын Эрүүгийн хуульд хууль сахиулагчийн амь биед халдах гэмт хэргийг зүйлчлэх тусгай (специальный) бүрэлдэхүүнтэй зүйл анги байдаггүйтэй холбоотой хэмээн дүгнэж байна.

## **VI. ОХУ болон Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан хууль сахиулагчдын амь биед халдах гэмт хэргийн ялын бодлого, зохицуулалт**

ОХУ-ын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 317 дугаар зүйл (Хууль сахиулагчдын амь биед халдах)-д зааснаас гадна Эрүүгийн хуулийн тусгай ангийн 105 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “б” пунктэд “Эрхэлж байгаа ажил, албан үүрэгтэй холбогдуулан өөрийг нь, түүний ойр дотны хүнийг санаатай алах” гэмт хэрэгт хариуцлага оногдуулдаг. Өөрөөр хэлбэл тус улсын Эрүүгийн хуульд хууль сахиулагчийн амь биед халдах болон эрхэлж байгаа ажил, албан үүрэгтэй холбогдуулан өөрийг нь, түүний ойр дотны

6 Скутин С. Л. Проблемы уголовно-правовой борьбы с преступными посягательствами на жизнь, здоровье и достоинство работников милиции, охраняющих общественный порядок : дис. ... канд. юрид. наук. М, 1995, с. 88.

7 Саруханян А.Р. Указ, соч, с. 47.

хүнийг санаатай алах гэсэн хоёр тусдаа ерөнхий болон тусгай бүрэлдэхүүнт зүйл ангиуд болгон хуульчилжээ.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 317 дугаар зүйлд арван хоёроос хорин жилийн хугацаатай хорих ялаар шийтгэж, хоёр жилийн хугацаатай эрх чөлөөг хязгаарлах, эсхүл бүх насаар нь хорих, эсхүл цаазаар авах ялаар шийтгэхээр заасан бол ерөнхий бүрэлдэхүүнтэй 105 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "б" пунктэд заасан гэмт хэрэг үйлдсэн бол наймаас хорин жилийн хугацаатай хорих ялаар шийтгэж, нэгээс хоёр жилийн хугацаатай эрх чөлөөг хязгаарлах, эсхүл бүх насаар нь хорих, эсхүл цаазаар авах ялаар шийтгэхээр заажээ. Энэхүү хоёр зүйл ангийн үндсэн ялын хэмжээг авч үзвэл 317 дугаар зүйлийн ялын доод хэмжээ 12 жил, 105 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "б" пунктийн ялын доод хэмжээ 8 жил байна. Аливаа гэмт хэргийн зүйлчлэлийн хүнд, хөнгөнийг тодорхойлохын тулд үндсэн ялын хэмжээг харгалзах зарчмын дагуу 317 дугаар зүйл анги нь 105 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "б" пунктээс оноох үндсэн ялын хэмжээгээр хүнд байна. Бид эндээс ОХУ-ын Эрүүгийн хуульд хууль сахиулагчдын амь биед халдах (Тусгай бүрэлдэхүүнтэй) болон эрхэлж байгаа ажил, албан үүрэгтэй холбогдуулан өөрийг нь, түүний ойр дотны хүнийг санаатай алах (Ерөнхий бүрэлдэхүүнтэй) гэмт хэргүүдийн хоорондын ялгааг харж болохоор байна. Тус улс нь хууль сахиулагчдын амь биед халдах гэмт хэрэг үйлдсэн этгээдийн үйлдэлд тусгай бүрэлдэхүүнтэй зүйл ангиар хариуцлага тооцсоноор Эрүүгийн хуулийн нөлөөллийн аргаар хууль сахиулагчдын амь биед шууд чиглэсэн халдлагаас хамгаалах, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх давхар арга хэмжээг үр дүнтэйгээр хэрэгжүүлж байна. Үүний үр дүнд алба хаагчид нийтийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдлыг хамгаалах, гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааг амь нас нь эрх зүйн баталгаагаар хангагдсан гэх итгэлтэйгээр айх аюулгүй явуулах нөхцөл бүрдэж байна.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид хууль сахиулагчдын амь биед халдах гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагаа зөвхөн нэг зүйл ангиар зохицуулагдаж байна. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлийн 2.9 дэх хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хүлээлгэх хариуцлагын хэм хэмжээ нь ОХУ-ын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 105 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "б" пунктэд заасан гэмт хэргээс ялын санкциар ялгагддаг. Өөрөөр хэлбэл Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлийн 2.9 дэх хэсгийн санкци нь ОХУ-ын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 105 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "б" пунктэд заасан гэмт хэргийн санкциас урт хугацаагаар хорих ялаар шийтгэдэг бол ОХУ-ын Эрүүгийн хуулийн энэ хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд ялын дээд хэмжээ болох цаазаар авах ялаар шийтгэхээр зааснаараа ялгарч байна. Адил тал нь гэвэл эдгээр хоёр зүйл ангид бүх насаар нь хорих ялын төрөл багтаж байна.


Үүнээс үзэхэд хууль сахиулагчдын амь биед халдах гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ОХУ-ын Эрүүгийн хуулийн тусгай ангийн (317, 105 дугаар

зүйлийн 2 дахь хэсгийн “б” пункт) ерөнхий болон тусгай хоёр зүйл ангиар төлөөлүүлэн, үйлдсэн онц хүнд гэмт хэрэгт оноох ял шийтгэлийн хатуу бодлогыг хэрэгжүүлж байна<sup>8</sup>. Харин энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хүлээлгэх хариуцлагын хувьд Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн хүмүүжүүлэх нөлөөллийн бодлогын хэрэгжилт хангалтгүй гэж дүгнэхээр байна.

Монгол Улсын Цагдаагийн байгууллагын алба хаагчид нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдлыг хамгаалах өдөр тутмын үйл ажиллагаа явуулахдаа тэдгээрийн амь бие, эрүүл мэндэд заналхийлсэн олон халдлагад өртөж байна. Тухайлбал 2013 оноос эхлээд цагдаагийн алба хаагчийн хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх, цаашлаад эрхэлж буй үйл ажиллагаатай нь холбогдуулан амь биед нь халдах гэмт хэргийн гаралт нэмэгджээ. Түүнчлэн Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.9-д зааснаар 2013 онд 1, 2014 онд 1, 2015 онд 0, 2016 онд 1, 2017 онд 1 гэмт хэрэг бүртгэгдсэн (ОХУ болон Монгол Улсын цагдаагийн нийт алба хаагчдын тоог харьцуулбал энэ нь тийм ч бага тоо биш юм) байна<sup>9</sup>.

ОХУ-ын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 317 дугаар зүйлд заасан гэмт хэргийн статистик үзүүлэлтийг авч үзвэл 2013 онд 364, 2014 онд 223, 2015 онд 181, 2016 онд 165, 2017 онд 121 гэмт хэрэг бүртгэгдсэн байна. ОХУ-ын хууль тогтоогчдын зүгээс энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх онол, арга зүйн үр ашигтай арга хэмжээ авч, зөв шийдлийг олсон явдал нь гэмт хэргийг бууруулах үндэс болсон гэж үзэж болно.

График 1. 2013-2017 онуудад ОХУ-ын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 317 дугаар зүйлд зааснаар үйлдэгдсэн гэмт хэргийн тоон үзүүлэлт



8 Сидоров Б. В., Бабичев А. Г. Дифференциация уголовной ответственности за убийство при отягчающих обстоятельствах и вопросы совершенствования уголовного законодательства // Вестник экономики, права и социологии, 2012, № 4, С. 186.

9 Монгол Улсын Цагдаагийн ерөнхий газрын дотоод сүлжээ (URL: [system.police.gov](http://system.police.gov)).

Монгол Улсын хувьд тодорхой хэмжээгээр Эрүүгийн хуулиар хамгаалах ёстой эрх зүйн харилцааны дутагдалтай байдлаас шалтгаалж, хууль сахиулагчдын амь биед халдах гэмт хэргийн гаралт ихсэх, цаашлаад нийгэмд хэвийн үзэгдэл болж тогтох аюултай байна. Тиймээс Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжийг сайжруулах, гадаадын өндөр хөгжилтэй орнуудын туршлага, тэр дундаа Ром-Германы эрх зүйн системийг шинжлэх ухаанчаар хэрэгжүүлж ирсэн баялаг туршлагатай ОХУ-ын Эрүүгийн хуулийн ололттой талуудыг нэвтрүүлэх хэрэгцээ, шаардлага тулгарч байна.

Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 3 дугаар зүйлд “Хүн бүр амьд явах эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх эрхтэй”, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Хүн бүр амьд явах салшгүй эрхтэй. Энэ эрхийг хуулиар хамгаална. Хэний ч амь насыг дур мэдэн бусниулж болохгүй” гэж тус тус баталгаажуулжээ. Үүнээс үзэхэд олон улсын гэрээгээр хүний амьд явах эрхийг хуулиар хамгаалахыг шаарддаг ба хүний амь насыг хүчээр авахыг хориглодог байна.

Тулгамдсан асуудлыг нээн, илрүүлэх зорилгоор цагдаагийн байгууллагын 200 алба хаагчдаас социологи судалгааг явуулахад дараах үр дүн гарч байна. Тухайлбал Монгол Улсын Эрүүгийн хуульд шинээр “Хууль сахиулагчийн амь биед халдах” гэсэн тусгай бүрэлдэхүүнтэй зүйл ангийг нэмж тусган, энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хариуцлага тооцох эсэх талаар санал, асуулга явуулахад нийт оролцогчдын 90.5 хувь буюу 181 алба хаагч энэхүү саналыг дэмжсэн бол 4 хувь буюу 8 алба хаагч татгалзаж, 5.5 хувь буюу 11 алба хаагч тодорхой хариулт өгөөгүй юм<sup>10</sup>. Үүнээс үзэхэд гэмт хэрэгтэй тэмцэх хүнд бөгөөд амаргүй үүрэг хүлээж, эрсдэл, аюулын тэргүүн эгнээнд байдаг хууль сахиулагчдын амь насыг Монгол Улсын Эрүүгийн хуулийн бодлогоор хамгаалах асуудлыг хууль тогтоогчдын зүгээс даруй хийж, гүйцэтгэх нь нэн чухал болоод байна.

## V. Дүгнэлт, санал

Хууль сахиулагчдын амь биед халдах гэмт хэрэгтэй Эрүүгийн хуулийн нөлөөллийн аргаар хийх тэмцэлд Монгол Улсын Эрүүгийн хуулийг бодвол ОХУ-ын Эрүүгийн хууль, тогтоомж харьцангуй үр дүнтэй хамгааллын тогтолцоог бүрдүүлжээ. Энэ нь ОХУ-ын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 317 дугаар зүйл (Хууль сахиулагчдын амь биед халдах)-д зааснаас гадна Эрүүгийн хуулийн тусгай ангийн 105 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “б” пунктэд “Эрхэлж байгаа ажил, албан үүрэгтэй холбогдуулан өөрийг нь, түүний ойр дотны хүнийг санаатай алах” гэмт хэрэгт хариуцлага тооцох эрх зүйн орчин бүрдүүлсэнтэй шууд холбоотой гэж үзэж байна.

ОХУ-ын Эрүүгийн хуульд хууль сахиулагчийн амь биед халдах гэмт хэргийн нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүйн объектив шинжийг 317

10

Всего было опрошено 200 сотрудников ППС органа полиции Монголии в 2016–2017 г.



дугаар зүйлийн диспозицод шууд тусгаж, энэ төрлийн гэмт хэргийн хэлбэрийн бүрэлдэхүүнийг тодотгож, завдалтаар гэмт хэрэг төгссөнд тооцсон үзэл санааг Монгол Улсын Эрүүгийн хуульд нэвтрүүлснээр хууль сахиулагчдыг хамгаалах эрх зүйн орчин сайжирна гэсэн дүгнэлтэд хүрч байна.

Хууль сахиулагчдын амь биед халдах гэмт хэрэгтэй эрчимтэй тэмцэж, чиг үүргийн алба хаагчид гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдлыг хамгаалах үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх явцдаа гадны ямар нэгэн халдлагаас бүрэн хамгаалагдсан эрх зүйн орчинг бүрдүүлэх зорилгоор Монгол Улсын Эрүүгийн хуульд шинээр нийтийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдлыг хамгаалах үүрэгтэй холбогдуулан хууль сахиулагчдын амь биед халдах гэмт хэрэгт оногдуулах тусгай бүрэлдэхүүнтэй зүйл ангийг нэмэлтээр оруулах саналтай байна.

## **VI. Ном зүй:**

### **Монгол эх сурвалж:**

1. *Монгол Улсын Эрүүгийн хууль, (2015).*
2. *Монгол Улсын Дээд шүүхийн тайлбарын эмхэтгэл, УБ, 2001 он.*

### **Орос эх сурвалж:**

1. Ансель М. *Методологические проблемы сравнительного права // Очерки сравнительного права: сб. М, 1981, С. 38.*
2. Саруханян А. Р. *Указ. соч. С. 47.*
3. Сидоров Б. В., Бабичев А. Г. *Дифференциация уголовной ответственности за убийство при отягчающих обстоятельствах и вопросы совершенствования уголовного законодательства // Вестник экономики, права и социологии. 2012, № 4, С. 186.*
4. Скутин С. Л. *Проблемы уголовно-правовой борьбы с преступными посягательствами на жизнь, здоровье и достоинство работников милиции, охраняющих общественный порядок: дис. ... канд. юрид. наук, М, 1995, С. 88.*



5. Уголовный кодекс Российской Федерации, М, 2016, С. 229.
6. Щербаков А. В. Преступления против порядка управления: научно-практический комментарий к главе 32 УК РФ. М, 2011, С. 58.

### **3. Бусад эх сурвалж:**

1. Цагдаагийн Ерөнхий Газрын дотоод сүлжээ (URL: [system.police.gov](http://system.police.gov)).
2. Цагдаагийн Ерөнхий Газрын Эргүүл хамгаалалтын газрын 200 алба хаагчдын дунд явуулсан анкет, 2017 он.
3. URL: [http://www.consultant.ru/document/cons\\_doc\\_LAW\\_6425/](http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_6425/)
4. Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал, (1948).
5. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, (1966).
6. НҮБ-ын Хүний эрхийн Дээд Комиссарын Газар, “Хүний эрх ба хууль сахиулах нь” Цагдаагийн ажилтнуудад зориулсан хүний эрхийн сургалтын гарын авлага, УБ, 2005 он.

UIN.MN  
СУДАЛГААНЫ САН



**С.ГАНТУЛГА**

Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн дэд профессор, доктор, дэд профессор, цагдаагийн дэд хурандаа



**Б.ЭНХБОЛД**

Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн эрхлэгч, доктор, дэд профессор, цагдаагийн хошууч

## БАГА НАСНЫ ХҮҮХДИЙГ АЛАХ БОЛОН ХҮЧИНДЭХ ГЭМТ ХЭРГИЙН ШАЛТГААН НӨХЦӨЛ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АСУУДАЛ<sup>1</sup>

### CAUSES OF CRIMES OF MURDER AND RAPE AGAINST CHILDREN AND ISSUE OF PREVENTION

**Товч агуулга:** Энэхүү нийтлэлээрээ бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэргийн нөхцөл байдал, ялын бодлого, түүний өөрчлөлтийн байдалд дүн шинжилгээ хийж, энэ төрлийн гэмт хэргийн шалтгаан нөхцөл, түүнээс урьдчилан сэргийлэх арга замын талаар санал зөвлөмж боловсруулсан.

**Түлхүүр үгс:** Хүүхэд, бага насны хүүхэд, гэмт хэрэг, шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх ажиллагаа.

**Abstract:** This article analyzes the situation of murder and rape against children, the concept of punishment and its changes, and develops recommendations on the causes, conditions and ways to prevent this type of crime.

**Keywords:** 0-14 years old child, children, crime, causes, situation, prevention.

1

Энэхүү судалгааг Нээлттэй нийгэм форумын захиалгаар гүйцэтгэсэн болно.


## I. Удиртгал

Хүүхдийн эрхийг хамгаалах олон улсын байгууллага болох “Хүүхдийг ивээх сан”-гаас жил бүр эрхлэн гаргадаг “Хүүхдийн эрх чөлөөний төлөв байдал” судалгаагаар 2018 онд Монгол Улс 100,000 хүн амд 1.4 хүүхдийн амь нас хохирсон үзүүлэлтээр 176 орноос 76-д оржээ<sup>2</sup>. Уг судалгаагаар гэмт хэргийн улмаас хүүхдийн амь нас хохирч буй нөхцөл байдалд үндэслэн тухайн улс дахь хүүхдийн аюулгүй байдлын түвшинг тодорхойлдог.

Иймд бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хүнд шүүхээс оногдуулсан ялын төрөл, хэмжээнд дүн шинжилгээ хийх, энэ төрлийн гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг тодорхойлж эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал, зөвлөмж боловсруулах шаардлагатай байна.

## II. Хүнийг алах гэмт хэргийн нөхцөл байдал, ялын бодлогын өөрчлөлт

График №1. Хүнийг алах гэмт хэргийн түвшин (2020-2009), хүний тоогоор



Сүүлийн 10 жилд<sup>3</sup> дунджаар 212, сард 18 гэмт хэрэг цагдаагийн байгууллагад бүртгэгджээ<sup>4</sup>. Үүнээс 2018 онд хүнийг алах гэмт хэрэг улсын хэмжээнд 192 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 3 хэргээр буюу 1.6 хувиар өсч, нийслэлийн хэмжээнд 8 хэргээр буюу 6.8 хувиар буурч, орон нутгийн хэмжээнд 11 хэргээр буюу 15.5 хувиар өссөн байна.

<sup>2</sup> Global childhood report 2019-Savethechildren.org/us/about-us/resource-library/annual-report

<sup>3</sup> 2009-2018 оны байдлаар.

<sup>4</sup> Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал-2018. ЦЕГ-ын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба, УБ, 2019 он, 169 дэх тал.

Хүнийг алах гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйсийн байдал

2019 онд хүнийг алах гэмт хэрэгт 201 хүн холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5 буюу 2.6 хувиар өсчээ. Холбогдогчдын 22 буюу 11 хувь нь эмэгтэй, 179 буюу 89 хувь нь эрэгтэй, тэдний 1 буюу 0.5 хувь нь 14-17 насны хүүхэд байна. Энэ нь өмнөх оны мөн үеийнхээс эрэгтэй 4.7 хувиар өсч, эмэгтэй 12, хүүхэд 85.7 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

График №2.




График №3.



Хүнийг алах гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчдын статистик үзүүлэлт

2019 онд хүнийг алах гэмт хэргийн улмаас 196 хүн хохирч, үүнээс 168 нь нас барж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад нас барсан хүний тоо 1 буюу 0.6 хувиар буурсан байна.

Хүснэгт №1. Хүнийг алах гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчид

№	Үзүүлэлт	Он				Өсөлт, бууралт <sup>5</sup>		Хугацаа		Өсөлт, бууралт	
		2015	2016	2017	2018	Тоо	Хувь	2019 оны эхний 8 сар	2020 оны эхний 8 сар	Тоо	Хувь
1	Хүнийг алах гэмт хэрэг	204	174	189	192	3	1.6	128	135	7	5.4
2	Хүнийг алах гэмт хэргийн хохирогч	214	184	191	196	5	2.6	131	137	6	4.5

№	Үзүүлэлт	Он				Өсөлт, бууралт <sup>5</sup>		Хугацаа		Өсөлт, бууралт		
		2015	2016	2017	2018	Тоо	Хувь	2019 оны эхний 8 сар	2020 оны эхний 8 сар	Тоо	Хувь	
3	Хүнийг алах гэмт хэрэг хохирсон хүүхэд	7	2	8	3	-5	-62.5	1	3	2	200	
4	Үүнээс хохирогч хүүхдийн тоо /0-17 нас/	9	2	9	3	-6	-66.7	1	3	2	200	
5	Үүнээс	0-7 нас	5	1	7	3	-4	-57.1	-	-	-	-
6		8-13 нас	2	-	1	-	-1	-100.0	-	1	1	100
7		14-17 нас	2	1	1	-	-1	-100.0	1	2	1	100

Эх сурвалж: ЦЕГ-ын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба

Сүүлийн 4 жилд хүнийг алах гэмт хэргийн халдлагад 785 хүн өртөж, хохирогчдын 92 хувь нь нас барсан. Хүнийг алах гэмт хэрэг болон энэ төрлийн гэмт хэргийн хохирогчдын тоо сүүлийн 3 жил тогтвортой өсөж, хохирогчдын олонх энэ төрлийн гэмт хэргийн улмаас нас барж, эрүүл мэндэд нь хүнд хохирол учирчээ. Энэ гэмт хэргийн улмаас учирсан хор уршгийг арилгах, нөхөн төлүүлэх боломжгүй буюу хүний амьд явах эрх зөрчигддөг тул нийгмийн хор аюул ихтэй гэмт хэрэгт тооцогддог. Энэ ч үүднээс дэлхийн улс бүр Эрүүгийн хуульдаа хүнийг алах үйлдлийг гэмт хэрэгт тооцож, энэхүү гэмт үйлдэлтэй ялын хатуу чанга бодлогоор тэмцдэг.

Сүүлийн жилүүдэд хүнийг алах гэмт хэргийн улмаас хүүхэд, тэр дундаа бага насны хүүхэд хохирох явдал буурахгүй байна. Тухайлбал 2015 онд 7 гэмт хэрэгт 9 хүүхэд, 2016 онд 2 гэмт хэрэгт 2 хүүхэд, 2017 онд 8 гэмт хэрэгт 9 хүүхэд, 2018 онд 3 гэмт хэрэгт 3 хүүхэд, 2019 онд 1 гэмт хэрэгт 1 хүүхэд, 2020 оны 8 дугаар сарын байдлаар 3 хэрэгт 3 хүүхэд тус тус хохирчээ. Үүнээс 2015 онд 7, 2016 онд 1, 2017 онд 8, 2018 онд 3, 2020 оны 8 сарын байдлаар 1 бага насны хүүхэд хохирч, нас барсан байна.

Гэмт этгээдүүд ихэвчлэн бага насны хүүхдийг биеэ хамгаалж чадахгүй, бага насны хүүхэд гэдгийг мэдсээр байж, өөр гэмт хэргийг нуун далдлах зорилгоор гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж амь насыг нь хөнөөжээ.

Гэмт этгээдүүдийн дийлэнх нь хохирогчтой гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүн байгаа бөгөөд удаан хугацаанд гэр бүлийн хүчирхийлэлд байлган, тарчлаасны эцэст амь насыг хөнөөсөн нь анхаарал татаж байна.

Мөн хүчиндэх болон бусад төрлийн гэмт хэрэг үйлдсэн этгээд үйлдсэн гэмт хэргээ нуун далдлах, гэмт хэргийн ул мөрөө баллах зорилгоор хохирогч бага насны хүүхдийг алсан тохиолдол цөөнгүй бүртгэгджээ. Тухайлбал Шүүгдэгч П.Т 2009 оны 8 дугаар сарын 26-27-ны өдөр шилжих шөнө ... аймгийн ... сумын ... дугаар багийн нутаг ... гэх газар 13 настай Ц.М-ийг биеэ хамгаалах чадваргүй байдлыг далимдуулан заазуур болон гараараа зодож, толгой, нүүр, гар, хөлд нь олон тооны шарх, цус хуралт үүсгэж, онц харгис хэрцгий аргаар өвтгөн шаналгаж, зовоон тарчлааж хүчиндсэн, хүчиндэх гэмт хэргээ нуун далдлах зорилгоор хохирогчийг нуурын усанд живүүлж алсан<sup>6</sup>.

### Учирсан хохирол

Хүнийг алах гэмт хэргийн улмаас иргэнд учирсан 948,1 сая төгрөгийн хохирлын 78.3 хувийг нөхөн төлүүлж, 533,1 сая төгрөгийн хөрөнгийг битүүмжилжээ. Энэ төрлийн гэмт хэргийн улмаас учирсан хохиролд хохирогчийн оршуулга, эмчилгээ, өмгөөллийн зардал, хохирогчийн хууль ёсны төлөөлөгчийн унааны зардал зэрэг материаллаг зардлыг шүүхээс нотлох баримтыг үндэслэн шүүгдэгчээс гаргуулахаар шийдвэрлэж байна.

Шүүхээс хянан шийдвэрлэсэн гэмт хэргээс үзэхэд хохирогчийн хууль ёсны төлөөлөгчид шүүгдэгчээс сэтгэл санааны хохиролд 5-100 сая төгрөгийг нэхэмжилсэн боловч шүүхээс нэхэмжлэлийн шаардлагыг хангалгүйгээр, гэм хорын хохирлыг иргэний журмаар шүүхэд хандан шийдвэрлүүлэх эрхтэй болохыг шийтгэх тогтоолдоо дурдсан байна.

Хүснэгт №2. Хүнийг алах гэмт хэргийн ялын бодлогын өөрчлөлт

2002 оны Эрүүгийн хууль				2015 оны Эрүүгийн хууль (шинэчилсэн найруулга)				Ялын бодлогын өөрчлөлт	
Зүйл, хэсэг	Гэмт хэргийн ангилал	Ялын доод хэмжээ	Ялын дээд хэмжээ	Зүйл, хэсэг	Гэмт хэргийн ангилал	Ялын доод хэмжээ	Ялын дээд хэмжээ	Ялын доод хэмжээ	Ялын дээд хэмжээ
91.1	Онц хүнд гэмт хэрэг	10 жил хорих ял	15 жил хорих ял	10.1 (1)	Хүнд гэмт хэрэг	8 жил хорих ял	15 жил хорих ял	-2	Үгүй
91.2	Онц хүнд гэмт хэрэг	15 жил хорих ял	25 жил хорих ял, цаазаар авах ял	10.1 (2)	Хүнд гэмт хэрэг	12 жил хорих ял	20 жил хорих ял, бүх насаар хорих	-3	-5 Цаазаар авах ялыг хасаж, бүх насаар хорих ял нэмсэн.

6

Булган аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2010 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 84 дүгээр шийтгэх тогтоол.

Хүнийг алах гэмт хэрэг үйлдсэн хүнд оногдуулах хорих ялын доод хэмжээг 2 жилээр багасгасан, хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар үйлдсэн тохиолдолд оногдуулах хорих ялын доод хэмжээг 3 жилээр, дээд хэмжээг 5 жилээр тус тус багасгаж, Монгол Улс Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт II протоколд нэгдэн орсонтой<sup>7</sup> холбоотойгоор цаазаар авах ялыг халж, энэ онцгой ялын оронд нь бүх насаар хорих ялаар өөрчилж хуульчилсан. Ингэж хорих ялын хэмжээг урьд байгаагүйгээр зөөлрүүлсэн нь гэмт хэргийг тогтоон барихад ялын хатуу чанга нь бодлого бус, харин гарцаагүй байх нь чухал бөгөөд шийтгэлгүй өнгөрөх болов уу гэсэн найдлага дагуулсан хатуу ялаар шийтгэгдэх айдсаас хөнгөн боловч гарцаагүй шийтгүүлнэ гэсэн мэдрэмж илүү нөлөөтэй гэсэн онол, олон улсын хандлагад нийцүүлсэн явдал юм<sup>8</sup>.

Практикт гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектив талын шинжийг тогтооход ихээхэн бэрхшээл тулгардаг. Гэмт хэрэг үйлдсэн хүний субъектив талд төдийлөн анхаарал хандуулалгүйгээр гэмт үйлдэл, эс үйлдэхүй түүний улмаас учирсан хор уршигт анхаарах болсон олон улсын жишгийг харгалзан 2002 оны Эрүүгийн хуульд хүнийг танхайн, өс хонзонгийн сэдлээр алсан бол хүндрүүлэх бүрэлдэхүүнд заасан байсныг 2015 оны шинэ Эрүүгийн хуулиас хасчээ. Мөн хүнийг алах гэмт хэргийг онц аюултай гэмт хэрэгтэн үйлдсэн, давтан үйлдсэн бол хүндрүүлж үзэхээр заасныг хассан бол гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж, эрүүдэн шүүж, бага насны хүүхдийг алсан болон зохион байгуулалттай гэмт бүлгийн гишүүн зохион байгуулалттай гэмт үйл ажиллагааныхаа явцад эсхүл үзэл бодол, арьсны өнгө, үндэс угсаа, шашин шүтлэг, бэлгийн болон хүйсийн чиг баримжаагаар нь үзэн ядаж алсан бол тус тус хүндрүүлэх бүрэлдэхүүн болгож, шинээр хуульчилсан.


Судалгаанаас үзэхэд хүүхэд ялангуяа биеэ хамгаалж чадахгүй бага насны хүүхэд хүнийг алах гэмт хэргийн халдлагад өртөх явдал түгээмэл байна. Хүнийг алах гэмт хэргийн хохирогч хүүхдийг насны байдлаар нь авч үзвэл 1-10 насны хүүхэд дийлэнх хувийг эзэлж байна. Бага насны хүүхдийг алсан тохиолдлыг хүндрүүлэх бүрэлдэхүүнд хуульчилсан явдал нь цаг үеэ олсон хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад чиглэгдсэн чухал алхам болсон гэж үзэж болохоор байгаа юм.

7 Монгол Улс 2012 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар соёрхон баталсан.

8 С.Гантулга, Б.Энхболд, "Эрүүгийн хуулийн эмгэгийг эмчлэх нь", Үндэсний шуудан сонины 2017 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн №008 (2705), 14 дэх тал.

### III. Хүчиндэх гэмт хэргийн нөхцөл байдал, ялын бодлогын өөрчлөлт

График №4. Хүчиндэх гэмт хэргийн түвшин (2020-2009), хүний тоогоор



Сүүлийн 10 жилд дунджаар 345, сард 29, хоногт 1 гэмт хэрэг цагдаагийн байгууллагад бүртгэгджээ<sup>9</sup>. Үүнээс 2019 онд хүчиндэх гэмт хэрэг улсын хэмжээнд 481 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 38 хэргээр буюу 7.3 хувиар буурчээ. Нийслэлийн хэмжээнд 55 хэргээр буюу 20.4 хувиар буурсан, орон нутгийн хэмжээнд 18 хэргээр буюу 7.2 хувиар өсчээ.

#### Хүчиндэх гэмт хэрэгт холбогдсон хүмүүсийн нас, хүйсийн байдал

2019 онд 338 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 34 буюу 11.2 хувиар өссөн үзүүлэлт юм. Холбогдогчдын 3 буюу 0.9 хувь нь эмэгтэй, 335 буюу 99.1 хувь нь эрэгтэй, тэдний 24 буюу 7.1 хувь нь 14-17 насны хүүхэд байна. Энэ нь өмнөх оны мөн үеийнхээс хэрэгт холбогдсон эрэгтэй 10.9 хувиар, эмэгтэй 50.5 хувиар тус тус өсч, хүүхэд 20 хувиар буурчээ.

#### Хүчиндэх гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал




График №5.

График №6.

9 Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал-2018. ЦЕГ-ын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба, УБ, 2019 он, 176 дахь тал.



## Хүчиндэх гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчдын тоон үзүүлэлт

2019 онд энэ төрлийн гэмт хэргийн улмаас 487 хүн хохирсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад хохирсон хүн 119 буюу 32.3 хувиар өсчээ. Үүнээс 2 хүн нас барж, 89 хүний эрүүл мэндэд хохирол учирсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад нас барсан хүний тоо 1 буюу 2 дахин өсч, эрүүл мэндэд хохирол учирсан хүний тоо өмнөх оны мөн үеийн түвшинд байна<sup>10</sup>.

Хүснэгт №3. Хүчиндэх гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчид

№	Үзүүлэлт	Хугацаа				Өсөлт, бууралт <sup>10</sup>		Хугацаа		Өсөлт, бууралт		
		2015 он	2016 он	2017 он	2018 он	Тоо	Хувь	2019 оны эхний 8 сар	2020 оны эхний 8 сар	Тоо	Хувь	
1	Хүчиндэх гэмт хэрэг	279	290	376	519	143	38.0	385	285	100	-26.4	
2	Хүчиндэх гэмт хэргийн хохирогч	287	295	368	487	119	32.3	386	290	96	-24.8	
3	Хүчиндэх гэмт хэрэгт хохирсон хүүхэд	134	140	183	235	52	28.4	134	153	19	14.1	
4	Үүнээс хохирогч хүүхдийн тоо /17-0 нас/	139	143	187	238	51	27.3	137	160	23	16.7	
5	Үүнээс	0-7 нас	7	18	20	20	0	0.0	6	9	3	50.0
6		8-13 нас	47	45	59	91	32	54.2	26	39	13	50.0
7		14-17 нас	85	80	108	127	19	17.6	45	64	19	42.2

Эх сурвалж: ЦЕГ-ын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба

Хүчиндэх гэмт хэрэг нь хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдалд халдаж, улмаар хүний амьд явах эрх, эрүүл амьдрахын халдашгүй байдалд ихээхэн хохирол, хор уршиг учруулдаг нийгэмд аюултай гэмт хэрэг юм. Сүүлийн 4 жилд хүчиндэх гэмт хэргийн гаралт нэмэгдэж, энэ төрлийн гэмт хэргийн улмаас 1,437 хүн хохирчээ. Ялангуяа хохирогчдын тоо сүүлийн 3 жилд огцом өсчээ. Үүний дотор энэ төрлийн гэмт хэргийн улмаас хүүхэд, тэр дундаа бага насны хүүхэд хохирох явдал буурахгүй байна. Тухайлбал 2015 онд 134 гэмт

<sup>10</sup> Сүүлийн 2 жилийн байдлаар

хэрэгт 139, 2016 онд 140 гэмт хэрэгт 143, 2017 онд 183 гэмт хэрэгт 187, 2018 онд 235 гэмт хэрэгт 238, 2019 онд 134 гэмт хэрэгт 137, 2020 оны эхний 8 сарын байдлаар 153 гэмт хэрэгт 160 хүүхэд тус тус хохирчээ. Үүнээс 2015 онд 54, 2016 онд 63, 2017 онд 79, 2018 онд 111, 2019 онд 32, 2020 оны эхний 8 сарын байдлаар 48 бага насны хүүхэд хохирсон байна.

Гэмт этгээдүүд ихэвчлэн гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай, бага насны хүүхдийг биеэ хамгаалах, эсэргүүцэл үзүүлэх чадваргүй байгааг далимдуулан хүч хэрэглэн заналхийлэх аргаар хүчинддэг байна. Эцэг эхдээ болон бусдад хэлбэл ална, эрүүл мэндэд нь хохирол учруулна хэмээн заналхийлж, бага насны хүүхдийг хүчиндсэн байх бөгөөд хохирогч айж эмээсний улмаас гэмт этгээдийн үйлдлийг нууж өнгөрдөг нь дахин хүчиндүүлэх, цаашид удаан хугацаанд энэ гэмт хэргийн халдлагад өртөх нөхцөлийг бүрдүүлдэг байна.

Бага насны хүүхдийг хүчиндэж, улмаар жирэмсэн болгосон, бэлгийн замын халдварт өвчин халдаасан, хохирогчийг тохуурхан доромжилж үйлдсэн тохиолдол цөөнгүй хувийг эзэлж байна. Тухайлбал судалсан хэргийн дийлэнх хувийг хохирогч хүчиндүүлсний улмаас жирэмсэн болсноор гэмт хэрэг илэрсэн байх бөгөөд хэрэв хохирогч жирэмсэн болоогүй бол тэр хэрэг илрэхгүй байх магадлал өндөр байна.

Бага насны хүүхдийг хүчиндсэний улмаас хохирогч жирэмсэлсэн тохиолдолд бүгд (100 хувь) үр хөндүүлсэн байгаа нь хохирогчийн цаашдын эрүүл мэнд, бие бялдар, оюун санааны хөгжилд асар хортой байгаа талаар мэргэжлийн эмч нар хэлдэг билээ. Мөн хохирогчийг хүчиндэж, бэлгийн замын халдварт өвчин халдаасан тохиолдолд бага насны хүүхдийн эрүүл мэндэд ихээхэн хохиролтой бөгөөд хохирогч хүчиндүүлсний улмаас сэтгэцийн өвчтэй болсон, амиа хорлосон, амиа хорлохоор завдсан, хүчиндүүлснээс хойш бусадтай замбараагүй бэлгийн харьцаанд орох явдал түгээмэл байна. Тухайлбал насанд хүрээгүй хохирогч Ц.Б-г хойд эцэг С.С нь 2016 оны 3 дугаар сарын 7-ны өдрөөс 2016 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийг хүртэлх хугацаанд удаа дараа хүчиндсэн. Хохирогч шүүхийн хэлэлцүүлэгт өгсөн мэдүүлэгтээ "... намайг харж хамгаалах ёстой хүн С.С-д хүчиндүүлсэндээ гутарч, сэтгэл санаагаар унасандаа асрамжийн газрын галч А.С, харуул К.Х нартай бэлгийн харьцаанд орсон" гэжээ<sup>11</sup>.

### Учирсан хохирол

Хүчиндэх гэмт хэргийн улмаас иргэнд учирсан 482,6 сая төгрөгийн хохирлын 66.1 хувийг нөхөн төлүүлж, 65,9 сая төгрөгийн хөрөнгийг битүүмжилжээ.

11

Увс аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 28 дугаар шийтгэх тогтоол.

Хүснэгт №4. Хүчиндэх гэмт хэргийн ялын бодлогын өөрчлөлт

2002 оны Эрүүгийн хууль				2015 оны Эрүүгийн хууль (шинэчилсэн найруулга)				Ялын бодлогын өөрчлөлт	
Зүйл, хэсэг	Гэмт хэргийн ангилал	Ялын доод хэмжээ	Ялын дээд хэмжээ	Зүйл, хэсэг	Гэмт хэргийн ангилал	Ялын доод хэмжээ	Ялын дээд хэмжээ	Ялын доод хэмжээ	Ялын дээд хэмжээ
126.1	Хүндэвтэр гэмт хэрэг	1 жил хорих ял	5 жил хорих ял	12.1 (1)	Хөнгөн гэмт хэрэг	1 жил хорих ял	5 жил хорих ял	Үгүй	Үгүй
126.2	Хүнд гэмт хэрэг	5 жил хорих ял	10 жил хорих ял	12.1 (2)	Хүнд гэмт хэрэг	5 жил хорих ял	12 жил хорих ял	Үгүй	2
				12.1 (3)	Хүнд гэмт хэрэг	8 жил хорих ял	15 жил хорих ял	3	5
126.3	Онц хүнд гэмт хэрэг	15 жил хорих ял	25 жил хорих ял, цаазаар авах ял	12.1 (4)	Хүнд гэмт хэрэг	12 жил хорих ял	20 жил хорих ял, бүх насаар хорих	-3	-5 Цаазаар авах ялыг хасч, бүх насаар хорих ял нэмсэн.

Хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хүнд оногдуулах хорих ялын доод, дээд хэмжээг өөрчлөөгүй, хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар үйлдсэн этгээдэд оногдуулах хорих ялын доод хэмжээг 3 жилээр, дээд хэмжээг 5 жилээр тус тус нэмэгдүүлсэн, хугацаатай хорих ялын хэмжээ багассантай холбоотойгоор онц хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар энэ гэмт хэргийг үйлдсэн хүнд оногдуулах хорих ялын доод хэмжээг 3 жилээр, дээд хэмжээг 5 жилээр тус тус багасгаж, цаазаар авах ялыг халж, харин үүний оронд бүх насаар хорих ялыг хуульчилсан.

Дээрх нэмэлт өөрчлөлтөөс дүгнэхэд хүчиндэх гэмт хэрэгт оногдуулах хорих ялын дээд хэмжээг бууруулж, цаазаар авах ялыг халсан нь 2002 оны Эрүүгийн хуулийн ялын бодлогыг зөөлрүүлэх, нөгөө талаас Монгол Улс Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт II протоколд нэгдэн орсонтой<sup>12</sup> холбоотой.

Олон нийтийн сүлжээгээр 2015 оны Эрүүгийн хуульд хүүхэд хүчиндсэн хүнийг 2 сая төгрөгөөр торгох ял шийтгэхээр хуульчилсан гэсэн мэдээлэл түгээгдсэн. Энэ нь худал мэдээлэл бөгөөд хүчиндэх гэмт хэрэгт оногдуулах

<sup>12</sup> 2012 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар соёрхон баталсан.

ялын бодлого төдийлөн зөөлрөөгүй, гэмт этгээдэд ял завших боломж огт олгоогүйн зэрэгцээ хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлыг өргөн хүрээнд хамгаалж, олон улсын жишгийг харгалзан энэ гэмт хэргийн объектив талын шинжийг тодорхойлж, үйлдлийн аргыг дэлгэрэнгүй байдлаар хуульчилсан. Тухайлбал хүчиндэх гэмт хэргийн объектив талын шинжийг хүчээр бэлгийн харьцаанд орсон, бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийсэн гэж тодорхойлж, хохирогчийн хүсэл зоригийн эсрэг, хуульд заасан арга хэрэглэж, хохирогчийн биеийн аль нэг хэсэгт бэлэг эрхтнээ оруулсан; хохирогчийн бэлэг эрхтэнд өөрийн бусад эрхтэн, эсхүл өөр зүйл оруулсан<sup>13</sup> үйлдлийг хүчиндэх гэмт хэрэгт тооцсон.

Бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл нь бэлгийн харьцаанд орох үйлдэлтэй адил хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдалд халддаг, нийгмийн хор аюул нь их үйлдэл учраас хүчиндэх гэмт хэрэгт тооцсон нь хүний эрхийг хангахад чухал алхам болсон гэж үзэж байна. Эмэгтэй хүний бэлэг эрхтэнд хуруу, бусад зүйлийг хийсэн, ам, шулуун гэдсэнд бэлэг эрхтнээ оруулсан зэрэг хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдалд бүдүүлгээр халддаг үйлдлийг 2002 оны Эрүүгийн хуулиар бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргээр зүйлчилж, хөнгөн ял оногдуулдаг байсан бол шинэ Эрүүгийн хуулиар хүчиндэх гэмт хэрэгт тооцож байна.

Мөн 2015 оны Эрүүгийн хуульд хүчиндэх гэмт хэргийн хохирогч нь бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдал зөрчигдсэн аль ч хүйсийн хүн байж болно<sup>14</sup> гэж хүйсийн ялгаваргүйгээр хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлыг Эрүүгийн хуулиар хамгаалсан нь ихээхэн ач холбогдолтой юм. Шинэ Эрүүгийн хууль хэрэгжиж эхлэхээс өмнө эрэгтэй хүн (эрэгтэй хүүхэд)-ийг шулуун гэдсээр хүчиндсэн тохиолдолд бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргээр зүйлчилж, гэмт этгээдэд хөнгөн ял оногдуулж, ял завшуулж байсан билээ.

Судалгаанаас үзэхэд хүүхэд ялангуяа биеэ хамгаалж чадахгүй бага насны хүүхэд хүчиндэх гэмт хэргийн халдлагад өртөх явдал түгээмэл ажиглагдав. Хүчиндэх гэмт хэргийн хохирогч болсон хүүхдийг насны байдлаар нь авч үзвэл 4-10 насныхан дийлэнх хувийг эзэлж байна. Бага насны хүүхэд хүчиндсэн бол Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан арга хэрэглэсэн, хохирогчийн хүсэл зоригийн эсрэг үйлдсэн зэрэг субъектив талын шинжийг хангасан байхыг шаардахгүй<sup>15</sup>. Өөрөөр хэлбэл гэмт хэрэг үйлдсэн хүн бага насны хүүхэдтэй бэлгийн харьцаанд орсон, бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийсэн объектив талын шинжээр нь зүйлчилж, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нь өмнөх хуультай харьцуулахад илүү нарийвчилсан, ялын бодлогын хувьд чангарсан зохицуулалт юм.

13 Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлийн тайлбар.

14 Мөн тэнд.

15 Мөн тэнд.


Энэ төрлийн гэмт хэргийг хүндрүүлэх нөхцөл байдалгүйгээр үйлдсэн тохиолдолд 2002 оны Эрүүгийн хуулиар хүндэвтэр, 2015 оны Эрүүгийн хуулиар хөнгөн ангиллын гэмт хэрэгт хамаарах тул шүүхээс хуульд заасан болзол, шалгуурыг хангасан тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх боломжтой. Практикт түгээмэл үйлдэгдэж буй байдлыг харгалзан гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг хүчиндсэн, хохирогчийг жирэмсэн болгосон, хохирогчид бэлгийн замын халдварт өвчин халдаасан, хоёр ба түүнээс олон хүнийг хүчиндсэн бол тус тус хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй болгож шинээр хуульчилсан байна.

2015 оны Эрүүгийн хуульд хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогыг чангатгасны нэг илрэл бол урьд нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12 дугаар бүлэгт заасан гэмт хэргийг үйлдэж, гэм буруутайд тооцогдож байсан хүн үйлдсэн тохиолдолд хүндрүүлэхээр хуульчилсан явдал юм. Хүчиндэх, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах, бэлгийн мөлжлөг, 16 насанд хүрээгүй хүнтэй хурьцал үйлдэхээс бусад гэмт хэргийг давтан үйлдсэн тохиолдолд зүйлчлэлээр хүндрүүлж байгаа нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх зүйн байдлыг дордуулахгүй болно.

#### **IV. Бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэргийн шалтгаан нөхцөл**

Судалгааны үр дүнгээс үзэхэд, бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

- Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийн 98.5 хувийг эрэгтэй, бага насны хүүхдийг алах гэмт хэргийн 55 хувийг эрэгтэй, 45 хувийг эмэгтэй хүн үйлдсэн байна. Мөн бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хүний 50.0 хувь, бага насны хүүхдийг алах гэмт хэрэг үйлдсэн хүний 62.5 хувийг 19-30 насны хүн эзэлж байгаа бол 51-74 насны хүмүүс бага насны хүүхдийг хүчиндсэн тохиолдолд 6 орчим хувь байна. Харин бага насны хүүхдийг 51-ээс дээш насныхан алсан тохиолдол бүртгэгдээгүй байна.
- Судалгаанаас үзэхэд, бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хүний 90 орчим хувь нь бүрэн дундаас доош, 60 хувь нь бүрэн бус дундаас доош боловсролтой, 85 орчим хувь нь тодорхой эрхэлсэн ажилгүй, 70 орчим хувь нь орон нутагт төрж өссөн, 19 орчим хувь нь урьд нь ял шийтгэгдэж байсан этгээд байна.
- Хорих ял биечлэн эдэлсэн этгээд зан байдлын хувьд засарч хүмүүжээгүй байхад хугацаанаас нь өмнө тэнсэн сулласан, шүүхийн



шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан, өршөөгдсөн үед цагдаагийн байгууллага хяналт сул тавьсан нь энэ төрлийн гэмт хэргийн шалтгаан нөхцөл болсон тохиолдол цөөнгүй байна.

- Бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэргийн хохирогчдын 90 орчим хувь нь сургууль, цэцэрлэгт хамрагддаг, сэтгэц, бие махбодын хувьд эрүүл, хүчиндэх гэмт хэргийн хувьд 13-14 насны хүүхэд халдлагад өртсөн тохиолдол 47 хувь, хүүхдийг алах гэмт хэргийн хувьд 8-10 насны хүүхэд хохирсон тохиолдол 37.5 хувь, энэ төрлийн гэмт хэргийн хохирогчдын хамгийн бага нь 1 настай хүүхэд байна. Мөн бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийн хохирогчдын 97.1 хувь эмэгтэй хүүхэд байхад хүүхдийг алах гэмт хэргийн хувьд 65 хувь мөн эмэгтэй хүүхэд байгаа нь анхаарал татаж байна.
- Бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэрэг нь гэр бүлийн хүрээнд ялангуяа хохирогч өөрийн амьдардаг гэртээ болон төрөл садангийн хүний гэрт халдлагад өртөж байгаа нь хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх хангагдахгүй байгааг илтгэж байна. Тухайлбал бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийн 38.2 хувь, хүүхдийг алах гэмт хэргийн 40 хувь нь хүүхэд өөрийн амьдардаг гэртээ халдлагад өртсөн бол бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийн 30.9 хувь, бага насны хүүхдийг алах гэмт хэргийн 27.5 хувь нь хамаатан садан, эцэг, эхийн найзын гэрт халдлагад өртжээ.
- Гэр бүл салалт, гэр бүлийн тогтворгүй байдал, хүүхдэд тавих хараа хяналт сул байдал, гэр бүлийн хүчирхийлэл, ахуйн хүрээний архидалт, гэр бүлээс гадуурх бэлгийн харьцаа зэрэг нь бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэрэг үйлдэгдэх үндсэн шалтгаан болж байна. Судалгаанаас үзэхэд өөрийн төрсөн хүүхдээ хүчиндсэн тохиолдол 2.9 хувь, төрсөн хүүхдээ алсан тохиолдол 42.5 хувийг тус тус эзэлж байна. Харин дагавар хүүхдээ хүчиндсэн тохиолдол 19.1 хувь, төрөл, садангийн хүний хүүхдийг хүчиндсэн тохиолдол 17.6 хувийг эзэлж байгаа бол дагавар хүүхдээ алсан тохиолдол 15 хувь, төрөл, садангийн хүний хүүхдийг алсан тохиолдол 12.5 хувийг тус тус эзэлж байна. Тухайлбал гэр бүл салж, хоёр дахь амьдрал зохиож байгаагаас дагавар хүүхдээ үзэн ядаж, удаан хугацаанд зодсоноос хүүхдийг алсан тохиолдол 25 хувь, өөрийн төрсөн хүүхэд биш гэсэн шалтгаанаар бага насны хүүхдийг хүчиндсэн тохиолдолд 40.2 хувийг эзэлж байна. Эцэг эх нь салсан, эцэг эхийн аль нэг нь өөр хүнтэй гэр бүл болсон гэсэн шалтгаанаар эмээ, өвөөгийн гэрт байхдаа бусад хүмүүст хүчиндүүлсэн тохиолдол 27.9 хувийг тус тус эзэлж байна.
- Гэр бүлийн хүрээнд үйлдэгдсэн бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг нуугдмал шинжтэй байгаа нь гэмт хэрэг давтан үйлдэгдэх, удаан хугацаанд үргэлжлэх шалтгаан нөхцөл болж байна. Судалгаанаас

үзэхэд гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүн, эсхүл төрөл, садангийн хүний халдлагад өртсөн бага насны хохирогч тэр даруй бусдад мэдэгдсэн тохиолдол 16 буюу 23.5 хувьтай байгаа анхаарал татаж байна. Хохирогч жирэмсэн болсон, эсхүл бэлгийн замын халдварт өвчний шинж тэмдэг илэрсэн, үйлдэл дээрээ баригдсанаас бусад тохиолдолд хохирогч цагдаагийн байгууллагад мэдэгдээгүй байна. Удаан хугацаанд нуун далдалсан шалтгаан нь 40.4 дарамтад өртсөн, 20.3 хувь хууртагдсан, 17 хувь гэр бүлийн гишүүдээсээ санаа зовсон (ээж, дүү), 19.1 хувь бэлгийн харьцааны учир холбогдлыг ойлгоогүй зэрэг байна. Харин үл таних хүнд хүчиндүүлсэн тохиолдолд хохирогч ойролцоо байгаа хүн болон өөрийн эцэг, эх ойр дотны хүндээ шууд мэдэгддэг байна.

- Бага насны хүүхдийг алах гэмт хэргийн хувьд хохирогчийн буруутай үйл ажиллагаа бараг тогтоогдоогүй, харин гэнэн итгэмтгий зангаасаа болж гэмт хэрэгт хохирсон тохиолдол цөөнгүй байна. Тухайлбал “Ухаан алдахаар гоё мэдрэмж төрдөг” гэсэн үгэнд хууртаж, өөрийгөө боолгуулсан байна. Харин хүчиндэх гэмт хэргийн хувьд хохирогч согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн, мөнгө шаардлагатай болсон, зочид буудал, гэмт хэрэг үйлдсэн хүний ажлын байранд очсон, тээврийн хэрэгслээр зугаалсан, ажил, хөдөлмөр эрхлэх нэрээр садар самуун явдалд орж биеэ үнэлсэн, бусдаас тусламж хүсэх боломж байсаар байтал тусламж аваагүй зэрэг нь хохирогч болоход нөлөөлсөн байх боломжтой байна. Эдгээр нөхцөл байдлын цаана гэр бүлийн таагүй орчин, эцэг, эхийн хараа хяналт сул, гэр бүл салалт, гэр бүлийн хүчирхийлэл байгааг анхаарах нь зүйтэй. Судалгаанаас үзэхэд 12 настай охин ажил хийж байгаа нэрээр гэртээ нэг сар орчим ирээгүй байхад эцэг, эх нь эрж хайгаагүй, мөн хойд эцэгтээ хүчиндүүлсэн охин нэгэнт хүчиндүүлсэн гэсэн шалтгаанаар бусад хүнтэй төлбөртэй бэлгийн харьцаанд орсон тохиолдол байна.
- Бага насны хүүхдийг биеэ хамгаалж чадахгүй гэдгийг нь мэдсээр байж зодох, боох, шидэх зэрэг аргаар алсан тохиолдол дийлэнх хувийг эзэлж байна. Бага насны хүүхдийг алах гэмт хэргийг үйлдсэн хүн өмнө үйлдсэн гэмт хэргийг бага насны хүүхэд харсан тохиолдолд гэмт хэргээ нуун далдлах, хялбарчлах зорилгоор тухайн бага насны хүүхдийг алсан тохиолдол 25 хувь, хүүхдийн хийсэн үйлдэлд зэвүүцэх, үзэн ядах, үгэнд орсонгүй гэсэн үл ялих зүйлээр шалтаглаж алсан тохиолдол 35 хувь, тэжээн тэтгэхээс зайлсхийх сэдэл, зорилготой 20 хувь байгаа нь анхаарал татаж байна. Хүчиндэх гэмт хэргийн хувьд бэлгийн харьцааны учир холбогдлыг ойлгохгүй байгааг далимдуулж, хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, согтууруулах ундааны зүйл хэрэглүүлж, биеэ хамгаалах чадваргүй байдлыг далимдуулах, хууран мэхлэх зэрэг аргаар ихэвчлэн үйлдэгдсэн байна.

- Хүчиндэх гэмт хэргийн улмаас бага насны хохирогч болон түүний ойр дотны хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, сэтгэл санаанд ихээхэн хохирол учирч байна. Тухайлбал хохирогч нас барсан, амиа хорлосон, сэтгэцийн эмгэгтэй болсон, жирэмсэн болсон, ураг хөндүүлсэн, бэлгийн замын халдварт өвчтэй болсон, сургууль завсардсан, гэр бүлээсээ дайжсан, гэр бүл салсан, биеэ үнэлэх болсон, бэлгийн замбараагүй харьцаанд орж эхэлсэн зэрэг сөрөг үр дагавар бий болжээ.
- Хүчиндэх гэмт хэргийн хохирогч 10-14 насны хүүхдийн хувьд сэтгэл зүйн хувьд бүрэн төлөвшөөгүй, өөрийн гэсэн үзэл бодол тогтоогүй байдаг учир сониуч зан, адал явдалд дурлах, итгэмтгий байх, хөөрч сагсуурах, шинэ нөхцөл байдалд дасах чадавхгүй байх, хайр халамж дутагдах, зарим тохиолдолд биеийн хөгжлийн онцлог зэрэг нь хохирох эрсдэлийг нэмэгдүүлж байна.

## V. Санал, зөвлөмж

Бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг тогтоох, урьдчилан сэргийлэх чиглэлээр:

- Хүүхдийн эсрэг хүчирхийлэлд өртөх эрсдэлийн судалгааг жил бүр хийж, хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх бодлого боловсруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөхдөө судалгааны үр дүнг ашиглах;
- Хүүхдийн эрхийг хамгаалахтай холбогдсон хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах, хэрэгжилтийн байдалд хяналт, шинжилгээ үнэлгээ хийх;
- Хүүхэд гэмт хэрэгт хохирох, ялангуяа хүнийг алах болон хүчиндэх гэмт хэргийн нийт гэмт хэрэгт эзлэх хувийн жинг бууруулах чиглэлээр эрх зүй, зохион байгуулалтын шинжтэй арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх;
- Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах, гэр бүлийн харилцаа, гэр бүл төлөвлөлт, эцэг, эхийн хариуцлага, үлгэр дуурайлал, түүний эерэг, сөрөг үр дагаврын талаарх иргэдийн мэдлэгийг нэмэгдүүлэх сургалт, зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах;
- Хууль зүй, дотоод хэргийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Батлан хамгаалах яам хамтран гэр бүл төлөвлөлт, гэр бүлийн гишүүдийн үүрэг хариуцлага, гэр бүл салалтаас үүсэх үр дагаврын талаар сургалтын хөтөлбөр боловсруулж ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчид, их, дээд



сургуулийн оюутан, хугацаат цэргийн алба хаагч нарт сургалт явуулах ажлыг тогтмолжуулах;

- Хүүхдийн эрхийн хороо, хүүхдийн эрхийн улсын байцаагчийн үйл ажиллагааг хүүхэд хамгаалал, гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хүүхдийг илрүүлэх, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, шаардлагатай тусламж, үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулахад чиглүүлэх, ажлын үр дүнг тооцож, ажиллах;
- Садар самуун явдал, биеэ үнэлэх, хардалт, эцэг эхээ үл тоомсорлох зэрэг хүүхдийн сэтгэхүй, хүмүүжилд сөргөөр нөлөөлөх агуулга бүхий насанд хүрэгчдэд зориулсан телевизийн нэвтрүүлэг, кино, ярилцлага, цэнгээт үзүүлбэрийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийтийн сүлжээгээр тараахгүй байхад анхаарах, бага насны хүүхэд интернэт орчинд чөлөөтэй нэвтрэх нь зохистой эсэх, хязгаарлалт тогтоох боломж нөхцөлийн талаар судлах;
- Бага насны хүүхэд хүчирхийлэлд өртсөн тохиолдолд эрх бүхий байгууллага, сурган хүмүүжүүлэгч, нийгмийн ажилтан, гэр бүлийн гишүүдэд цаг алдалгүй хандах талаар хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон аргаар мэдээлэл хүргэх;
- Энэ төрлийн гэмт хэргийг түгээмэл үйлдэж буй 19-25 насны бүрэн дундаас доош боловсролтой, эрхэлсэн тодорхой ажилгүй, ял шийтгэл эдэлж байсан, тэнсэгдсэн, ял хойшлогдсон, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж шийтгэгдсэн этгээдүүдэд тавих хяналтыг сайжруулах, гэмт хэргийн хор уршиг, эрүүгийн хариуцлагын талаарх болон зан үйлд нөлөөлөх сургалтыг олон талт хэлбэрээр зохион байгуулах;
- Энэ төрлийн гэмт хэрэг үйлдэж, хорих ял эдэлж суллагдсан хүнд тавих хяналтыг сайжруулах, нийгэмд дасан зохицоход нь дэмжлэг үзүүлэх;
- Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг эрүүл мэндийн үзлэг, хүүхдийн хөгжлийн ерөнхий байдлын судалгаанд тогтмол хамруулах;

УИИМН  
СУДАЛГААНЫ САН

## Ном зүй

1. "Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном-2017", УБ, 2018 он.
2. *Global childhood report 2019-Savethechildren.org/us/about-us/resource-library/annual-report*
3. Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал-2017, ЦЕГ-ын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба, УБ, 2018 он.
4. Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал-2018, ЦЕГ-ын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба, УБ, 2019 он.

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН



**Л.ГАЛБААТАР**

Хуульч, судлаач

## ИНТЕРНЭТИЙН ХАНДАЛТЫГ ХЯЗГААРЛАХ, НИЙГМИЙН СҮЛЖЭЭГЭЭР ТАРХИ УГААХ, ХУВИЙН ӨГӨГДЛИЙГ ЗАДРУУЛАХААС ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАХ НЬ

## PROTECTING HUMAN RIGHTS FROM INTERNET SHUTDOWN, SOCIAL MEDIA MANIPULATION AND DATA BREACHES

**Товч утга:** Хүний эрхийн олон улсын эрх зүйн суурь гэрээний нэг болох Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад хүний үндсэн эрхийг цахим орчинд нэгэн адил эдлэх баталгааг заасан байдаг. Гэвч Засгийн газрууд, том компаниуд интернэтийн хандалтыг хязгаарлах, нийгмийн сүлжээгээр тархи угаах, хувь хүний өгөгдлийг задруулах зэргээр цахим орчинд хүний эрхийг нэлээд зөрчиж байна. Энэхүү нийтлэлээрээ интернэтийн хандалтын хязгаарлалт, нийгмийн сүлжээний тархи угаалт, төр болон хувь хүмүүсийн өгөгдөл алдагдах зэрэг цахим гэмт хэргийн хохирогчийн талаарх тоо баримтыг судлан, дээрх асуудлын эсрэг авч хэрэгжүүлж болох арга замыг тодорхойлохыг зорилгоо.

**Түлхүүр үгс:** Интернэтийн хандалтыг хязгаарлах, нийгмийн сүлжээ, өгөгдөл задруулах, мэдэх эрх.

**Abstract:** *International human rights instruments such as the International Covenant on Civil and Political Rights guaranteed fundamental digital rights in cyberspace. However, many governments and large companies have violated human rights in cyberspace by an Internet shutdown, social media manipulation, and data breaches. This paper aims to examine victims of cyberspace, numbers of Internet shutdowns, social media manipulation and data breaches of governments and individuals and tries to identify ways to implement measures against an Internet shutdown, social media manipulation and data breaches.*

**Keywords:** *Internet shutdown, social media, data breaches, right to know.*

## I. Цахим орчин дахь хүний эрхийн зөрчил

2018 оны 7 дугаар сарын 4-ний өдөр НҮБ-ын Хүний эрхийн хорооноос “Хүний эрхийн баталгаа цахим орчинд ч нэгэн адил үйлчлэх ёстой” гэдгийг санал нэгтгэйгээр хүлээн зөвшөөрсөн байдаг<sup>1</sup>. Түүнчлэн НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс “цахим орчинд дур зоргоороо, хууль бусаар хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах явдлаас сэргийлэх, интернэт дэх хувийн өгөгдөл болон хувийн нууцын хамгаалалтыг хүлээн зөвшөөрөх, хууль тогтоомжийг батлах, боловсронгуй болгох зэргээр шаардлагатай арга хэмжээ авах”-ыг гишүүн орнууддаа уриалжээ.

### 1.1. Интернэтийн хандалтыг хязгаарлах

Интернэтийн хандалтыг хязгаарлах гэдэг нь аль нэг нутаг дэвсгэр доторх эсвэл тодорхой бүлгийг давтамжтайгаар хянан мэдээлэлд хандах, ашиглах бололцоогүй болгох, эсвэл цахим орчин, цахим харилцааг санаатайгаар бусниулах явдал юм. Төрийн зүгээс интернэтийн хандалтыг хязгаарлахдаа Фэйсбүүк, Ютүб, SMS, Твитэр зэрэг мэдээллийн хэрэгслүүдийг хааж, сүлжээг бусниулдаг. Технологийн компаниуд хуульд заасны дагуу төрийн шийдвэрийг зайлшгүй дагаж мөрдөх шаардлагатай байдаг нь ийм хязгаарлалт нэмэгдэх нэг шалтгаан юм<sup>2</sup>. 2016-2019 оны хооронд интернэтийн хандалтад хязгаарлалт тогтоосон улсуудын тоо нэг жилд дунджаар 25-аас доошгүй болж, интернэтийг хязгаарлах давтамж нэмэгдсэн байна<sup>3</sup>.

1 Human Rights Council. “The promotion, protection and enjoyment of human rights on the Internet”. A/HRC/38/L.10/Rev.1. 04/07/2018.

<https://documents-dds-ny.un.org/doc/UNDOC/LTD/G18/203/73/PDF/G1820373.pdf?OpenElement>

2 Access Now. *Fighting Internet Shutdowns Around the World*

<https://www.accessnow.org/cms/assets/uploads/2018/06/KeepItOn-Digital-Pamphlet.pdf>

3 Access Now. *The State of Internet Shutdowns Around the World: The 2018 #KeepItOn Report*

<https://www.accessnow.org/cms/assets/uploads/2019/07/KeepItOn-2018-Report.pdf>

Access Now. *Targeted, cut off, and left in the dark: how internet shutdowns became an even greater threat to human rights in 2019.*

<https://www.accessnow.org/keepiton-2019-review/>

Access Now. *Official justifications vs. actual causes of internet shutdowns in 2018.*

Хүснэгт 1. Интернэтийн хандалтыг хязгаарласан тоо

Он	Улсуудын тоо	Интернэтийн хандалтыг хязгаарласан тоо
2016	41	75
2017	30	108
2018	25	196
2019	33	2019

Төрөөс ихэвчлэн үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах, худал мэдээлэл, үзэн ядах үг хэллэгтэй тэмцэх зэргээр шалтаглан интернэтийн хандалтыг хязгаарлаж байна. Гэвч бодит байдал дээр төрөөс дэвшүүлж буй дээрх үндэслэлүүд нь интернэтийн хандалтад хязгаарлалт тогтоох гол шалтгаан биш юм. 2018 онд интернэтийн хандалтыг хязгаарлах үед төрөөс хүч хэрэглэсэн хамгийн багадаа 33 тохиолдол ил болжээ. Мөн төрөөс буюу хууль сахиулах байгууллагаас иргэддээ хүчирхийлэл үйлдэхийн тулд интернэтийн хандалтыг хязгаарласан хэд хэдэн тохиолдол гарчээ. Тухайлбал Судан Улсад “интернэтийн хандалтыг хязгаарлах” үндэслэлийн дор Засгийн эрх баригчид сөрөг хүчнийхнийг дарамталсан байна<sup>4</sup>. 2019 оны байдлаар 33 оронд 213 удаа интернэтийн хандалтыг хязгаарлаж, 1706 хоногийн турш интернэт холболтгүй байжээ<sup>5</sup>.

Хүснэгт 2. Интернэтийн хандалтыг хязгаарлах хамгийн түгээмэл шалтгаан

Засгийн газраас баримталдаг түгээмэл шалтгаан	Бодит шалтгаан
Олон нийтийн аюулгүй байдлыг хангах	Эсэргүүцлийг зогсоох
	Нийгмийн бүлгийн эсрэг чиглэсэн хүчирхийлэл үйлдэх
Үндэсний аюулгүй байдлыг хангах	Улс төрийн тогтворгүй байдлыг намжаах
	Мэдээллийг хянах
Хуурамч мэдээ/Үзэн ядах үг хэллэгтэй тэмцэх	Нийгмийн бүлгийн эсрэг чиглэсэн хүчирхийлэл үйлдэх
	Сонгуулийг хянах
	Эсэргүүцлийг зогсоох
	Улс төрийн тогтворгүй байдлыг намжаах

4 Access Now. *Official justifications vs. actual causes of internet shutdowns in 2018.*  
<https://www.accessnow.org/the-state-of-internet-shutdowns-in-2018/>

5 Access Now. *Targeted, Cut off, and Left in the Dark-The #KeptOn report on internet shutdowns in 2019.*  
<https://www.accessnow.org/keepiton/>

2019 оны байдлаар интернэтийн хандалтыг хязгаарласан улс орнуудын хүн амын тоо 3,082,764.82 мянга, өөрөөр хэлбэл дэлхийн хүн амын 40 хувийг эзэлж байна<sup>6</sup>.

Хүснэгт 3. 2019 оны интернэтийн хандалтын хязгаарлалт, улс орны тоогоор

Улс	Интернэтийн хандалтийг хязгаарласан тоо	Хүн амын тоо (мянга)
Энэтхэг	134	1,352,617.33
Пакистан	12	212,215.03
Йемен	7	28,498.69
Ирак	7	38,433.60
Этиоп	6	109,224.56
Бангладеш	5	161,356.04
Конго	3	84,068.09
Орос	2	144,478.05
Чад	2	15,477.75
Мали	2	19,077.69
Филиппин	2	106,651.92
Камерун	1	25,216.24
Индонез	1	267,663.43
Алжир	1	42,228.43
Нигер	1	195,874.74
Казахстан	1	18,276.50
Кот-Д'ивуар	1	25,069.23
Никарагуа	1	6,465.51
Сьерра-Лион	1	7,650.15
Өмнөд Солонгос	1	51,635.26
Шри Ланка	1	21,670.00
Того	1	7,889.09
Сири	1	16,906.28
Судан	1	41,801.53
Турк	1	82,319.72

<sup>6</sup> The World Bank. Population, total. <https://data.worldbank.org/indicator/SP.POP.TOTL>

Дэлхий даяар интернэтийн хандалтыг хязгаарлах нь мэдээлэл олж авах, үзэл бодлоо чөлөөтэй эрх чөлөөтэй илэрхийлэхэд заналхийлж байна. Энэ нь сэтгүүл зүй, бизнес эрхлэгчид, хүний эрхийг хамгаалагчид, жагсагчид төдийгүй түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлэх баг зэрэг бүх этгээдийг хохироодог. Цаашлаад интернэтийн хандалтын хязгаарлалт нь дэлхий даяар эрчимтэй нэмэгдсээр байна. Үүний улмаас мэдээлэл олж авах, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх явдлыг шууд зөрчиж, хүний эрхийн олон ноцтой зөрчлийг өөгшүүлэх үр дагавартай юм. Судалгаанаас үзэхэд ихэвчлэн төрийн дарамт шахалтыг эрчимжүүлэх<sup>7</sup>, жагсаал цуглааныг саармагжуулахад интернэтийн хандалтын хязгаарлалтыг хэрэглэж байна<sup>8</sup>.

## 1.2. Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн тархи угаалт

Ардчилал өндөр хөгжсөн орнуудад иргэдийг үнэн, бодит мэдээллээр хангах, мөн түүнчлэн иргэд хоорондын хамтран ажиллах, мэдээлэл солилцох зэрэг үйл ажиллагааг дэмждэг. Нөгөөтэйгүүр олонхи улс оронд олон нийтийн мэдээллийн хэрэгслийг санаатайгаар суртал ухуулга тараахад ашигласан баримт илэрчээ. Тухайн улс бүрт ямар нэг улс төрийн нам, эсвэл улс төрийн бүлэглэл нь дотоод дахь нийгмийн сүлжээг ашиглан олон нийтийн хандлагыг тандаж байна. Түүнчлэн 26 оронд мэдээллийг хянан суртал ухуулга хийх гол арга хэрэгсэл нь компьютер болжээ<sup>9</sup>.

Хүснэгт 4. Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр суртал ухуулга хийж буй улс орнуудын тоо, 2019-2017 он

Он	Улс орны тоо
2017	28
2018	48
2019	70

## 1.3. Хувийн өгөгдөл задруулах

Зөвхөн 2018 оны эхний хагаст гэхэд л хувийн өгөгдлийг задруулснаас үүдэн 4.5 тэрбум баримт материал задарсан байна. 2019 онд 774 сая и-мэйл хаяг болон 21 сая нууц үг бүхий 2.7 тэрбум нууцлалын мэдээллийг

7 Rahman, A & Shaban, A. (2019). Unexplained internet blackout in Ethiopia's Oromia region | Africanews. <https://www.africanews.com/2018/03/21/unexplained-internet-blackout-in-ethiopia-s-romia-region/>

8 Rydzak, J. "Of Blackouts and Bandhs: The Strategy and Structure of Disconnected Protest in India." SSRN: <https://ssrn.com/abstract=3330413>

9 Samantha Bradshaw, Philip N. Howard. The Global Disinformation Order: 2019 Global Inventory of Organised Social Media Manipulation. 2019. <https://comprop.oii.ox.ac.uk/wp-content/uploads/sites/93/2019/09/CyberTroop-Report19.pdf>

интернэтэд худалдахаар байршуулжээ<sup>10</sup>. АНУ-ын Холбооны худалдааны комисс 2019 оны 7 дугаар сарын 24-ны өдөр өөрийн төв байрандаа хэвлэлийн бага хурал зохион байгуулж, хэрэглэгчдийн хувийн нууц болон хувийн мэдээллийг задруулсан хэргээр Фэйсбүүк компанид урьд өмнө байгаагүй өндөр буюу 5 тэрбум долларын торгууль оногдуулсан. Энэ үйл явдлаас үүдэн тус компани хэрэглэгчдийн хувийн мэдээлэлд хариуцлага хүлээхээс сэргийлсэн шинэ бүтэцтэй болжээ<sup>11</sup>.

Хүснэгт 5. Хувийн өгөгдлийг алдсан компаниуд

Компанийн нэр	Зохицуулах байгууллага	Мэдээлсэн он	Торгуулийн хэмжээ	Зөрчлийн төрөл	Хэрэглэгчдийн хаягийн тоо
Facebook	FTC	2019	\$5 тэрбум	Өгөгдөл алдагдах	2.4 тэрбум
Google / Youtube	FTC	2019	\$170 сая	Өгөгдөл алдагдах	1,3 тэрбум
Equifax	FTC	2019	\$700 сая	Өгөгдөл алдагдах	147 сая
British Airways	ICO	2018	183£ сая	Өгөгдөл алдагдах	185,000
Uber	State AGs	2018	\$148 сая	Өгөгдөл алдагдах	57 сая
Marriot	ICO	2019	\$124 сая	Өгөгдөл алдагдах	339 сая
Yahoo	SEC	2018	\$35 сая	Өгөгдөл алдагдах	500 сая

**II. Цахим орчинд мэдэх эрхийг хангах, ардчиллыг хамгаалах нь**

Тухайн улсад интернэт, нийгмийн сүлжээ хязгаарлагдсан үед хувь хүн онлайн хэвээр байх чадвар болон Засгийн газрын эерэг үйл ажиллагаа нь цахим орчинд хүний эрхийг хангах, ардчиллыг хамгаалахтай шууд хамааралтай байдаг. “Онлайн эрх чөлөө эвсэл”-ийн зүгээс засгийн газрын санхүүжилтээр сүлжээг тасалдуулах асуудлын тухайд мэдэгдэл гаргажээ<sup>12</sup>.

10 Song, Victoria. “Mother of All Breaches Exposes 773 Million Emails, 21 Million Passwords”. Gizmodo. Retrieved 2019-01-18. <https://gizmodo.com/mother-of-all-breaches-exposes-773-million-emails-21-m-1831833456>

11 FTC Imposes \$5 Billion Penalty and Sweeping New Privacy Restrictions on Facebook. July 24, 2019. [https://www.ftc.gov/news-events/press-releases/2019/07/ftc-imposes-5-billion-penalty-sweeping-new-privacy-restrictions?utm\\_source=govdelivery](https://www.ftc.gov/news-events/press-releases/2019/07/ftc-imposes-5-billion-penalty-sweeping-new-privacy-restrictions?utm_source=govdelivery)

12 The Freedom Online Coalition Joint Statement on State-Sponsored Network Disruptions, 2017. <https://www.freedomonlinecoalition.com/wp-content/uploads/2017/03/FOCJointStatementonStateSponsored-NetworkDisruptions.docx.pdf>



Мэдэгдэлд “Засгийн газрын санхүүжилтээр тодорхой газар нутаг дахь хүн амын интернэт болон мобайл сүлжээг таслах, ашиглах боломжгүй болгох, зориудаар тасалдуулах явдал нь үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, тайван замаар жагсаал цуглаан хийхэд саад хийх нэлээн түгээмэл арга болж байна. Энэ талаар санаа зовниж буй Засгийн газрууд үүнээс сэргийлэхэд чиглэсэн тохиромжтой бүх арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай” гэжээ.

Түүнчлэн сүлжээ тасрахаас сэргийлэхийн тулд хүн бүр доорх зүйлсийг мэдэх шаардлагатай байдаг<sup>13</sup>.

- Төөрөгдүүлэх хэрэгсэл буюу Proxy серверийг хэрэглэх талаар мэдлэгтэй болох шаардлагатай. Интернэтийн хязгаарлалтаас зайлсхийх, цахим орчинд нэрээ нууцлахад зориулсан маш олон төөрөгдүүлэх хэрэгсэл бий.
- Хувийн виртуал сүлжээний (VPN) аюулгүй байдлыг хангах шаардлагатай. Олон хүн цахим орчинд зайн компьютерээс аюулгүйгээр нэвтрэхийн тулд хувийн виртуал сүлжээг ашиглах хэрэгтэй.

### III. Дүгнэлт

Орчин үед хүний эрх нь интернэттэй шууд харилцан хамааралтай болжээ. Тиймээс Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад заасан хүний эрхийн хэм хэмжээ цахим орчинд ч нэгэнд адил хэрэгжих ёстойг НҮБ-аас баталгаажуулсан байна. Өнөөдөр дэлхий даяар олон сая хүмүүс интернэтийн хандалтыг хязгаарлах, нийгмийн сүлжээгээр дамжуулан тархи угаах, хувийн өгөгдлийг задруулах хэргийн бай болсоор байна. НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл, “Онлайн эрх чөлөөний эсвэл”, “Access Now” зэрэг бусад хамтрагч байгууллагуудаас интернэтийн хандалтыг хязгаарлах, нийгмийн сүлжээгээр дамжуулан тархи угаах, хувийн өгөгдлийг задруулах зэрэг асуудлыг шийдэх олон арга замыг дэвшүүлсэн байна. Хүний үндсэн эрхийг хамгаалсан хэм хэмжээг хэрэгжүүлэх нь цахим орчинд хүний эрхийг бататган, ардчиллыг хамгаалахтай улам бүр хамааралтай болж байгаад анхаарах шаардлагатай болжээ.

<sup>13</sup> Abdi Latif Dahir. *A guide to staying online if the internet or social media gets blocked in your country*, January 6, 2017.


<https://qz.com/africa/878823/a-guide-to-staying-online-if-the-internet-or-social-media-has-been-blocked-in-your-country/>

## Ном зүй

1. Abdi Latif Dahir, *A guide to staying online if the internet or social media gets blocked in your country*, January 6, 2017. <https://qz.com/africa/878823/a-guide-to-staying-online-if-the-internet-or-social-media-has-been-blocked-in-your-country/>
2. Access Now. *Fighting Internet Shutdowns Around the World*. <https://www.accessnow.org/cms/assets/uploads/2018/06/KeepItOn-Digital-Pamphlet.pdf>
3. Access Now. *Official justifications vs. actual causes of internet shutdowns in 2018*. <https://www.accessnow.org/the-state-of-internet-shutdowns-in-2018/>
4. Access Now. *Targeted, Cut off, and Left in the Dark-The #KeepItOn report on internet shutdowns in 2019*. <https://www.accessnow.org/keepiton/>
5. Access Now. *Targeted, cut off, and left in the dark: how internet shutdowns became an even greater threat to human rights in 2019*. <https://www.accessnow.org/keepiton-2019-review/>
6. Access Now. *The State of Internet Shutdowns Around the World: The 2018 #KeepItOn Report*. <https://www.accessnow.org/cms/assets/uploads/2019/07/KeepItOn-2018-Report.pdf>
7. *FTC Imposes \$5 Billion Penalty and Sweeping New Privacy Restrictions on Facebook*, July 24, 2019. [https://www.ftc.gov/news-events/press-releases/2019/07/ftc-imposes-5-billion-penalty-sweeping-new-privacy-restrictions?utm\\_source=govdelivery](https://www.ftc.gov/news-events/press-releases/2019/07/ftc-imposes-5-billion-penalty-sweeping-new-privacy-restrictions?utm_source=govdelivery)
8. Human Rights Council. *"The promotion, protection and enjoyment of human rights on the Internet"*, A/HRC/38/L.10/Rev.1. 04/07/2018. <https://documents-dds-ny.un.org/doc/UNDOC/LTD/G18/203/73/PDF/G1820373.pdf?OpenElement>
9. Rahman, A & Shaban, A. (2019). *Unexplained internet blackout in Ethiopia's Oromia region* | Africanews. Available at: <https://www.africanews.com/2018/03/21/unexplained-internet-blackout-in-ethiopia-s-oromia-region/>

10. Rydzak, J. "Of Blackouts and Bandhs: The Strategy and Structure of Disconnected Protest in India." Available at SSRN: <https://ssrn.com/abstract=3330413>
11. Samantha Bradshaw, Philip N. Howard. *The Global Disinformation Order: 2019 Global Inventory of Organised Social Media Manipulation*, 2019. <https://comprop.oii.ox.ac.uk/wp-content/uploads/sites/93/2019/09/CyberTroop-Report19.pdf>
12. Song, Victoria. "Mother of All Breaches Exposes 773 Million Emails, 21 Million Passwords". Gizmodo. Retrieved 2019-01-18. <https://gizmodo.com/mother-of-all-breaches-exposes-773-million-emails-21-m-1831833456>
13. *The Freedom Online Coalition Joint Statement on State-Sponsored Network Disruptions*, 2017. <https://www.freedomonlinecoalition.com/wp-content/ploads/2017/03/FOCJointStatementonStateSponsoredNetworkDisruptions.docx.pdf>
14. *The World Bank. Population, total.* <https://data.worldbank.org/indicator/SP.POP.TOTL>

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН



## Л.ЛХАГВАРАГЧАА

Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн  
Эрүүгийн процессын эрх зүйн тэнхимийн ахлах багш, доктор,  
цагдаагийн ахлах дэслэгч

## ХҮНИЙ ЭРХ БА ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

## HUMAN RIGHTS AND ROLES AND RESPONSIBILITIES OF THE POLICE

**Товч утга:** Хүний эрхийг хэрэгжүүлэх нь олон хүчин зүйлээс хамаарна. Үүний дотор тухайн улс орны төрийн болон хуулийн байгууллагын албан хаагч нарын (ялангуяа цагдаагийн байгууллагын) үүрэг чухал үүрэг гүйцэтгэдэг. Аль ч улсад цагдаагийн алба хаагчид хууль, дэг журмыг хэрэгжүүлэхэд хүний эрхэд халдах, хязгаарлах эрх эдэлж, үүрэг, хариуцлага хүлээдэг. Эрх мэдэл, чиг үүргийнхээ хажуугаар үйл ажиллагаагаараа ард иргэд, олон нийтийн өмнө хариуцлага хүлээх хэд хэдэн үүрэг хүлээдэг. Хүний эрхийг хамгаалах, ард иргэдийн аюулгүй байдлын хангахад цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаанд мөрдлөг болгодог олон улсын гэрээ, конвенц, үндэсний хууль тогтоомж болон цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны код, журмаас хамаарна. Цагдаагийн байгууллагын хувьд алба хаагчийн хандлага, ёс зүй, ёс суртахуунтай байдал нь хүний эрхийг хангахад маш чухал үүрэг гүйцэтгэдэг. Хүний эрхийг хүндэтгэх, сахин хамгаалах талаар цагдаагийн байгууллагын эрх мэдлийг онцлон дурдсан болно.

**Түлхүүр үгс:** Хүний эрх, цагдаагийн байгууллага, Цагдаагийн албаны тухай хууль.

**Abstract:** *The realisation of human rights depends on many factors. Among the various things, the role of Justice Administration officials of the state (especially Police) play vital role. In any country, police have enormous powers in the implementation of Law and Order. Along with powers and functions, they have a number of responsibilities, accountable to state, and public at large through their acts. Human Rights protection and their realisation too depend on the behavioural pattern of the police. As a law enforcing agency their attitude, ethical, and moral conduct is very important in the promotion of Human Rights. Being a vital agency between the state and public, this paper is a modest attempt to highlight the powers of the police in the protection and promotion of human rights.*

**Keywords:** *Human rights, National Police Commission, Model Police Manual.*

## I. Оршил

Хүн бүр төрөхөөсөө эрх чөлөөтэй, нэр төр, эрхийнхээ хувьд адил тэгш байна. Тэдэнд оюун ухаан, өрлөг сэтгэл заяасан бөгөөд өөр хоорондоо ахан дүүсийн ёсоор харилцах ёстой<sup>1</sup>. Хүний эрх бол хүний зэрэгтэй амьдрахад шаардагдах наад захын баталгаа бөгөөд хүн бүрт заяасан нэр төрөөс урган гардаг. Хууль сахиулах албан тушаалтнууд нь ямагт хүний эрхийг дээдэлж, хуульд захирагдан хуулиар хүлээлгэсэн үүрэг, хариуцлагын хүрээнд нийгэмд үйлчлэн гэмт хэрэг, зөрчлөөс иргэдийг хамгаалах үүрэгтэй. Үүний тулд хууль сахиулагч нь хүч, албадлага хэрэглэх онцгой эрхийнхээ хүрээнд хууль ёсны дагуу хүний эрхийг хязгаарлах шаардлагатай бөгөөд ингэхдээ хууль ёсны байх, зайлшгүй байх, ялгаварлан гадуурхахгүй байх, тэнцүү чанартай байх, хүмүүнлэг байх зэрэг зарчимд үндэслэн мэргэжлийн ёс зүйн дүрмийн хүрээнд хүн бүрийн эрхэм чанарыг хүндэтгэн, хүн бүрийн эрх, эрх чөлөөг сахин хамгаалах замаар хуулиар оноосон үүргээ биелүүлэх үүрэгтэй болно.

Ялангуяа хууль сахиулах албан хаагчид эрх бүхий албан тушаалтан болохын хувьд хуульд түүний дотор хүний эрхийг хамгаалахад чиглэсэн хуульд захирагдах үүрэгтэй юм. Иймээс хүний эрх, эрх чөлөөг хангаж, хамгаалах, хөхиүлэн дэмжих төрийн үүргийг хэрэгжүүлэхэд хууль сахиулах чиг үүрэг бүхий байгууллагуудаас ялангуяа цагдаагийн байгууллагын эрх хэмжээ, чиг үүрэг чухал үүрэг гүйцэтгэнэ.

Түүнчлэн цагдаагийн байгууллагын хувьд алба хаагчийн хандлага, ёс зүй, ёс суртахуунтай байдал нь хүний эрхийг хүндэтгэх, сахин хамгаалахад онцгой үүрэгтэй учраас тэд ёс зүйд нийцсэн, хууль ёсны зан үйлийн хүрээнд хуулийн хүндэтгэх, түүнд захирагдах, хүний эрхийг хүндэтгэх, сахин хамгаалах гэсэн зарчимд үндэслэн үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх шаардлагатай юм. Иймээс хүний эрхийг хүндэтгэх, сахин хамгаалах талаар

<sup>1</sup> Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 1 дүгээр зүйл.

цагдаагийн байгууллагын эрх мэдэл, үйл ажиллагааны онцлог, анхаарах асуудлыг тодорхойлохыг зорилоо.

## II. Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах үүрэг, хариуцлага

### Хууль сахиулагч гэж хэн бэ?

Олон улсын түвшинд ардчилсан нийгэм дэх хууль сахиулах албадын албан хаагчдын мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээ, зарчмыг тайлбарлаж тодорхойлсон дараах хэм хэмжээ мөрдөгдөж байна. Үүнд:

- НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 1979 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 34/169 дүгээр тогтоолоор баталсан Хууль сахиулах байгууллагын албан хаагчдын ёс зүйн дүрэм
- Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагаас<sup>2</sup> 1994 оны 12 дугаар сарын 3-ны өдөр баталсан Аюулгүй байдлын улс төр-цэргийн хүрээний ёс зүйн дүрэм

Эдгээр дүрэмд хууль сахиулагч нь хүн бүрийг хууль бус аливаа үйлдлээс хамгаалж, нийгэмдээ өндөр хариуцлагатай үйлчлэх тэдний үүргийг тодорхойлж, тайлбарлажээ. Түүнчлэн “Хууль хэрэгжүүлэх албан тушаалтан” гэдэгт цагдаагийн бүрэн эрх эдэлдэг, ялангуяа бусдыг баривчлах, хорьж саатуулах эрх бүхий томилдог болон сонгодог бүх албан тушаалтнууд хамаарна. Харин цагдаагийн бүрэн эрхийг дүрэмт болон иргэний цэргийн байгууллагын төлөөлөгчид болон аюулаас хамгаалах хүчнүүд эдэлдэг тийм орнуудад “хууль хэрэгжүүлэх албан тушаалтан” гэдэг ойлголтын тодорхойлолтод тэдгээр албадын ажилтнуудыг хамааруулна гэжээ.

Мөн “Хууль сахиулах байгууллагын албан хаагчдын ёс зүйн дүрэмд” хууль сахиулах байгууллагын ажилтнууд хүний эрх, эрх чөлөө болон хүн хэмээх эрхэм чанарыг хүндэтгэн сахиж хамгаалах үүрэгтэй болохыг онцолж, нэн шаардлагатай үед хэрэглэх хүчийг аль болох хязгаарлах, тодорхой асуудлуудын нууцлалыг хамгаалах, эрүү шүүлт, хэрцгий, хүнлэг бус харилцааг хориглох, саатуулагдсан этгээдүүдийн эрүүл мэндийг хамгаалж ажиллахыг тус тус зааснаар гадна авлигаас ангид ажиллахыг сануулж, хуулийн дагуу ажиллах тэдний үүргийг хуульчилсан байна<sup>3</sup>.

2 Монгол Улс 2012 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага (ЕАБХАБ)-ын гишүүн орноор элссэн билээ. ЕАБХАБ-д Европ, Хойд Европын бус нутгаас гадна Төв Азийн зарим орон багтдаг бөгөөд нийт 56 улс тус байгууллагын эгнээнд нэгтгэсэн дэлхийн бүс нутгийн энэхүү байгууллагад Монгол Улс 57 дахь бүрэн эрхт гишүүн нь болжээ.

3 НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 1979 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 34/169 дүгээр тогтоолоор баталсан Хууль сахиулах байгууллагын албан хаагчдын ёс зүйн дүрмийн 1 дүгээр зүйлд “Хууль сахиулах байгууллагын албан хаагчид ямагт ажил мэргэжлийн хариуцлагатай байдлаа чандлан сахиж, олон нийтэд үйлчлэн, нийт ард иргэдийг хууль бус үйлдлээс хамгаалах замаар хуулиар ногдуулсан өөрийн үүргийг гүйцэтгэнэ”, 2 дугаар зүйлд “Ажил үүргээ гүйцэтгэхдээ хууль сахиулах байгууллагын албан хаагчид нь аливаа хүний нэр төрийг хүндэлж, хамгаалахын зэрэгцээ хүний эрхийг дээдэлнэ” хэмээн тус тус заажээ.

## Хүний эрхийг хамгаалагч гэж хэн бэ?

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 53 дугаар чуулганы 85 дугаар нэгдсэн хуралдаанаас 1998 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн А/RES53/144 тогтоолоор баталсан Хүний эрхийг хамгаалагчдын тунхаглалд зааснаар хүний эрхийг хамгаалагчид нь орон нутгийн, үндэсний, бүсийн, олон улсын түвшинд “ганцаарчлан болон бусадтай эвсэж хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах, хэрэгжүүлэх явдлыг хөхиүлэн дэмжиж, үүний төлөө эрмэлзэж” ажилладаг<sup>4</sup> гэсэн байна. Үүнээс үзэхэд аливаа ялгаварлалгүйгээр бүх хүнд хамаатай хүний эрхийн түгээмэл чанарыг хүлээн зөвшөөрч, хүний эрхийг хангах, хамгаалах үүрэг хүлээсэн тусгай төрийн алба хаагч нарыг мөн ойлгож болно. Иймээс цагдаагийн алба хаагчид нь мэргэжлийн үйл ажиллагаагаараа хүний эрхийн хамгаалагчид юм.

Хүний эрхийн олон улсын суурь гэрээ, конвенцын хэрэгжилтийг бүрэн дүүрэн хангахын тулд тасралтгүй ахиц дэвшил гарган ажиллахад хүмүүс, бүлэг, байгууллага, институцүүдийн идэвхтэй оролцоо амин чухал билээ. Бусад байгууллагаас гадна, иргэний нийгэм нь хүний эрх, үндсэн эрх чөлөө, ардчилал, эрх зүйт ёс бүрэн хэрэгжих нөхцөлийг хангахад төрийг дэмжин ажилладаг. Үүний нэгэн адил хүний эрхийг хамгаалагчид ардчилсан нийгэмд чухал, хууль ёсны үүрэг гүйцэтгэдэг. Төрийн эрх бүхий байгууллагууд ардчилсан нийгэмд тайван замаар илэрхийлж байгаа шүүмжлэлт үзэл санааг дэмжих хэрэгтэй бөгөөд хүний эрхийг хамгаалагчдын хууль ёсны, чухал үүргийг олон нийтэд нээлттэйгээр хүлээн зөвшөөрөх хэрэгтэй.

Хүний эрхийг хамгаалагчид нь хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаа явуулсныхаа төлөө онцгой эрсдэлтэй учирч, ихэвчлэн ноцтой дарамт шахалтын бай болдог. Иймээс орон нутаг, үндэсний, олон улсын хэмжээнд тусгай, нэмэлт хамгаалалтаар хамгаалуулах, хуулиар онцгой эрх эдлэх шаардлагатай. Хүний эрхийг хамгаалагчдын тодорхой төрлийн үйл ажиллагааныхаа онцлог, анхаарч буй асуудал, газар зүйн байршил, үйл ажиллагаа явуулж буй нөхцөл байдал эсвэл нийгмийн тодорхой бүлэгт харьяалагддагаасаа шалтгаалаад илүү ноцтой эрсдэлтэй тулгардаг.

## Төрийн үүрэг, хариуцлага

Хүний эрхийг хамгаалагчдын хамгааллыг нэн тэргүүнд сайжруулж хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллах үүргийг төр биелүүлнэ. Төр нь хүний эрхийг хамгаалагчдын хамгаалах тал дээр эерэг ба сөрөг хариуцлагын аль алиныг хүлээнэ. Хүний эрхийг хүндлэх, хамгаалах ёстой гэж заасан олон улсын зарчим, хэм хэмжээгээр хүлээсэн үүргийнхээ хамт, төр нь дараах

<sup>4</sup> Хүний эрхийг хамгаалагчдын тунхаглалын 1 дүгээр зүйл. (Бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах, хөхиүлэн дэмжих талаар хувь хүн болон нийгмийн бүлэг, байгууллагын эрх үүргийн тухай тунхаглал).

хариуцлагыг үүрнэ. Үүнд:

- Хүний эрхийн талаарх үйл ажиллагааны улмаас хүний эрхийг хамгаалагчдын аливаа эрхийг зөрчих үйлдэл гаргахаас татгалзах;
- Хүний эрхийг хамгаалах үйл ажиллагааных нь улмаас гуравдагч талаас үзүүлэх дарамт шахалтаас хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах, энэ үйл явцыг зохих журмын дагуу шийдвэрлэх;
- Хүний эрхийг хамгаалагчдын эрх, түүний дотор хүний эрхийг хамгаалах бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд чиглэсэн санаачилгатай алхмуудыг авч хэрэгжүүлэх зэрэг болно.

Хүний эрхийг хамгаалагчдыг үйл ажиллагааных нь төлөө ямарваа нэгэн хууль бус шийтгэл оногдуулах, хуулийн дарамт, шахалт үзүүлж хуулийн болон шүүн таслах ажиллагаа явуулах, эрх мэдлээ урвуулан ашигласан аливаа үйлдэл эсвэл гэмт хэрэгт тооцох, дур зоргоор баривчлах, албадан саатуулах болон бусад төрлийн шийтгэл оногдуулахаас ангид байх ёстой. Хүний эрхийг хамгаалагчдыг албадан саатуулсан эсвэл тэдэнд оногдуулсан аливаа ял шийтгэлийн эсрэг гомдол гаргах, хууль ёсны эсэхэд нэхэмжлэл, гомдол гаргах эрхтэй байх ёстой<sup>5</sup>.

НҮБ-ын Хүний эрхийн хороо “цагдаа ба хүний эрх”-ийн хоорондох уялдаа холбоог харуулсан хэд хэдэн баримт бичиг, дүрэм баталсан<sup>6</sup>. Хууль сахиулах бүх байгууллагуудын дагаж мөрдөх шаардлагатай удирдамжийг тогтоосон бөгөөд энэ нь цагдаагийн алба хаагч нарт ч хамаатай юм<sup>7</sup>. Тухайлбал:

- Хууль сахиулагч үүргээ гүйцэтгэх үедээ хүний нэр төрийг хүндэтгэж, хамгаалах, хүний эрхийг хамгаалах ёстой.
- Хууль сахиулах байгууллага нь зөвхөн шаардлагатай тохиолдолд хүний эрхэд халдаж, хүний эрхийг хязгаарлах шаардлагатай бол шүүхэд хандах хэрэгтэй.
- Мөрдөн байцаалтын явцад тухайн хүмүүсийн талаар олж авсан бүх мэдээллийг нууцлах нь хууль сахиулах байгууллагын үүрэг бөгөөд зөвхөн гэмт хэргийг илрүүлэх, болж өнгөрсөн бодит байдлыг олж тогтооход ашиглах шаардлагатай.

5 НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 53 дугаар чуулганы 85 дугаар нэгдсэн хуралдаанаас 1998 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн А/RESS3/144 тогтоолоор баталсан Хүний эрхийг хамгаалагчдын тунхаглал (Бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах хөхиүлэн дэмжих талаар хувь хүн болон нийгмийн бүлэг, байгууллагын эрх үүргийн тухай тунхаглал).

6 For details the Web Site of UNHCR <http://www.unhcr.org.in>; also see HR Standards and Practices for the Police : Expanded pocket Book on Human Rights for the police PTS No.5/Add.3, 2004

7 UNGA Res.34/169, December, 17, 1979.



- Цагдан хорих байранд байгаа хүмүүсийн нэр төрд харшилсан хүнлэг бус, харгис хэрцгий, бусдын нэр төрийг доромжилсон үйлдэл хийх, эрүүдэн шүүх болон бусад аливаа үйлдэл хийхгүй байх нь хууль сахиулах байгууллагын үүрэг юм.
- Шаардлагатай тохиолдолд цагдан хорихгүйгээр асрамжийн газарт байгаа хүмүүст эмнэлгийн болон бусад эрүүл мэндийн байгууллагуудаар хангах шаардлагатай.
- НҮБ-ын хууль тогтоомж, дүрмийг цаг ямагт ямар ч эргэлзээгүйгээр сахин биелүүлэх ёстой бөгөөд хэрэв ямар нэгэн зөрчих үйлдэл гарсан бол хүний эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг эрх бүхий байгууллагуудад танилцуулна. Энэ дүрмийг конвенцод нэгдэн орсон улс орны цагдаагийн байгууллага нь үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах үүрэгтэй юм.

### III. Цагдаагийн алба хаагч ба хууль ёсны үйл ажиллагаа


НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 1979 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 34/169 дүгээр тогтоолоор баталсан Хууль сахиулах байгууллагын албан хаагчдын ёс зүйн дүрмийн 1 дүгээр зүйлд зааснаар “Хууль хэрэгжүүлэх албан тушаалтнууд нь нутаг нэгтэндээ үйлчлэн бүх хүмүүсийг хууль бус үйлдлээс хамгаалж, хуулиар хүлээсэн үүргээ мэргэжлийн шаардлагын үүднээс байнгын өндөр хариуцлагатай биелүүлж байна” гэжээ. Энэхүү заалтын тайлбарт:

а/ “Хууль хэрэгжүүлэх албан тушаалтан” гэдэгт цагдаагийн бүрэн эрх эдэлдэг, ялангуяа бусдыг баривчлах, хорьж саатуулах эрх бүхий томилдог болон сонгодог бүх албан тушаалтнууд хамаарна.

б/ Цагдаагийн бүрэн эрхийг дүрэмт болон иргэний цэргийн байгууллагын төлөөлөгчид болон аюулаас хамгаалах хүчнүүд эдэлдэг тийм орнуудад “хууль хэрэгжүүлэх албан тушаалтан” гэдэг ойлголтын тодорхойлолтод тэдгээр албадын ажилтнуудыг хамааруулна.

в/ Нийгэмд хүчин зүтгэх гэдэгт тухайлбал хувийн, эдийн засгийн, нийгмийн болон бусад онцгой шалтгааны улмаас яаралтай тусламж үзүүлэх шаардлагатай нийгмийн тийм гишүүдэд үзүүлэх тусламж, үйлчилгээг хамааруулж үзнэ.

г/ Энэ заалтад нь зөвхөн хүчирхийллийн дээрмийн болон хор уршигт үйлдүүд хамаараад зогсохгүй Эрүүгийн хуулиар тогтоосон бүх хоригдолд хамаарна. Үүнийг эрүүгийн хариуцлага хүлээх чадваргүй этгээдийн зан үйлд ч хамааруулан үзнэ.



Манай улсын хувьд хууль сахиулах ажиллагааны үндэслэл, журмыг төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэгч гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах, аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүрэг бүхий байгууллагуудын эрх зүйн хэм хэмжээний хүрээнд зохицуулж байгаа бөгөөд хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлэгч субъектууд болон тэдний эрх, үүрэг, хэрэгжүүлэх арга хэмжээ хүрээг зохицуулсан 10 гаруй хууль байна. Өнгөрсөн жилүүдэд зөрчил, гэмт хэргийг шалган тогтоох ажиллагааны явцад хүний халдашгүй эрхийг хангах, хууль сахиулагчийн хэрэгжүүлэх эрх хэмжээг нэг стандартад оруулахаар Хууль сахиулагчийн тухай хуулийн төслийг хэлэлцүүлж байсан ч одоогоор батлагдаагүй байна.

Цагдаа болон Шүүхийн шийдвэр биелүүлэх, Хил хамгаалах байгууллага, Гадаадын иргэн харьяатын газар, Онцгой байдлын алба нь хууль сахиулах байгууллага мөн бөгөөд гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах, хүний эрх, эрх чөлөөг хангах, аюулгүй байдлыг нь хамгаалах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж буй алба хаагчийг хууль сахиулагч гэнэ.

Монгол Улсын нутаг дэвсгэрт хууль тогтоомжоор тогтоосон журам сахиулах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, (цаашид “мөрдөн шалгах” гэх)-ийн ажиллагаа явуулахад хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг хангаж, хамгаалах ёстой.

Хууль сахиулагч нь гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах, ард иргэдийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргээ гүйцэтгэхдээ Үндсэн хууль, Цагдаагийн албаны тухай хуульд зааснаас гадна цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэмд заасан эрх зүйн хэм хэмжээг мөрдлөг болгон хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, ил тод, нээлттэй байх, нууцыг чанд хадгалах, олон нийтийн итгэл хүлээж иргэний дэмжлэгийг авах, төр болон төрийн бус байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага, иргэдтэй харилцан хамтран ажиллах, шинжлэх ухаан, орчин үеийн техник, технологи, мэдээллийн сүлжээний ололтыг ашиглах, нэгдмэл төвлөрсөн удирдлагатай байх үндсэн зарчмыг баримталдаг.

Монгол Улсын хувьд Цагдаагийн байгууллага нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллага юм.

Цагдаагийн байгууллага нь гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийн хүрээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлдэг байна. Үүнд:


- гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг гарсан шалтгаан нөхцөлийг тогтоох, арилгуулах;

- гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа тухай мэдээллийг хүлээж авах, бүртгэх, олзлох, цуглуулах, олж авмагц таслан зогсоох, учирч болох хор хохирлыг гаргуулахгүй, нэмэгдүүлэхгүй байх арга хэмжээ авах, гэмт хэргийг илрүүлэх;
- гэмт хэрэг гарсан тухай мэдээллийг хүлээн авмагц гэмт хэргийн газрыг хамгаалах, үзлэг хийх, нотлох баримт илрүүлэх, бэхжүүлэх, цуглуулах, гэмт этгээдийг олж тогтоох, эрэн сурвалжлах, баривчлах;
- хуулиар харьяалуулсан гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах;
- хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу гүйцэтгэх ажил явуулах;
- гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий бусад байгууллагатай хамтран ажиллах;
- хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхээс оргон зайлсан сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, гэмт хэрэг үйлдсэнд сэрдэгдсэн хүнийг эрэн сурвалжлах, баривчлах;
- гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасны дагуу гэрч, хохирогчийг хамгаалах;
- шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах; гэмт хэрэг, зөрчил, тэдгээрт шийтгүүлсэн этгээдийн нэгдсэн тоо бүртгэл хөтлөх, лавлагаа гаргах;
- гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр судалгаа, шинжилгээний ажилд мэргэжлийн байгууллага, мэргэжилтний туслалцаа авах, татан оролцуулах зэрэг эрхийг эдлэн гэмт хэрэгтэй тэмцдэг байна<sup>8</sup>.

Мөн нийтийн хэв журмыг хамгаалах чиг үүргийн хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлдэг. Үүнд:

- зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах, бүртгэх, хуулиар харьяалуулсан зөрчлийг шалгаж шийдвэрлэх, байгууллага, алба хаагчийг мэдээллээр хангах;
- гудамж, талбай болон нийтийн эзэмшлийн бусад газарт эргүүл хийх, байнгын болон түр ажиллагаатай хянаж-нэвтрүүлэх цэг ажиллуулах дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг, бусад арга, техник хэрэгсэл ашиглан хяналт тавих;

<sup>8</sup> Цагдаагийн албаны тухай хууль, (2017).



- замын хөдөлгөөний аюулгүй байдлын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах; насанд хүрээгүй хүнийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах;
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах;
- гэрээт харуулын болон хувийн хамгаалалтын үйл ажиллагаанд хяналт тавих, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах;
- хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх явцад илэрсэн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгуулах, тэдгээрийг гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор иргэн, хуулийн этгээдэд шаардлага, сэрэмжлүүлэг өгөх, биелэлтийг нь хангуулах;
- олон нийтийн цагдааг мэргэжил, арга зүйгээр хангах зэрэг болно.

Цагдаагийн алба хаагч нь 18 насанд хүрсэн, ял шийтгэлгүй, цагдаагийн тангараг өргөж, цагдаагийн аль нэг байгууллагад ажиллаж суралцаж байгаа Монгол Улсын иргэн байна. Цагдаагийн алба хаагч нь хууль тогтоомжийг чанд сахиж, хүний эрх, эрх чөлөөг ханган, хамгаалж, бусдын нэр төрийг хүндэтгэн хүнлэг харилцах үүрэгтэй.

Цагдаагийн алба хаагч нь үйл ажиллагаандаа шуурхай байж, хуулиа дээдлэн, шудрага ёс, тэгш байдлыг ханган, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэж, ажил хэрэгч, соёлч, цагдаагийн алба хаагчийн нэр хүндийг ямагт өргөж, өөрийгөө хөгжүүлэн, мэдлэг боловсрол, мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэхийг эрхэмлэх ёстой<sup>9</sup>. Түүнчлэн Үндсэн хууль, бусад хууль тогтоомж, хэм хэмжээний эрх зүйн акт, дээд шатны байгууллага, албан тушаалтны хуульд нийцсэн шийдвэрийг ёсчлон биелүүлж, захирах, захирагдах ёсны зарчмыг баримтлан, нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээ болон цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмыг сахин мөрдөж, албан үүргээ гүйцэтгэх явцдаа төр, байгууллага, хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцыг үл задруулах, хувийн болон бусдын ашиг сонирхлын төлөө ашиглахгүй байх, албан ёсны шийдвэр гараагүй аливаа асуудлын талаар байр суурь илэрхийлэхгүй байх, зөвшөөрөлгүй мэдээ, мэдээлэл тараахгүй байх үүрэгтэй.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэж, хүнийг үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, эрүүл мэндийн байдал, бэлгийн чиг хандлагаар нь ялгаварлан гадуурхахгүй байж, бусдын эрхэнд хууль

9 Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм, (2017).

бусаар халдах, чирэгдүүлэх, дарамтлах, хүнд суртал гаргахгүй байх; албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ иргэн, хамтран ажиллаж байгаа алба хаагчтай адил тэгш, хүлээцтэй, хүндэтгэлтэй харилцаж, тэдний нэр төр, алдар хүнд, хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хүндэтгэн албан үүргээ гүйцэтгэнэ.

Цагдаагийн алба хаагч нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, зөрчлийг арилгуулах, учирч болох хор хохирлыг гаргуулахгүй, нэмэгдүүлэхгүй байх зорилгоор хүн, хуулийн этгээдэд тодорхой үйлдлээс татгалзах, эсхүл үйлдэл хийх талаар хууль ёсны шаардлага тавих ёстой.

Нийтийн хэв журмыг зөрчсөн, зөрчиж болзошгүй согтуурсан, мансуурсан хүнийг олон нийтийн газрыг тодорхой хугацаанд орхин явахыг шаардана. Цагдаагийн алба хаагч гэмт хэрэг, зөрчлийн ул мөрийг бэхжүүлэх, бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг хамгаалах, хуулийн этгээдийн хэвийн үйл ажиллагааг хангах, тээврийн хэрэгсэл, явган зорчигчийн хөдөлгөөнд учирсан саадыг арилгах зорилгоор хүнийг тодорхой байр, газрыг орхин явахгүй байх, эсхүл өөр газар шилжин байрлахыг шаардах, гэмт хэрэг, зөрчлийн тухай гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэхэд шаардлагатай хуулиар хориглосноос бусад баримт эд зүйлийг гаргаж өгөхийг мөн шаардах эрхтэй бөгөөд хоёр болон түүнээс дээш тооны хүнд шаардлага тавих тохиолдолд хүн тус бүрд хэлэх үүрэг хүлээхгүй. Цагдаагийн алба хаагчийн шаардлагыг тухайн хүн, хуулийн этгээд биелүүлэх үүрэгтэй бөгөөд шаардлагыг биелүүлээгүй, эсэргүүцсэн, эсхүл хуулийн дагуу явуулж байгаа ажиллагаанд нь саад учруулсан бол албадан гүйцэтгэж, гэм буруутай этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэх хууль эрх зохицуулалттай юм. Энэ хуулийн дагуу хийгдэж байгаа хууль ёсны үйл ажиллагаа учраас ард иргэд эрхээ эдлэж байгаа хэдий ч цагдаагийн алба хаагчийн хууль ёсны шаардлагыг хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ.

Цагдаагийн алба хаагч нь гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журам сахиулах үйл ажиллагаа нь хүний эрх, эрх чөлөөнд халдаж хийгддэг, хууль ёсны үйл ажиллагаанаас хууль бус үйлдэл, зөрчилд тооцогдох эрсдэлтэй хууль сахиулах үйл ажиллагаа юм. Гэхдээ цагдаагийн алба хаагч нь хүний эрх, эрх чөлөөнд хууль бусаар халдах, албан тушаал, байгууллагын нэрээр бусдыг эрхшээлдээ оруулах, дарамтлах үйл ажиллагааг Цагдаагийн албаны тухай хуулиар хориглосон.

Нийгмийн харилцаа нягтарч хүний эрхийг хангаж ажиллах шаардага өндөр тавигдаж буй өнөө үед хүний эрх, эрх чөлөөнд халдах аливаа ажиллагааг нарийн журамлаж, хэрэгжүүлэх нь нэг талаас хүний эрхийг хангах, нөгөө талаас хууль сахиулах үйл ажиллагаа хэрэгжих баталгаа болох учиртай юм.

Өнөөдөр дагаж мөрдөж буй хууль тогтоомжид дүн шинжилгээ хийж үзэхэд Цагдаагийн байгууллагаас гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам сахиулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор хүний эрхийг хязгаарлах, тайлбар авах, бичиг баримтыг шалгах, түр саатуулах болон бусад хойшлуулшгүй ажиллагаа явуулахтай холбоотой харилцааг Цагдаагийн албаны тухай болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар зохицуулж байна.

Цагдаагийн албаны тухай хуульд зааснаар гэмт хэргийг таслан зогсоох, илрүүлэх зорилгоор хуульд заасан эрх эдэлж хүний эрхийг хязгаарлан баривчилах ажиллагааг явуулж болно. Үүнд:

- Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхээс оргон зайлсан сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, гэмт хэрэг үйлдсэнд сэрдэгдсэн хүнийг баривчлах<sup>10</sup>;
- Оргон зайлсан болон эрэн сурвалжлагдаж байгаа, эсхүл тухайн хүнийг гэмт хэрэг үйлдсэн гэх баримт, үндэслэл бүхий сэжиг байгаа бол баривчлах<sup>11</sup>;
- Гэмт хэрэг гарсан тухай мэдээллийг хүлээн авмагц цагдаагийн алба хаагч нь гэмт хэргийн газрыг хамгаалах, үзлэг хийх, нотлох баримт илрүүлэх, бэхжүүлэх, цуглуулах, гэмт этгээдийг олж тогтоох, эрэн сурвалжлах, баривчлах<sup>12</sup>;
- Эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр албадан ирүүлэхээр даалгасан, эсхүл эрэн сурвалжлагдаж байгаа сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан түүнчлэн гэмт хэрэг, зөрчил үйлдсэнд сэрдэгдэж байгаа гэх үндэслэл бүхий сэжиг байгаа тохиолдолд баривчлах<sup>13</sup>;
- Гэмт хэргийг таслан зогсоох, гэмт хэрэг үйлдсэн болон эрэн сурвалжлагдаж байгаа хүн, оргосон сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хоригдлыг мөрдөн хөөж баривчлах<sup>14</sup>;
- Нийтийн хэв журмыг бүлэглэн зөрчиж бусдад хүч хэрэглэсэн, эсхүл хүч хэрэглэхээр заналхийлсэн, эд хөрөнгө устгаж гэмтээсэн, эдгээр үйлдэлд өдөөн турхирсан, татан оруулсан, оролцсон хүнийг баривчлах<sup>15</sup>;
- Шаардлагатай гэж үзвэл хүчирхийлэл үйлдэгчийг баривчлах<sup>16</sup> зэрэг

10 Цагдаагийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.7 дахь хэсэг.

11 Цагдаагийн албаны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.5.2 дахь хэсэг.

12 Цагдаагийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь хэсэг.

13 Цагдаагийн албаны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.5.6 дахь хэсэг.

14 Цагдаагийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.3 дахь хэсэг.

15 Цагдаагийн албаны тухай хуулийн 40 дугаар зүйлийн 40.2.6 дахь хэсэг.

16 Цагдаагийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.5 дахь хэсэг.

тохиолдлуудад цагдаагийн алба хаагч нь хуулиар хүлээлсэн үүргээ биелүүлж бусдыг эрхийг хамгаалах үүднээс гэмт хэрэг үйлдсэн хүний эрхийг хязгаарлаж баривчлах талаар хуульд тодорхой зааж өгсөн байна.

Харин НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас хүнийг баривчлах үеийн цагдаагийн алба хаагчтай холбоотой хүний эрхийн гол асуудал болон холбогдох олон улсын хүний эрхийн стандартыг нэгтгэсэн “Цагдаагийн байгууллага, хүний эрхийн стандарт, туршлага” цагдаагийн алба хаагчдад зориулсан үйл ажиллагааны стандарт, зөвлөмжүүдийг оруулсан сургалтын гарын авлагад хүнийг баривчлах үед цагдаагийн алба хаагч нь дараах зөвлөмжийг баримтлах ёстой талаар тусгаж өгчээ. Үүнд:

- Өөрийн баривчлах эрх мэдэл, түүнтэй холбоотой журмаа сайтар ойлгохын тулд баривчилгааны өмнө болон дараа байнга танилцана.
- Хүний эрхэм чанарыг хүндэтгэж, хашир болгоомжтой хандан мэргэшсэн байдлаар баривчилгаа явуулах, хүнтэй харилцахад шаардлагатай ур чадвар, ялангуяа харилцааны ур чадвараа хөгжүүлэх, бий болгох сургалтад оролцоно.
- Баривчлах үедээ ямар нэгэн эсэргүүцэлтэй тулгараагүй бол тайван, эелдэг, татгалзах аргагүй байдлаар ярилцаж, шаардлагатай тохиолдолд л ширүүн, захирангуй өнгөөр харилцана.
- Баривчилгаа явуулахдаа хүний эрхэм чанарыг хүндэтгэж, хашир болгоомжтой хандан мэргэшсэн байдлаар ажиллахад чухалд тооцох шаардлагатай техникийн болон тактикийн ур чадвараа хөгжүүлэх, бий болгоно.
- Гав зэрэг хүний хөдөлгөөнийг хязгаарлах хэрэгслийг ашиглах ур чадвараа хөгжүүлнэ.
- Өөрийгөө хамгаалах ур чадвараа нэмэгдүүлэх замаар өөртөө итгэх итгэлээ нэмэгдүүлнэ.
- Баривчлахтай холбоотой хүч хэрэглэх тухай заасан бүлгийг сайтар судална.
- Боломжтой бол баривчлах тогтоол зөвшөөрлийг заавал авна.
- Жижиг цаасан дээр баривчлагдсан хүний эрхийг бичиж, зугтах боломжгүй хамгаалалтад байгаа баривчлагдсан хүнд үг бүрчлэн уншиж өгөхөөр өөрийн дүрэмт хувцсандаа хадгалан авч явна.
- Ажлын байрны эсхүл тэдэнд чиглэсэн сургалтын хөтөлбөрөөр

УИИ.МН  
СЭДАЛГААНЫ САН

дамжуулан, зөрчилдөөнийг шийдвэрлэх арга техникийг судална.

- Баривчилсан тэмдэглэлийг сайтар хөтөлж хэвшинэ<sup>17</sup> зэрэг стандартыг үйл ажиллагаандаа баримтлах бөгөөд баривчлах ажиллагаа хууль ёсны дүрэм, журмын дагуу явагдсан эсэх тал дээр удирдах албан тушаалтан нь хяналт тавьж ажиллана.

Мөн удирдах албан тушаалт нь цагдаагийн алба хаагч нарт баривчлах ажиллагааны талаар тодорхой, ойлгомжтой журам гаргаж мөрдүүлэх бөгөөд бүх цагдаагийн ажилтнуудыг баривчилгааны журам, баривчлагсдын эрх болон баривчилгааны аюулгүй, хүнлэг арга техникийн сургалтад хамруулж хүнтэй харилцах, зөрчилдөөн шийдвэрлэх, өөрийгөө хамгаалах, хүний хөдөлгөөнийг хязгаарлах механизм ашиглах сургалт зохион байгуулна. Мөн өөрийн эрх мэдлийн хүрээнд баривчилгааны талаар заасан хууль тогтоомж, журам болон баривчилсан тухай мэдээллийг тэмдэглэх стандарт маягт боловсруулж урьдчилан төлөвлөх боломжтой бол баривчилгаа явуулах боломжит сонголтуудыг тодорхойлж, баривчлах нөхцөл байдалдаа тохирсон байдлаар төлөвлөх, бэлтгэх, ярилцах, тактикийг батална. Эцэст нь баривчлах ажиллагаа бүрийн дараа оролцсон албан хаагчидтай товч ярилцаж, баривчилгааны тухай тэмдэглэлийг бүрэн дүүрэн хөтөлсөн эсэхийг сайтар нягтална<sup>18</sup>.

Бусдыг баривчлах үед цагдаагийн алба хаагч нь дээрх зөвлөмжүүдийг баримталснаар баривчлах ажиллагаа нь хүний эрхийг хязгаарлаж байгаа хэдий ч хүний эрхийг зөрчихгүй тухайн ажиллагаа хууль ёсны болох учиртай юм.

#### IV. Дүгнэлт

Цагдаагийн байгууллага нь хууль ёсны дагуу албадлага, хүч хэрэглэх эрхтэй байгууллага хэдий ч хууль дээдлэх ёсыг чанд сахихын зэрэгцээ мэргэжлийн ёс зүйн дүрмийн хүрээнд ажиллаж, хүний эрхийг дээдлэх, иргэд, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүргийг хэрэгжүүлэхэд бүтэц, зохион байгуулалт, хяналт, хариуцлагын тогтолцоо нь мэргэжлийн чадавх, материаллаг нөөц, менежментийн бодлоготой салшгүй холбоотой. Мөн цагдаагийн албаны захиргаа, удирдлага зохион байгуулалт, стратеги төлөвлөлтөд хүний эрхийг хангах асуудал чухал байна. Түүнчлэн бодлогын шийдвэр гаргах үйл явц тэр дундаа үйл ажиллагаа нь тушаалаар хэрэгждэг учраас албан тушаалын зэрэглэл, цолны эрэмбээр захирах, захирагдах ёсыг чанд баримтлах ёстой билээ. Энэхүү онцлог харилцааг хэрэгжүүлэхдээ хэний ч болов эрхэмсэг оршихуйг хүндэтгэн, ардчиллын зарчмыг дагаж

17 “Цагдаагийн байгууллага, хүний эрхийн стандарт, туршлага”, НҮБ-ын Ерөнхий Ассамблей, (цагдаа нарт зориулсан хүний эрхийн тухай дэлгэрэнгүй өврийн ном, мэргэжлийн сургалтын цуврал №5), 20 дахь тал.

18 “Цагдаагийн байгууллага, хүний эрхийн стандарт, туршлага”, НҮБ-ын Ерөнхий Ассамблей, (цагдаа нарт зориулсан хүний эрхийн тухай дэлгэрэнгүй өврийн ном, мэргэжлийн сургалтын цуврал №5), 21 дахь тал.



мөрдөн, хуулийн засаглал, эрх зүйт ёс, иргэний эрхийг дээдэлсэн, хүний эрхийн хандлага арга зүйд суурилсан мэргэжлийн салбарыг бий болгож хөгжүүлэхэд анхаарах шаардлагатай. Иймд хууль сахиулах ажиллагаатай холбоотой үндэсний хууль тогтоомжийг олон улсын нийтийн эрх зүйн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэх, олон улсын гэрээ, конвенцод заасан нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандартыг хэрэгжүүлэх, түүнчлэн нийгмийн үнэт зүйлс, хүний эрх, эрх чөлөө, ашиг сонирхолыг хамгаалах чиглэлээр цагдаагийн алба хаагчдын хүний эрхийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, хүний эрхийн боловсрол олгох явдлыг тасралтгүй хэрэгжүүлэх нь зайлшгүй чиг үүрэг болно.

Одоогоор цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд баривчлах, албадан саатуулах шийдвэр биелүүлэх, түр саатуулах ажиллагааг хэрхэн явуулахтай холбоотой асуудлыг бүрэн тусгаж, зохицуулсан гэж үзэхэд учир дутагдалтай байна. Баривчлах ажиллагааг хэрхэн явуулах, баривчлахын тулд орон байранд нэвтрэх, сэжигтэй этгээдийн биеийн байцаалтыг шалгах, баривчлах, албадан саатуулах шийдвэр биелүүлэх, түр саатуулах үед эсэргүүцэл үзүүлбэл хэрхэн ажиллах, ямар арга хэмжээ авах, баривчлах, албадан саатуулах, түр саатуулах үед хэрэглэх албадлагын арга хэмжээ, баривчлах, албадан саатуулах, түр саатуулах ажиллагааны тэмдэглэл хэрхэн хөтлөх зэрэг асуудал цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам, кодод журамлагдаагүй байна.

Баривчлах ажиллагааны үед цагдаагийн алба хаагчийн хийх үйлдэл хөдөлгөөнийг нэг бүрчлэн нарийвчлан боловсруулж заавар, журмыг гаргах нь зүйтэй. Ажиллагааны үеийн үйл хөдлөл, дэс дарааллыг нарийн зааж өгсөнөөр хүний эрхийг хязгаарлан баривчлах ажиллагаа нь хууль ёсны, үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагч нар өөрөө буруутан болох эрсдэлээс бүрэн хамгаалагдах юм. Харин одоо хүчин төгөлдөр үйлчиж байгаа холбогдох дүрэм, журамд тодорхой зааж өгөөгүйгээс нийгмийн хэв журам сахиулах үед баривчлах, саатуулах, түр саатуулах ажиллагаа удирдаж буй албан тушаалтны мэдлэг, чадвараас шалтгаалан амаар үүрэг өгсөний дагуу хэрэгжиж байгаа нь хүний эрх зөрчигдөх нэг нөхцөл болж байна.

## Ном зүй

### Монгол эх сурвалж

1. Монгол Улсын Үндсэн хууль, (1992).
2. Цагдаагийн албаны тухай хууль, (2017).
3. Цагдаагийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, (2017).
4. Нийгмийн хэв журам ба хүний эрх, (2012).

ОИГ.МН  
СУДАЛГААНЫ САН

## Гадаад эх сурвалж

1. Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал, (1948).
2. НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 53 дугаар чуулганы 85 дугаар нэгдсэн хуралдаанаас 1998 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн А/RES53/144 тогтоолоор баталсан Хүний эрхийг хамгаалагчдын тунхаглал (Бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах, хөхиүлэн дэмжих талаар хувь хүн болон нийгмийн бүлэг, байгууллагын эрх үүргийн тухай тунхаглал).
3. НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 1979 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 34/169 дүгээр тогтоолоор баталсан Хууль сахиулах байгууллагын албан хаагчдын ёс зүйн дүрэм.
4. Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагаас 1994 оны 12 дугаар сарын 3-ны өдөр баталсан Аюулгүй байдлын улс төр-цэргийн хүрээний ёс зүйн дүрэм.
5. НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас “Цагдаагийн байгууллага, хүний эрхийн стандарт, туршлага” (цагдаа нарт зориулсан хүний эрхийн тухай дэлгэрэнгүй өврийн ном, мэргэжлийн сургалтын цуврал №5).
6. НҮБ-ын Хүний эрхийн Дээд Комиссарын Газар, “Хүний эрх ба хууль сахиулах нь” Цагдаагийн ажилтнуудад зориулсан хүний эрхийн сургалтын гарын авлага, УБ, 2005 он.

## Бусад эх сурвалж

1. For details the Web Site of UNHCR <http://www.unhcr.org.in>; also see HR Standards and Practices for the Police : Expanded pocket Book on Human Rights for the police PTS No.5/Add.3, 2004. [https://www.researchgate.net/publication/291986212\\_HUMAN\\_RIGHTS\\_AND\\_POLICE\\_A\\_BIRD'S\\_EYE\\_VIEW](https://www.researchgate.net/publication/291986212_HUMAN_RIGHTS_AND_POLICE_A_BIRD'S_EYE_VIEW)
2. UNGA Res.34/169, December 17, 1979. [https://www.researchgate.net/publication/291986212\\_HUMAN\\_RIGHTS\\_AND\\_POLICE\\_A\\_BIRD'S\\_EYE\\_VIEW](https://www.researchgate.net/publication/291986212_HUMAN_RIGHTS_AND_POLICE_A_BIRD'S_EYE_VIEW)



## П.НАМУУН

Чингэлтэй дүүрэг дэх Цагдаагийн газрын бичээч,  
цагдаагийн ахлагч, докторант

## АВЛИГА, АЛБАН ТУШААЛЫН ГЭМТ ХЭРЭГ БА ХҮНИЙ ЭРХ

## CORRUPTION AND WHITE COLLAR CRIMES AND HUMAN RIGHTS

**Хураангуй:** Эрх зүй, эрх зүйт төрийн үүсэл нь эдүгээ цагт яригдах хууль дээдлэх, сахин биелүүлэх тухай ойлголтод хамаарах хамгийн чухал хэсэг билээ. Эрх зүйн зорилго бол хүний төрөлхийн жам ёсны эрх, эрх чөлөөг дээд ухамсрын түвшинд үнэлж, түүнийг хангах явдал бөгөөд бид эрх зүйг хуульд тогтоосон хэм хэмжээнийх нь хүрээнд дагаж мөрдөх учиртай. Харин ийнхүү дагаж мөрдөхөд ёс зүй, ёс суртахууны ойлголт, уялдаа холбоо, ач холбогдлыг орхигдуулж болохгүй юм. Нэгэнт тогтоосон хэм хэмжээг зөрчих нь бусдын эрхэд халдаж, хохирол учруулж байдаг буруу үр дагавартай. Үүний нэг жишээ болох гэмт хэргийн улмаас зөрчигдөж буй хүний эрх, цаашлаад авлига албан тушаалыг гэмт хэргийн улмаас хүний эрх зөрчигдөх үеийн хор, хөнөөлийг энэхүү өгүүллээр судлахаар зорив.

**Түлхүүр үгс:** Хүний эрх, авлига, ёс зүй.

**Abstract:** The emergence of the rule of law is one of the most important aspects of the current concept of law-abidance. The purpose of law is to value and ensure innate human rights and freedoms at the highest level of con-

*sciousness, and we must abide by the law within the norms established by law. In doing so, however, ethics, moral understanding, coherence, and importance must not be neglected. Violation of established norms can have harmful consequences that infringe on the rights of others. One example of this is the study of human rights being violated as a result of crime, as well as corruption and white collar crimes. We aim to review the harms of the violations of human rights by these crimes through this article.*

**Keywords:** Human rights, corruption, morality.

## I. Оршил

Хүний эрх, эрх чөлөө нь хүн бүрийн өмнө нээлттэй, түгээмэл ойлголт боловч нэг мөр ойлгоход төвөгтэй байж болох асуудал юм. Өөрөөр хэлбэл хүний эрх, эрх чөлөө нь зөвхөн хууль, тогтоомжийн хүрээнд яригдахгүй, нийгэм, ёс зүй, нийтээр дагаж мөрдөх аливаа хэм хэмжээ, тэр ч бүү хэл нийгмийн түүхэн хөгжил, цаашлаад хүний ухамсрын тухай ойлголтуудтай гарцаагүй холбогддог. Тиймээс энэхүү өгүүллээрээ нийгэм хийгээд нийтээр хүлээн зөвшөөрөгдөх нь зүй ёсны болох ёс суртахуун, эрх зүйт төр, төрт ёсны ухамсарт байдлын талаар хөндөж, авлига, албан тушаалын гэмт хэргийн улмаас хүний эрх зөрчигдөж байгаа талаар судлахыг зорив.

Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын 8 дугаар зүйл, “Нийтийн албан тушаалтны ёс зүйн дүрэм”<sup>1</sup>-д “Авлигатай тэмцэхийн тулд оролцогч улс бүр нийтийн албан тушаалтныхаа дунд шударга, үнэнч, хариуцлагатай байх явдлыг бусад зарчмын хамт эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн хөхиүлэн дэмжинэ” хэмээн зааж, мөн конвенцын удиртгал хэсэгт “Авлигын улмаас нийгмийн тогтвортой болон аюулгүй байдалд үүсэж буй бэрхшээл, аюул занал нь ардчилсан тогтолцоо, үнэт зүйлс, түүнчлэн ёс зүйн үнэт зүйлс, шударга ёсыг сулруулж, тогтвортой хөгжил, хууль дээдлэх ёсонд хохирол учруулж” байгаа тухай дурдсан байдаг. Үүнээс үзвэл авлига, албан тушаалын гэмт хэрэг нь улс төр, эрх зүйн философийн үндсэн суурь зарчимд нь тулгуурлагдаж, нийгмийн бүхий л хөгжлийн үе шатууд дахь ёс зүй, ёс суртахууны талаарх ойлголттой салшгүй холбогдож байна.

1 НҮБ-ын Ерөнхий Ассамблей 2000 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн 55/61 дугаар тогтоолд “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенцоос тусдаа авлигын эсрэг олон улсын бие даасан эрх зүйн баримт бичиг боловсруулах нь чухал байгаа”-г дурдаж НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албаны дэргэд авлигын эсрэг олон улсын баримт бичгийн төсөл боловсруулах түр хороог байгуулсан байна. Тус түр хороо нь 2002 оны 1 дүгээр сарын 31-ний өдрөөс 2003 оны 10 дугаар сарын 1-ний өдрийн хооронд 7 удаа хэлэлцэж, зөвшилцөн Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын төслийн эцсийн найруулгыг боловсруулсан. НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 2003 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 58/4 дугаар тогтоолоор тус конвенцыг баталсан юм.

Монгол Улс уг конвенцод 2005 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр нэгдэн орж (UN Doc.NoC.N.323.2005.TREATIES-11), 2005 оны 10 дугаар сарын 27-ны өдөр УИХ соёрхон баталсан. (UN DocNoC.N.9.2006.TREATIES-1) Конвенцыг соёрхон баталсан тухай батламж жуух бичгийг 2006 оны 1 дүгээр сарын 11-ний өдөр НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулахаар хүргүүлж, 2006 оны 2 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн. Ингэснээр манай улс тухайн олон улсын гэрээг даган мөрдөх, түүний хэрэгжилтийг хангахад хүчин чармайлт тавих үүргийг олон улсын өмнө албан ёсоор хүлээсэн билээ.

Ёс суртахууны хэм хэмжээ нь нийгмийн амьдралд хэрэгжүүлэхэд итгүүлэх болон олон нийтээр дэмжүүлэх арга ажиллагаанд тулгуурладаг бол эрх зүй хэм хэмжээг хуулиар урьдчилан тогтоосон байдгаараа ялгаатай.

Төр улс үүсэн, нийлмэл нийгэм бий болохтой зэрэгцэн эхэлсэн хүн төрөлхтний хөгжил, хувьсал одоог хүртэл тасралтгүй үргэлжилсээр байна. Эртний улсуудын төр, эрх зүй, нийгмийн түүхийн судалгаа шинжилгээг өнөөгийн нийгэмтэй харьцуулан үзэхэд асар их хувьсал, өөрчлөлт, дэвшлийг харж болох ч хүн төрөлхтөн хөгжин дэвшихийн хирээр нийгэмд аюул занал учруулах аливаа хүчин зүйлс ч мөн адил нэмэгдсээр байгаа юм.

Ёс суртахуун, шашин, боловсрол, урлаг, гүн ухаан, технологи, гэх мэт материаллаг баялаг тэдгээрийн дээд түвшин дэх нийлэмжгүйгээр соёл иргэншил гэх ойлголт бий болохгүй байсан биз ээ. Хүн төрөлхтөн, тэдний соёл иргэншлээс хөдөө аж ахуйн үйл явц, худалдаа арилжаа, ажил мэргэжлийн ахиц, засаглалын анги бүлэг, хотжилт гэсэн категорийг салгаж болохгүй юм. Соёл иргэншлийн хөгжлийн түвшинд нөлөөлөгч хоёрдогч хүчин зүйлсийн нэг болох хөгжсөн тээвэрлэх систем, утга зохиол, мөнгө, хуулийн систем, соёл урлаг болон архитектур, математик, шинжлэх ухааны ойлголт, төмөрлөгийн боловсруулалт, улс төрийн бүтэц, шашин зэрэг билээ.

## II. Нийгэм болон ёс суртахууны тухай ойлголт

Германы философич К.Маркс “Нийгэм гэдэг нь хамтын үйл ажиллагааны явцад бүрэлдсэн хүмүүсийн хоорондын харилцааны түүхэн ёсоор хөгжигч цогц”<sup>2</sup> гэж тодорхойлжээ. Тиймээс нийгмийн харилцаанд оролцогч хүмүүсийн ёс суртахуун, тэдгээрийн ухамсрын түвшин дэх тодорхой ойлголтуудыг судлахгүйгээр нийгэм, төр, эрх зүйн асуудал, цаашлаад хууль дээдлэх зарчим, хуульд захирагдах ёс, нийгмийн аюулгүй байдлын талаар ярих боломжгүй юм.

Уламжлалт философийн онолоор бол нийгмийн харилцаа гэдгийг “хүмүүсээс нийгмийн үйл явцад, өөрөөр хэлбэл нийгмийн амьдралыг зохион байгуулахад оролцох” үйл явцыг хамааруулдаг ойлголт юм. Тухайлбал сонгууль, төрийн үйлчилгээ, иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагаа, үзэл бодол, байр сууриа илэрхийлэх гэх мэт жишээг дурдаж болно.

Нийгэмчлэх үзлийн анхны төлөөлөгч Аристотель<sup>3</sup> “Хүн бол полис (хот улс)-ын амьтан мөн” гэж үздэг бол К.Маркс<sup>4</sup> “Хүний мөн чанар бол хийсвэр зүйлс бус, утгаа тэр бээр нийгмийн харилцааны цогц мөн” гэж

2 Маркс К., Энгельс Ф. *Немецкая идеология // Избранные сочинения: в 9 т. Т. 2. М.: Политиздат, 1985.*

3 *Политика. ок.335-322г. до н.э. (Аристотель.)*

4 Маркс К., Энгельс Ф. *Немецкая идеология // Избранные сочинения: в 9 т. Т. 2. М.: Политиздат, 1985.*

тодорхойлсон байдаг. Тиймээс хүн бол нийгмийг цогцлоон бүтээгч эд эс болохынхоо хувьд өөрсдийн оюун ухаанаар бүтээсэн хууль дүрэм, ёс зүйн хэм хэмжээнд захирагдах учиртай билээ.

Нийгэм бол хүн төрөлхтний хувьд үнэт ололт болохынхоо хувьд хүмүүсийн ухамсар, оюунаар бүтэж, эргээд хувьсан өөрчлөгдөж байдаг бодит байдал, орчлон ертөнцийн юмс үзэгдлийн аливаа хэлбэр, тэдгээрийн түвшин юм гэж ойлгож болно. Харин нийгэм нь хэлцэл, хэм хэмжээ, эрх зүй, төрийн үйл ажиллагаа зэргээр зохицуулагдах ёстой юм.

Платон<sup>5</sup> “Нийгэмд хэн нь хэндээ захирагдах вэ?”, “Төр баригчийг хэрхэн шилж сонгох тэд сонгогдсоныхоо дараа нийгмийн эрх ашгийг хувийнхаас хэрхэн дээгүүр тавих вэ?” зэрэг улс төрийн философийн чухал асуудлыг хөндөж байсан. Платоны онолоор бол “Тусгай бэлтгэгдсэн бүлэг нийгмийг жолоодох ёстой” өөрөөр хэлбэл нийгмийг жолоодохын тулд тодорхой хүмүүст хязгааргүй бүрэн эрх олгох ёстой гэж үзсэн байдаг. Чухам ухамсар, ёс суртахууны дээд түвшинд хүрсэн тохиолдолд түүний энэ онолтой маргах зүйл үгүй билээ.

Харин Томас Гоббс<sup>6</sup> “Хэмжээгүй эрхт хаант засаг, төртэй байх нь засаггүй нийгмээс дээр гэж үзсэн. Тэрээр төр ард түмний хооронд гэрээ хэлэлцээр байх арга үгүй учир улсын харьяат албад төр засагт захирагдах л болно. Хүмүүсийн үйл ажиллагаа бол хүслээ хангах үйл ажиллагаа юм. Иймд үүнд хязгаарлалт хэрэгтэй” гэсэн ойлголтыг бий болгожээ.

Тэгвэл Джон Локк<sup>7</sup> “Төр нь захиргаадалт болон хуульд тулгуурлахгүй л бол эзэрхэг түрэмгий байх болно. Хуулийн дагуу байгуулагдсан захиргаа бол ардчилал юм” гэжээ.

Түүнээс ч илүүтэйгээр, хүн төрөлхтний түүхэн дэх хамгийн анхны ухамсарт харилцаа бол ёс суртахууны харилцаа байсан ажээ. Ёс суртахууны харилцаа нь үндсэндээ хорио, зөвшөөрөл гэсэн хоёр гол шалгуурын дагуу явагддаг байна. Тэгвэл төр, засаг захиргаа хэмээх ойлголтоос өмнө ухамсрын түвшин дэх ёс зүй, ёс суртахууны харилцаа үүссэн юм бол, хууль, эрх зүйн хүрээнд дагаж мөрдөх ёстой зан үйлийн горим журам бол ёс суртахуундаа улам бүр нийцэх гэсэн оролдлого юм гэж хэлж болохоор байна.

Чухамдаа нийгмийн харилцаанд зайлшгүй уусан шингэж, өдөр тутмын мөрдлөг болгохоос аргагүй чухал элемент бол, ёс зүй, ухамсар, ёс суртахууны асуудал мөн билээ. Ёс зүйтэй нийгмийг хүн өөрөө бүтээж,

5 <https://ru.wikipedia.org/wiki/%D0%9F%D0%BB%D0%B0%D1%82%D0%BE%D0%BD>

6 [https://ru.wikipedia.org/wiki/%D0%93%D0%BE%D0%B1%D0%B1%D1%81,\\_%D0%A2%D0%BE%D0%BC%D0%B0%D1%81](https://ru.wikipedia.org/wiki/%D0%93%D0%BE%D0%B1%D0%B1%D1%81,_%D0%A2%D0%BE%D0%BC%D0%B0%D1%81)

7 [https://ru.wikipedia.org/wiki/%D0%9B%D0%BE%D0%BA%D0%BA,\\_%D0%94%D0%B6%D0%BE%D0%BD](https://ru.wikipedia.org/wiki/%D0%9B%D0%BE%D0%BA%D0%BA,_%D0%94%D0%B6%D0%BE%D0%BD)

тэгснээр тэнд амьдрах гишүүд ёс зүйтэй байна гэдэг ойлголтыг орхиж болохгүй юм.

Нийгэм дэх хүмүүс өөрсдийн зан авир, үйлдлийг тохируулахын тулд өөрийн санаагаар, өөрсдийн дур зоргоор баримталдаг хэм хэмжээний цогц бол ёс зүй байна.

Эртний Хятадын ёс зүйн сургаалд Кунзийн<sup>8</sup> ёс суртахууны үзэл онол их том байр суурьтай байдаг билээ. Тэрээр “Хариуцлагаа ухаардаг байх нь шударга байх нөхцөл”, “Хамгийн муу үйлдэл бол хувийн ашиг олзны төлөө үйлдэл” гэж үзсэн нь өнөөгийн нийгэмд ч зонхилох болсон шударга бус үйлдлийн шинж чанарт тохирсон сургаал болохыг харж болно.

Харин Аристотель “Бие хүн нэг талаар нийгэм буюу хүмүүсийн төлөө нөгөө талаар өөрийнхөө төлөө байж бас төрд туслах ёстой. Сайн үйлийн хамгийн чухал нь шударга ёс”<sup>9</sup> гэжээ.

Аль ч нийгмийн хөгжлийн үе шатанд ёс зүйн тухай ойлголт, онол, тодорхойлолтууд тухайн үеийн эрдэмтэн мэргэдийн үзэл суртал, философийн онол, шашны сургаал номлол зэргээр дамжин хүн төрөлхтөнд тархан хүрдэг байсан бөгөөд хүнд хүрэх арга зам нь ямар ч хэлбэрийнх бай эцсийн дүндээ ёс зүй буюу ёс суртахуун “оюун ухаандаа захирагдах” гэсэн ойлголт юм.

Ницшегийн үзсэнээр “Ёс суртахуун бол сүрэг хүний үйлдлийг тэгшитгэх үйл явц”<sup>10</sup> ажээ. Тиймээс оюун ухаант хүний түвшинд ёс суртахуун гэдэг ойлголт бол нийгмийн аль ч харилцаанаас салгаж болохгүй чухал ойлголт гэдгийг нэгэнт батлан харуулсан билээ.

Ёс суртахууны үндсэн үүрэг нь хүмүүсийн харилцааг зохицуулах, үнэлэмж баримжаалалтай болгох, зөв сэдэлтэй болгох, урьдчилан зөвөөр хандах гэх мэт ухамсрын түвшинд үнэлэгдэхүйц ойлголт юм. Түүний үндсэн ухагдахууныг сайн ба муу, шударга ёс, үүрэг, нинжин сэтгэл, нэр төр гэх мэтээр тайлбарлаж болно.

Нийгмийн харилцаан дахь бас нэгэн чухал шалгуур бол шударга ёс юм. Энэ нь зан суртахууны үнэлэл баримжаалал төдийгүй харилцаа зөв байх ёсыг илэрхийлж байдаг. М.С.Горбачев “Нийгмийн шударга ёсны зарчмыг амьдралд хэрэгжүүлэх нь ард түмний нэгдэл нягтрал нийгмийн улс төрийн

8 <https://ru.wikipedia.org/wiki/%D0%9A%D0%BE%D0%BD%D1%84%D1%83%D1%86%D0%B8%D0%B9>

9 Аристотель, Улс төр, Орч.Б. Даш-Ёндон, УБ, 2003 он.

10 Левикова С.И.-Мораль как неотъемлемый элемент человеческого сообщества и мера человеческого в человеке // Философская мысль, 2016, №11, С. 87-102.

Правильная ссылка на статью: Левикова С.И.-Мораль как неотъемлемый элемент человеческого сообщества и мера человеческого в человеке // Философская мысль, 2016, №11, С. 87-102, DOI: 10.7256/2409-8728.2016.11.2056. URL: [https://nbpublish.com/library\\_read\\_article.php?id=20566](https://nbpublish.com/library_read_article.php?id=20566)

тогтвортой байдал, өрнүүн хөгжлийн нөхцөл мөн” гэжээ. Үүнээс үзвэл ёс суртахууны хэм хэмжээ нь нийгмийн хамгийн түгээмэл бөгөөд ердийн хэв журмыг зохицуулан сахиулах шинж чанартай жам ёсны ойлголт юм.

Өмнө нь дурдсанаар “ёс зүй, ёс суртахуундаа улам бүр ойртон нийцэхийн тулд хүн төрөлхтөн, төр, нийгэм, хууль, эрх зүйг бий болгож, түүнийг улам бүр төгөлдөржүүлж иржээ” гэсэн дүгнэлтийг судлаач миний бие дэвшүүлж байна.

### **III. Эрх зүйт төрийн ухамсар хийгээд авлига, албан тушаалын гэмт хэрэг**

Кант “Төр нь эрх зүйд захирагдсан хүмүүсийн нэгдэл юм”<sup>11</sup> гэж тэмдэглэж үлдээснээс харвал нийгэм, төрийн харилцаа, түүний холбогч эд нь эрх зүй болно. Эрх зүй, эрх зүйт төрийн үүсэл нь эдүгээ цагт яригдах хууль дээдлэх, сахин биелүүлэх тухай ойлголтод хамаарах хамгийн чухал хэсэг билээ.

Эрх зүйн зорилго бол “Хүний төрөлхийн жам ёсны эрх, эрх чөлөөг дээд ухамсрын түвшинд үнэлж, түүнийг хангах явдал” бөгөөд бид эрх зүйг хуульд тогтоосон хэм хэмжээнийх нь хүрээнд дагаж мөрдөх учиртай.

Харин төрийн албан тушаалтан гэдэг бол хуулиар олгосон хүрээ хязгаарын дотор шийдвэр гаргаж хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулж, төр, ард түмэндээ үйлчилдэг эрх зүйт төр, түүний байгууллагыг төлөвшүүлэн төгөлдөржүүлэх эрх, үүрэг бүхий амин чухал субъект юм. Харамсалтай нь өнөөгийн нийгэмд албан тушаалтны ёс зүй, ёс суртахуун, ажил албаа гүйцэтгэснийхээ төлөө эсвэл үл гүйцэтгэхийн тулд шан харамж авах үйлдэл буюу авлига, албан тушаалын гэмт хэргийн талаарх асуудал өргөн цар хүрээтэй яригдах болсон билээ.

Хууль дээдлэх зарчим гэдэгт дээд түвшний үнэлэмж, түгээмэл зарчим буюу зөвхөн хуулийг нийгмийн бусад хэм хэмжээнээс дээгүүрт тавьж ухамсарласан дотоод итгэлийн үндсэн дээр нийтээр, тэр дундаа төр засаг өөрийн бүхий л үйл ажиллагаандаа хуулийг сахин биелүүлэх, хэрэглэх, хамгаалах үйл ажиллагааг ойлгож болно. Хуульд үндэслэгдээгүй, хуулиар журамлагдаагүй, албан тушаалтны “дур зоргын шийдвэр” иргэний эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулах нь гарцаагүй юм. Харин үйл ажиллагааг хуульд захируулах гэсэн оролдлого буюу хууль дээдлэх ёс нь хүн төрөлхтний нэг ололт болно.

Аливаа гэмт хэрэг хүний ухамсар, хүсэл зоригийн үндсэн дээр хийгддэг, зан үйлийн гадаад үйл юм. Тухайн этгээдийн Эрүүгийн хууль зөрчсөн

11

Категорический императив / А. К. Судаков // Новая философская энциклопедия : в 4 т. / пред. науч.-ред. совета В. С. Стёпин.-2-е изд., испр. и доп.-М, Мысль, 2010.-2816 с.



зан үйл нь гадаад үйлээр илрэн гараагүй бол гэмт хэрэг болохгүй. Тийм ч учраас Эрүүгийн хуулиар гэм буруугийн зарчимд “Хүний үзэл бодол, итгэл үнэмшлийн төлөө хариуцлага хүлээлгэхгүй”<sup>12</sup> гэж заасан байдаг. Өөрөөр хэлбэл субъектын нийгэмд харш санаа бодол, итгэл үнэмшлийнх нь төлөө бус зөвхөн Эрүүгийн хуульд заасан нийгэмд аюултай, гэм буруутай үйлдлийнх нь төлөө түүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг. Аливаа үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэж үзэх шаардлагад нийгэмд аюултай, өөрөөр хэлбэл Эрүүгийн хуулиар хамгаалагдсан иргэн, нийгэм, төр, байгууллага, аж ахуй нэгжийн хуулиар хамгаалагдсан эрх ашиг, сонирхолд хохирол учруулсан, эсвэл тийм хор уршиг учрах бодит нөхцөл байхыг хамруулж үзнэ.

Профессор Г.Совд “Гэмт хэргийн нийгмийн хор аюулын хэр хэмжээ гэдэг гэмт хэргийн объектив тал буюу гэмт хэрэг үйлдсэн этгээдийн нийгэмд хор аюул учруулсны эрчим ямар хэмжээнд байсан үр дагавар, хор уршиг тэдгээрийн хоорондох шалтгаант холбоо зэргээр тодорхойлогдоно. Үүнд үйлдлээ хэрэгжүүлсэн арга, хэрэглэсэн зэвсэг хэрэгсэл, орчин, цаг хугацаа, учруулсан хохирлын хэмжээ, түүнээс уламжлах үр дагавар зэрэг олон асуудлыг хамааруулж судалсны үндсэн дээр дүгнэлт хийж болно”<sup>13</sup> гэж гэмт хэргийн нийгмийн хор аюулын хэр хэмжээг тодорхойлсноос үзвэл аливаа гэмт хэргийн хор уршгаас хэн нэгний эрх ашиг гарцаагүй хөндөгдөх нь ойлгомжтой байна.

Монгол Улсын хувьд анх 1942 оны Эрүүгийн хуульд “Хувьсгалт төр засагт эсэргүү халдсан, хууль журмыг зөрчсөн, нийтэд аюултай үйлдэл, эс үйлдлийг гэмт хэрэг”<sup>14</sup> гэж нийгэмд аюултай шинжийг гэмт хэргийн тодорхойлолтын гол агуулга болгон хуульчилсан түүхтэй. Энэ уламжлал өнөөг хүртэл хадгалагдан иржээ.

Одоо дагаж мөрдөж буй Эрүүгийн хуулийн 2.1 дүгээр зүйлд “Энэ хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцно”<sup>15</sup> гэжээ. Гэмт хэргийн нийгэмд аюултай байдлын шинж нь юуны өмнө түүний халдлагад өртөгдөн хохирол амсаж байгаа эрх ашиг, сонирхлын үнэ цэнэ, агуулгатай шууд холбоотой илрэн гардаг. Тэгвэл дэлхий нийтээр авлига, албан тушаалын гэмт хэргийг ерөнхий 3 түвшинд хувааж, илрэх хэлбэр, үр дагаврыг нь дараах байдлаар тайлбарладаг.

**Өндөр түвшний:** Авлигатай тэмцэх хуулийн үр нөлөө бага байхаар зохицуулан баталж, авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэх таатай орчныг бүрдүүлдэг. Үүний үр дагавар нь улс орны үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнолд шууд аюул занал учруулдаг.

12 Эрүүгийн хууль, (2015).

13 Г.Совд. Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар, УБ, 2002 он, 77 дахь тал.

14 С.Жанцан. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй (ерөнхий анги), УБ, 2002 он.

15 Эрүүгийн хууль, (2015).

**Дунд түвшний:** Төрийн түшмэл, шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтнууд хүнд суртал, чирэгдэл үүсгэх замаар өөртөө болон, бусдад давуу байдал бий болгодог. Энэ нь албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэргийн үндсэн шинж болдог. Үр дагавар нь хууль хэрэгжихгүй байх үндсэн шалтгаан болно.

**Доод түвшний:** Гар цайлгах, шан харамж авах зэрэг нэг удаагийн үйлдлээр илрэх авлига, албан тушаалын гэмт хэргүүд хамаарна. Үүний үр дүнд авлига байж болох зүйл юм гэсэн ойлголтыг нийгмийн сэтгэл зүйд суулгадаг.

Эдгээрээс харвал авлига, албан тушаалын гэмт хэргийн улмаас хохирох хохирогчийн цар хүрээ харьцангуй өргөн байна. Тодруулбал энэ нь ганц хүний эрх ашиг биш, гэр бүл, хамт олон, цаашлаад улс орны эрх ашиг ихээр харшилж байдаг нийгмийн аюулын шинжтэй гэмт хэрэг юм.

Энэ төрлийн гэмт хэрэг нь:

1. төрийн дээд албан тушаалтнууд, шийдвэр гаргадаг институциуд оролцдог.
2. улс орон, ард түмний нийтлэг эрх ашиг хөндөгддөг.
3. улс үндэстний тусгаар тогтнол, аюулгүй байдалд хор хөнөөл учруулдаг.

Үүний зэрэгцээ ихэвчлэн хуулийн хамгаалалтад орсон байдаг тул илрүүлэх, шалгах, хариуцлага тооцоход хүндрэлтэй байдаг.

Өргөн утгаараа авлига, албан тушаалын гэмт хэргээс болж улс орон, ард иргэд, улс орны цаашдын хөгжил дэвшил, ирээдүй, хойч үе хохирно. Цаашлаад улс орны нэр төр унах, өөр улсын хараат байлдалд орох зэргээр улс орон төр засаг бүхэлдээ хохирно гэж үзэж болно. Авлигын асуудлаас болж ард иргэд төр засагтаа итгэхээ больдог талаар ч дурдаж болно.

Тэгвэл хүний эрх хаана хөндөгдөж байна вэ?

... дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2013 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн ... дугаар тогтоолоор ... дугаартай эрүүгийн хэрэгт оногдуулсан шийтгэх тогтоолд:

“Шүүгдэгч Б.Д нь Нийслэлийн захирагчийн ажлын албаны Орчны бохирдолт, хог хаягдлын менежментийн хэлтсийн даргаар ажиллаж байхдаа Хот тохижилтын газрын дарга Ц.Б, ерөнхий нягтлан бодогч М.Б нартай бүлэглэн 2009 оны 1 дүгээр сараас 2010 оны 1 дүгээр сар хүртэлх хугацаанд удаа дараагийн давтан үйлдлээр:

- Захирагчийн ажлын албанаас Хот тохижилтын газарт Нийслэлийн нийтийн эзэмшлийн зам талбай, автозамуудын халтиргаа, гулгааг арилгах зориулалттай ногоон байгууламжид сөрөг нөлөөгүй химийн бодис нийлүүлэх ХБ/2009 дугаартай тендерийн гүйцэтгэлийн ажилд зарцуулахаар шилжүүлсэн 15,132,030 төгрөгийг 2009 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр Хот тохижуулах газрын данснаас бэлнээр гаргуулан;
- Хот тохижилтын газраас Сүхбаатар дүүргийн ТҮК-д халтиргаа гулгаа арилгах бодис зарж олсон орлогын мөнгө болох 13,750,000 төгрөгийг 2009 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр Г.Э-ийн нэрээр Хот тохижилтын газрын данснаас бэлнээр гаргуулан;
- Нийслэлийн Захирагчийн ажлын албаны даргын эрх шилжүүлж, хөрөнгө гаргах тухай тушаалаар “Халтиргаа гулгаа арилгах бодис” худалдан авах зориулалтаар 2009 оны 12 дугаар сарын 16-ны өдөр Хот тохижуулах газарт шилжүүлсэн 60,000,000 төгрөгийг Хот тохижуулах газрын данснаас 2009 оны 12 дугаар сарын 14-ний өдөр 15,000,000 төгрөг, 12 дугаар сарын 22-ны өдөр 15,000,000 төгрөг, 2010 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр 30,000,000 төгрөгийг тус тус бэлнээр гаргуулан цас хайлуулах бодис худалдан авч төрийн өмчийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах тухай хууль, санхүү, нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжийг давтан үйлдлээр зөрчин албан тушаалын байдлаа урвуулан ашигласан болох нь шүүгдэгч нарын шүүхийн хэлэлцүүлэгт өгсөн мэдүүлэг болон хэрэгт цугларсан хуульд заасан үндэслэл журмын дагуу цуглуулж бэхжүүлсэн нотлох баримтуудаар болон шүүх хуралдаанаар хэлэлцэгдсэн бусад нотлох баримтуудаар тогтоогдлоо.

Шүүгдэгч Б.Д, Ц.Б, М.Б нарын дээрх үйлдлээс аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн хуулиар хамгаалагдсан эрх, ашиг сонирхолд хохирол учирсан гэж үзэх үндэслэлтэй байна. Төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдаж авах хуульд заасан журмын дагуу цас хайлуулах бодис худалдан авах үйл ажиллагааг явуулсан нөхцөлд бусад аж ахуйн нэгж байгууллага уг худалдан авах үйл ажиллагаанд оролцох, түүнээс ашиг олох, үйл ажиллагаа явуулах зэрэг эрх ашиг сонирхол нь зөрчигдсөн байна гэж шүүх бүрэлдэхүүн дүгнэв<sup>16</sup> гэснээс харвал “хэрэгцээ, ашиг сонирхол, эрх зүйн зохицуулалтын шаардлагыг гүнзгий судалж тооцсон байх” гэсэн эрх зүйн хэм хэмжээг бүтээх шинжлэх ухааны үндэслэлтэй байх зарчмын дагуу нийгмийн, нийтийн, цаашлаад хүний эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх хөндөгдөж байгааг харж болно.

Чезаре Беккариа “Гэмт хэрэг болон шийтгэлийн тухай” бүтээлдээ “Нийгмийн дээд давхаргынхан, эрх баригчид гэмт хэрэг үйлдсэн нь

шийтгэгдэхгүй үлдээд байвал харьяат иргэдийн шударга ёс, үүргийн мэдрэмж устаж үгүй болно”<sup>17</sup> гэж үздэг бөгөөд энэ нь энэ төрлийн гэмт хэргийн улмаас хүний эрх зөрчигдөж буй байдал нь 300 жилийн өмнө ч гэсэн хөндөгдөж байсныг гэрчилж байна гэж ойлгож болох юм.

Түүнчлэн доктор С.Жанцан “Төр, байгууллага, иргэдийн Эрүүгийн хуулиар хамгаалагдсан эрх ашиг, сонирхолд халдсан нийгэмд аюултай, Эрүүгийн хуульд заасан гэм буруутай үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэг гэнэ. Гэмт хэрэг нь нийгмийн хор аюулын түвшин, хэр хэмжээгээрээ бусад эрх зүйн зөрчлөөс ялгагдана”<sup>18</sup> гэж авлига, албан тушаалын гэмт хэргийг тодорхойлсон байдаг.

Тэгвэл гэмт хэрэг (гэмт явдал) нь нийгэм-эрх зүйн үзэгдэл болохын хувьд нийгмийн хөгжлийн эхний шатанд эсрэг тэсрэг зөрчилтэй ангиуд үүссэнтэй шууд холбоотой гарч ирсэн түүхэн ойлголт юм гэдгийг эргэн санах нь зүйтэй.

Франц Улсын 1791 оны Эрүүгийн хуулиас эхлээд Европын хэд хэдэн улс Эрүүгийн хуульдаа гэмт хэргийг “Ялын сүрдүүлгийн дор Эрүүгийн хуулиар хориглосон үйлдэл”<sup>19</sup> гэж тодорхойлжээ. Анх гэмт хэргийн тодорхойлолтыг хуульчилсан акт бол 1789 онд Франц Улсад гарсан “Хүний болон иргэний эрхийн тунхаглал” юм. Энэ тунхаглалын 5 дугаар зүйлд “Хууль бол зөвхөн нийгэмд хортой тийм үйлдлийг хориглох ёстой. Хуулиар хориглоогүй бол саад тотгор учруулж болохгүйн нэгэн адил хуульд заагаагүй бол албадан гүйцэтгүүлж бас болохгүй”<sup>20</sup> гэж гэмт хэргийн нийгэмд аюултай, хуульд заасан материаллаг болон хууль цаазын шинжийг тодорхойлжээ. Тэгэхээр аливаа гэмт хэрэг бүр гарцаагүй хүний эрх, эрх чөлөөг зөрчиж байдаг бөгөөд харин авлига, албан тушаалын гэмт хэргийн хор уршиг нь цар хүрээ өргөн байгаад зогсохгүй цаашид үргэлжлэн учрах хохирлыг тооцох боломжгүй байдаг.

Өөрөөр хэлбэл “Авлига бол нийгэм, эдийн засагт эрүүл бус орчин бий болгож, шударга ёс, тэгш байдлыг алдагдуулдаг хууль бус сөрөг үзэгдэл байгаад зогсохгүй улс орны эдийн засгийн хөгжлийг сааруулж, эрх зүйт төрийн бодлогод сөрөг нөлөө үзүүлж улмаар тухайн орны үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнолд аюул занал учруулдаг”<sup>21</sup> нэг талаасаа нийгмийн үзэгдэл, нөгөө талаасаа нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхгүйгээр илэрдэг гэмт хэрэг юм гэдэг тодорхойлолттой санал нийлж буй хэрэг юм.

17 Чезаре Беккариа /1738-1794/, “Гэмт хэрэг болон шийтгэлийн тухай”, 1764 он.

18 С.Жанцан. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй (ерөнхий анги), УБ, 2002 он.

19 Франц Улсын Эрүүгийн хууль, (1791).

20 Хүний болон иргэний эрхийн тунхаглал, (1789).

21 “Авлига үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх нь” онол-практикийн хурлын эмхэтгэл. УБ, (2014).

Дэлхий нийтээрээ авлигагүй, эрүүл нийгэм, эрүүл эдийн засгийн төлөө тэмцэж байгаа боловч авлига, хээл хахууль нь нийгмийн хөгжлийн аль ч үе шатанд ямар нэг хэлбэр, хэмжээгээр оршин тогтносоор ирсэн билээ.

Аливаа гэмт хэргийн нийгмийн аюулыг хамгаалагдаж буй нийгмийн харилцааны үнэ цэнэ, учирсан хор уршгийн хэмжээ, нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүйн онцлог, зарим тохиолдолд гэмт хэргийн субъектийн онцлог зэргээс хамааруулан тодорхойлох бөгөөд авлига, албан тушаалын гэмт хэрэгт оногдуулж буй ялын бодлогоор нь тухайн гэмт хэргийн нийтэд хор уршгийн хэмжээг тооцож болох талтай.

Манай улсын эрдэмтэн, судлаачид 2015 оны шинэ Эрүүгийн хуулийн батлагдан гарахаас өмнөх жилүүдэд эрүүгийн эрх зүй дэх тулгамдсан асуудлын нэг болох авлига, албан тушаал, хээл хахуулийн гэмт хэрэгт хүлээлгэх эрүүгийн хариуцлагын тогтолцоог нэлээн өргөн хүрээнд шүүмжилж байсан юм. Тухайлбал өмнө дагаж мөрдөж байсан хуулийн заалтаар эрх мэдэл, албан тушаалаа урвуулан ашиглах гэмт хэрэг нь гэмт хэргийн хөнгөн, хүндэвтэр ангилалд хамаарч байсан. Тиймээс энэ төрлийн гэмт хэрэгт бага ял оногдуулснаар Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь заалтад “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно” гэсэн хүн бүр хуулийн өмнө эрх тэгш байх зарчимд нийцэхгүй байна гэж үздэг байв.

Мөн 2002 оны Эрүүгийн хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасан “Ял, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ нь гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруутай этгээдийн хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдалд тохирсон байна” гэсэн шударга ёсны зарчимд ч мөн нийцдэггүй гэж дүгнэж байжээ. Өөрөөр хэлбэл Чезаре Беккариагийн<sup>22</sup> хэлснээр “Нийгмийн дээд давхаргынхан, эрх баригчид гэмт хэрэг үйлдсэн нь шийтгэгдэхгүй үлдээд байвал харьяат иргэдийн шударга ёс, үүргийн мэдрэмж устаж үгүй болно” гэсэнтэй судлаач бүр санал нийлж байв.

Албан тушаалын буюу авлига, хээл хахуулийн гэмт хэрэг нь улс, нийгэм, иргэдийн аюулгүй байдал, амьдрах эрхэд ноцтой аюул учруулахад хүргэдэг, жирийн иргэний үйлдсэн гэмт хэрэгтэй харьцуулшгүй хүнд үр дагавартай, үйлдлийн арга, хэлбэрээрээ “сонгодог” гэмт хэрэгт тооцогдох учраас энэ гэмт хэргийн улмаас хохирч буй иргэдийн эрх ашгийг тэр бүр тодорхой тооцоолох боломжгүй өргөн цар хүрээтэй хохирол учруулдаг болохыг дахин онцолж байна.

22 Чезаре Беккариа (1738-1794), “Гэмт хэрэг болон шийтгэлийн тухай”, (1764).

#### IV. Дүгнэлт

Хүний эрх, эрх чөлөө нь жам ёсны шинжтэй бөгөөд хүн бүр төрөхөөсөө эрх чөлөөтэй, нэр төр, эрхийнхээ хувьд адил тэгш байна. Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 1 дүгээр зүйлд “Хүн бүр төрөхөөсөө эрх чөлөөтэй, нэр төр, эрхийнхээ хувьд адил тэгш байна. Тэдэнд оюун ухаан, өрлөг сэтгэл заяасан бөгөөд өөр хоорондоо ахан дүүсийн ёсоор харилцах ёстой” гэж заажээ. Монгол Улс 1992 оны Үндсэн хуульдаа хүний эрх, эрх чөлөөг олон улсын зарчим хэм хэмжээнд нийцүүлэн баталгаажуулсан байна.

Гэмт хэрэг бол нийгэмд аюултай болох нь нэгэнт тодорхой тул нийгэмд учруулж байгаа аюулынхаа хэмжээгээр хүний эрх, эрх чөлөөнд ноцтой халдаж байгаа юм гэдгийг ойлгох нь зүйтэй.

2020 оны эхний 8 сарын байдлаар улсын хэмжээнд нийт 17,790<sup>23</sup> иргэн гэмт хэрэгт өртөж хохирсон байна. Мөн эрүүгийн хариуцлага хүлээлгэх насанд хүрсэн 1,000, 10,000, 100,000 хүн тутамд ноогдох тодорхой хугацааны туршид тодорхой нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэргийн тоон үзүүлэлтийг гэмт хэргийн түвшин гэж үзэх бөгөөд 2020 оны 9 дүгээр сарын байдлаар Улаанбаатар хот 61 дүгээр байр<sup>24</sup> буюу гэмт хэргийн түвшин өндөр гэсэн үзүүлэлттэй байна.

Монгол Улсын хувьд Улаанбаатар хотын хэмжээнд гэмт хэргийн тоо, гаралт өндөр байгаа нь тэр хэмжээгээр хүний аюулгүй байдал хөндөгдөж, хүний эрх зөрчигдөх явдал өндөр байна гэж үзэж болох юм.

Статистикийн мэдээллийн нэгдсэн сангаас харвал авлига, албан тушаалын гэмт хэргийн улмаас 2020 оны эхний 8 сарын байдлаар<sup>25</sup> 12 тэрбум төгрөгийн хохирол учирсан бөгөөд нийт 20 гэмт хэрэг бүртгэгдсэн гэх тоон мэдээлэл байхаас өөр хохирогчид хандсан судалгаа мэдээлэл дутмаг байна. Тиймээс цаашид авлига, албан тушаалын гэмт хэрэгт хохирсон хохирогч, нийгэмд учруулсан хохирол үр дагаврыг, зөрчигдөж байгаа эрхийн талаарх асуудлыг нарийвчлан судлах нь зүйтэй юм.

Тухайлбал виктимология<sup>26</sup> буюу гэмт хэрэгт хохирох явдлын судалгааны арга зүйд тулгуурлан авлига, албан тушаалын гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн зан байдал, ахуй амьдрал, боловсролын түвшин, учирсан хор уршгийн талаарх мэдээллийг цуглуулж энэ төрлийн гэмт хэргээс шалтгаалан хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх боломжтой юм.

23 Монгол Улсын Цагдаагийн ерөнхий газрын дотоод сүлжээ (URL: [system.police.gov](http://system.police.gov))

24 <https://www.numbeo.com/crime/in/Ulaanbaatar>

25 [www.1212.mn](http://www.1212.mn), Статистикийн мэдээллийн нэгдсэн сан.

26 “Гэмт хэргийн статистикийн арга зүй” гарын авлага. УБ, 2019 он.

Дотоод хэргийн их сургуулийн Эрүүгийн эрх зүй, криминологийн судалгааны багаас 2017 онд нуугдмал гэмт хэргийн түвшнийг тодорхойлох оролдлого бүхий 1,449 хүнийг хамруулсан судалгааны дүнгээс харвал<sup>27</sup>:

Гэмт хэргийн нуугдмал байх магадлалыг тодорхойлох судалгааны үр дүнд Авлигын эсрэг (Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.1, 22.4, 22.5) гэмт хэрэг 18 бүртгэгдсэн боловч, үйлдэгдсэн байж болох гэмт хэргийн тоо 153, нуугдмал байж болох гэмт хэргийн тоо 135, харин гэмт хэрэгт шууд хохирсон байдлын судалгааны үр дүнд авлигын улмаас эрх ашиг нь хөндөгдсөн иргэн 1,290 буюу 89.9 хувь байгаа нь энэ төрлийн гэмт хохирогчийн тоо харьцангуй өндөр байгааг илтгэж байна.

Мөн 2019 оны шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын төсөөллийн индекс 3.86 гарсан нь өмнөх оны үзүүлэлтээс 0.18 пунктээр өссөн<sup>28</sup> талаарх тоон мэдээллийг дурдахгүй байж болохгүй. Тэгвэл энэхүү судалгааны үр дүнгээс авлига, албан тушаалын гэмт хэргийн субъектүүд нь тухайн гэмт хэрэгт хохирогчдын хөндөгдөж байгаа эрх ашгийнх нь цар хүрээнд нөлөөлөх боломжтойг харуулж байгаа юм.

Аливаа хохирол, эрх, эрх чөлөө нь зөрчигдөж байгаа тоон үзүүлэлт, хэмжээг бууруулах нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилтай салшгүй холбоотой тул энэхүү ажлыг зөв ангилж, оновчтой зохион байгуулснаар өртөж хохирох хүрээг хумих, гэмт хэргийн гаралтыг багасгах боломжтой болно.

### **Эх сурвалж:**

1. *“Авлига үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх нь” онол-практикийн хурлын эмхэтгэл, УБ, 2014 он.*
2. *Аристотель, Улс төр, Орч. Б.Даш-Ёндон, УБ, 2003 он.*
3. *Г.Совд, Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар. УБ, 2002 он, 77 дахь тал.*
4. *Категорический императив, А. К. Судаков.*
5. *“Гэмт хэргийн статистикийн арга зүй” гарын авлага. УБ, 2019 он.*
6. *“Гэмт хэрэгт хохирох явдлын судалгаа” УБ, 2017 он.*
7. *Левикова С.И.-Мораль как неотъемлемый элемент человеческого сообщества и мера человеческого в человеке.*

27 *“Гэмт хэрэгт хохирох явдлын судалгаа” УБ, 2017 он.*

28 *Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн 2019 оны судалгааны тайлан*

8. Маркс К, Энгельс Ф, *Немецкая идеология*.
9. *Политика, ок. 335-322 г. до н.э. (Аристотель)*.
10. *Правильная ссылка на статью: Левикова С.И.-Мораль как неотъемлемый элемент человеческого сообщества и мера человеческого в человеке. URL: [https://nbpublish.com/library\\_read\\_article.php?id=20566](https://nbpublish.com/library_read_article.php?id=20566)*
11. *С.Жанцан, Монгол Улсын Эрүүгийн эрх зүй (ерөнхий анги), УБ, 2002 он.*
12. *Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал, (1948).*
13. *Франц Улсын Эрүүгийн хууль, (1791).*
14. *Хүний болон иргэний эрхийн тунхаглал, (1789).*
15. *Чезаре Беккариа (1738-1794) "Гэмт хэрэг болон шийтгэлийн тухай", (1764).*
16. *Эрүүгийн хууль, (2015).*
17. *Эрүүгийн хууль, (2012).*
18. *[www.1212.mn](http://www.1212.mn) Статистикийн мэдээллийн нэгдсэн сан.*
19. *[www.shuukh.mn](http://www.shuukh.mn)*
20. *<https://www.numbeo.com/crime/in/Ulaanbaatar>*







## Я.ЦЭЛМЭН

Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн  
Эрүүгийн процессын эрх зүйн тэнхимийн дэд профессор,  
цагдаагийн хошууч, докторант

## ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЭРХИЙН БАТАЛГААЖИЛТ БА ХЯЗГААРЛАЛТ

## GUARANTEES AND RESTRICTIONS ON THE RIGHTS OF LEGAL ENTITIES

**Хураангуй:** Хуулийн этгээдийн эрхийн баталгаажилт, хязгаарлалтын талаар хууль тогтоогчдын зүгээс сүүлийн жилүүдэд анхаарч Иргэний хууль, Компанийн тухай хууль зэргээс гадна, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Зөрчлийн тухай хууль, Зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Цагдаагийн албаны тухай зэрэг хуулиудаар эрх зүйн харилцааг зохицуулахаар өргөтгөсөн. Хэдийгээр хуулийн этгээдийн ойлголт нь Монгол Улсын хувьд шинэ ойлголт биш боловч бидэнд эрх зүйн болон эдийн засаг, хүний эрх, компани, корпорацийн онолын хүрээнд гүнзгий судлах шаардлага тулгарч байна. Тухайлбал хуулийн этгээдтэй холбоотой эрүүгийн болон зөрчлийн хэргийн шийдвэрлэлтийн статистик мэдээнээс дүгнэхэд шалгаж, шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтнуудын хувьд шинэ ойлголт гэдэг нь ойлгомжтой байна. 21 дүгээр зуунд хуулийн этгээдийн талаарх ойлголт олон талт, өргөн хүрээтэй судлагдахуун болжээ.

Бид дэлхийн туршлагаас судлахаас гадна өөрийн орны үндэсний эрх зүйн түүхэн уламжлалын гүнд судалгааны ажлаа чиглүүлэхийг зорьж байна. Хуулийн этгээдийн улс гэр, нийгэм нийтэд үзүүлэх нөлөө нь эерэг

ба сөрөг үр дагавартай байдгийг түүх бидэнд сургамжилж үлдээсэн байх бөгөөд орчин цагийн онолоор тэднийг үйл ажиллагааных нь зорилго, цар хүрээгээр зөв тодорхойлж, эрх зүйн зохицуулалтаа үндэсний хэмжээнд улам боловсронгуй болгох шаардлагатай юм. Иймээс хуулийн этгээдийн эрхийн баталгаажилт ба хязгаарлалтын талаарх эрх зүйн зохицуулалтын талаар онолын ойлголт, уламжлал, шинэчлэл, үндэсний ба дэлхийн практикт тулгуурласан судалгааныхаа хүрээнд зарим асуудлаар дүгнэлт хийж, санал дэвшүүлэхийг зорилоо.

**Түлхүүр үг:** Эрх зүйн онол, уламжлал, эрх зүйн шинэчлэл, дэлхий нийтийн чиг хандлага, эрх, үүрэг, хариуцлага, үндэсний эрх зүйн тогтолцоо, компани, корпораци, групп, хамтын хариуцлага.

**Abstract:** In recent years, legislators have focused on guaranteeing and restricting the rights of legal entities and have expanded to regulate legal relations through laws such as the Civil code, the Company law, the Criminal code, the Criminal procedure code, the Infringement code, the Infringement procedure code, and the Police service law.

Although the concept of a legal entity is not new to Mongolia, we need to study it in depth within the legal and economic, human rights, company and corporate theory. For example, from the statistics on the resolution of criminal and infringement cases related to legal entities, it is clear that this is a new concept for officials with the authority to investigate and resolve. In the 21st century, the concept of a legal entity has become a multifaceted and wide-ranging subject.

In addition to studying world experience, we aim to focus our research on the depths of our country's national legal history and tradition.

History has taught us that the impact of legal entities on the country and society has both positive and negative consequences, and modern theory needs to define these consequences in terms of the purpose and scope of their activities and improve the legal framework at the national level.

Therefore, we aim to make conclusions and make suggestions on some issues within the framework of our research based on theoretical understanding, traditions, innovations, and national and world practices on the legal regulation of guarantees and restrictions on the rights of legal entities.

**Keywords:** Legal theory, tradition, legal reform, global trends, rights, duties, responsibilities, national legal system, companies, corporations, groups, joint responsibility.

## I. Оршил

Хуулийн этгээдийн үндсэн философи нь “хүмүүс нэгдэж хүний төлөө” гэсэн ойлголт байдаг. Хүний эрхийн онол, хөгжлийн онол, эдийн засгийн онолын хүрээнд энэ асуудлыг томъёолж хөндөх нь зүйтэй байна.

Монгол Улсын эрх зүйн зохицуулалтын хүрээнд хуулийн этгээдийн талаар иргэний эрх зүйн салбарт эрхийн баталгаажилт ба хязгаарлалтын талаар авч үзэж байсан. 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа шинэ Эрүүгийн хууль<sup>1</sup>, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай<sup>2</sup>, Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай<sup>3</sup> хуулиудад хуулийн этгээд нь эдгээр салбар эрх зүйн харилцааны субъект болсон.

1990 оноос өрнөсөн улс төр, хууль эрх зүй, нийгэм, эдийн засгийн өөрчлөлтийн үр нөлөөгөөр сүүлийн жилүүдэд манай улсын бүхий л харилцаанд хуулийн этгээдийн гүйцэтгэж байгаа үүрэг, оролцоо, зөв ба буруу нөлөөлөл өдөр бүр нэмэгдэж байна. Манай улстай ижил нөхцөл байдалд байсан пост-социалист хэмээн нэрлэгддэг Унгар, Польш, Румын зэрэг улсад ч сүүлийн жилүүдэд эрх зүйн орчны шинэчлэлийг түлхүү хийж, хуулийн этгээдийн эрхийг захиргаа болон эрүүгийн эрх зүйн харилцаагаар баталгаажуулах, хязгаарлах, хариуцлага хүлээлгэх зарчмыг тодорхойлж байна.

Монгол Улсын тухайд хуулийн этгээдийн талаар ийнхүү онцгой анхаарч эрх зүйн зохицуулалтыг өргөжүүлж байгаа нь дараах хэд хэдэн суурь нөхцөл бүрдсэнтэй холбоотой. Үүнд:

- Хуулийн этгээдийн нийгэмд үзүүлж байгаа эерэг ба сөрөг оролцоо нөлөөлөл огцом нэмэгдсэн;
- Хуулийн этгээдийн эдийн засгийн чадавх ба нийгэмд эзлэх байр суурь өргөжсөн;
- Улс, үндэстэн дамнаж үйл ажиллагаа эрхэлдэг томоохон компани, корпорациудын үйл ажиллагаа нь улсын эдийн засаг болон үндэсний аюулгүй байдалд нөлөөлж эхэлсэн;
- Хуулийн этгээдийн байгаль орчинд нөлөөлөх нөлөөлөл улс орны эдийн засгийн засгийн онцлогоос, эрхэлж буй аж ахуйн хэлбэрүүдээс шалтгаалан ихэссэн;

1 Төрийн мэдээлэл, УБ, 2016 он, №7.

2 Төрийн мэдээлэл, УБ, 2017 он, №23.

3 Төрийн мэдээлэл, УБ, 2017 он, №24.

- Хуулийн этгээдээс явуулж байгаа үйл ажиллагаа нь иргэний эрх зүйн харилцаанаас хэтэрч эрүүгийн эрх зүй, эрүүгийн процессын эрх зүй болон эрх зүйн бусад харилцаагаар зохицуулах шаардлага үүссэн;
- Хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг, зөрчлийн өмнөөс тодорхой албан тушаалтан, төлөөний этгээд хариуцлага хүлээж байгаа нь хуулийн этгээдэд үзүүлэх шийтгэл үр нөлөөтэй болж чаддаггүй;
- Хуулийн этгээдийн үйл ажиллагаа явуулах эрхийн баталгаажилт, эрх зүйн орчныг сайжруулах шаардлага үүссэн;
- Хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг, зөрчлийг зөв нотлох, хохирол, хор уршгийг бодитой тооцож нөхөн төлүүлэх, тэдгээрийг гэмт хэрэг, зөрчил үйлдүүлэхгүй байх талаар урьдчилан сэргийлэх боломж бүрдүүлэх зэрэг болно.

## II. Хуулийн этгээдийн ойлголт, мөн чанар

Хуулийн этгээд гэх нэр томъёо нь латин хэлэнд “UNIVERSITATES” буюу хамтран байгуулах, хамтран бий болгох, цогц бүрдэл гэх утгыг илэрхийлдэг байна<sup>4</sup>.

Дэлхийн улс орнуудын үндэсний эрх зүйн тогтолцоо болон эрх зүйн бүлийн онцлогоос хамааран хуулийн этгээдийн олон төрлүүд байдаг бөгөөд тэдгээрийн нэршил нь эрх зүйн тогтолцоо, практик, заншил зэргийн улмаас хууль тогтоомжид нь өөр өөрөөр нэршсэн байдаг. Тухайлбал хуулийн этгээд-legal entity, бизнесийн байгууллага-business entity, компани-company, корпораци-corporate, нөхөрлөл-partnership, холбоо-association, хоршоо-cooperative, сан-foundation гэх мэт.

Англи хэлнээ хуулийн этгээдийг “Legal entity” гэсэн нэр томъёогоор илэрхийлэх ба Кембрижийн толь бичигт “Хуулийн этгээд гэж хууль зүйн эрх эдэлж, хариуцлага хүлээдэг компани болон байгууллага юм. Тухайлбал гэрээ хийх эрхтэй, өр төлбөрөө төлөх хариуцлага хүлээдэг” гэжээ. Хууль зүйн толь бичиг дээрх тодорхойлолт дээр нэмээд нэхэмжлэл гаргах эрхтэй, хууль бус үйл ажиллагааныхаа төлөө хариуцлага хүлээх чадвартайг нэмж тодорхойлжээ<sup>5</sup>.

Монгол Улсын Иргэний хуулийн<sup>6</sup> 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт “Өмчлөлдөө буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхдээ тусгайлсан хөрөнгөтэй, өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээдэг, үйл ажиллагаанаасаа бий болох үр дагаврыг эд хөрөнгөөрөө хариуцдаг,

4 Д.Баярсайхан, “Хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлага”, УБ, 2013 он, 7 дахь тал.

5 Б.Одонгэрэл, “Хуулийн этгээдэд хүлээлгэх хариуцлага, Хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл”, УБ, 2020 он.

6 Төрийн мэдээлэл, УБ, 2002 он, №7.

нэхэмжлэгч, хариуцагч байж чадах, тодорхой зорилго бүхий, тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг зохион байгуулалтын нэгдлийг хуулийн этгээд гэнэ” хэмээн тогтоожээ.

Хуулийн этгээдийг ерөнхийд нь хувийн эрх зүйн болон нийтийн эрх зүйн хуулийн этгээд гэж ангилдаг. Хувийн эрх зүйн хуулийн этгээд нь хувийн зорилгыг хэрэгжүүлэхээр нэгдсэн, хувийн эрх зүйн хэм хэмжээнд тулгуурлан зохион байгуулагддаг бөгөөд дотор нь ашгийн төлөө ба ашгийн төлөө бус гэж ангилдаг ба ашгийн төлөө-for-profit, ашгийн төлөө бус-nonprofit, not-for-profit буюу non business entity, non-commercial organization гэж нэршдэг. Нийтийн эрх зүйн хуулийн этгээд нь нийтийн зорилгыг хэрэгжүүлэхээр нийтийн эрх зүйн хууль тогтоомжид тулгуурлан зохион байгуулагддаг бөгөөд тэдгээрт төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд (төрийн өмчит-state owned corporation, company гэх мэт.) буюу “Эрдэнэт үйлдвэр” ХХК, төрийн өмчийн байгууллагууд буюу улсын сургууль, сүм хийд, төрийн чиг үүргийг хэрэгжүүлэгч бусад байгууллагууд буюу улсын радио, телевиз зэргийг ойлгож болно.

Дэлхийн бусад улс орнуудад хуулийн этгээдийн олон янзын нэршлүүдийг хэрэглэдэг бөгөөд заримаас нь дурдвал тухайлбал нээлттэй хувьцаат компани-public corporation, company, хамтарсан үйлдвэр, хамтарсан хөрөнгө оруулалттай үйлдвэр, аж ахуйн газар-joint venture, хувийн хязгаарлагдмал компани-private limited company, төрийн бус байгууллага-non-governmental organization, сангууд-foundations, donation гэх мэт. Харин итгэлцэл дээр суурилсан эдгээр нэгжийг нийтийн эрх зүйн тогтолцоонд хуулийн этгээд гэж үздэггүй. Үүнд: итгэлцэл дээр суурилсан нэгж-trust, буюны байгууллага-charities<sup>7</sup> зэрэг болно.

Хуулийн этгээдийн гэмт хэрэг гэдэгт хүмүүс өөрсдийн хууль ёсны мэргэжлээрээ ажиллаж байгаа байгууллагынхаа ашиг сонирхлын үүднээс үйлдсэн цагаан захтны гэмт хэргийн тухай ойлголтыг хамруулдаг байна. Эдгээр хүмүүс ерөнхийдөө өөрсдийгөө гэмт хэрэгтэн гэж боддоггүй, мөн тэдний үйл ажиллагааг гэмт хэрэгт хуулиар тооцдоггүй гэж хөнгөмсөгөөр найддаг. Хуулийн этгээдийн гэмт хэргийн онцлог нь мэргэжлийн гэмт хэрэг бөгөөд ашиг олох сонирхол бүхий хүмүүс, тэдгээрийн бүлэг үйлддэг.

“Компанийн хариуцлага” гэсэн ойлголт энд чиглэгдэнэ. Криминологийн хувьд корпорацийн гэмт хэрэг гэдэг нь корпорацийн (өөрөөр хэлбэл үйл ажиллагаагаа удирдаж буй хувь хүнээс тусдаа хууль ёсны хувийн шинж чанартай аж ахуйн нэгж), эсвэл корпораци буюу бусад аж ахуйн нэгжийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулдаг хувь хүмүүсийн үйлдсэн гэмт

хэргийг хэлдэг. Хамгийн ноцтой корпорацийн гэмт хэргийн хувьд түүнийг шүүхээс татан буулгах асуудал тулгардаг бөгөөд заримдаа «аж ахуйн нэгжийн цаазаар авах ял» гэж нэрлэдэг. Энэ нь корпорацийг татан буулгах эсвэл бүрмөсөн зогсоох хууль ёсны журам юм.

Хуулийн этгээдийн гэмт хэргийг цагаан захтны гэмт хэрэг гэсэн ойлголт түгээмэл байна. Учир нь корпорацийн ашиг сонирхлыг төлөөлж чадах хүмүүсийн олонхи нь цагаан захтан, мэргэжлийн хүмүүс байдаг;

Хуулийн этгээдийн гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт хэрэг гэж үздэг учир нь гэмт хэрэгтнүүд корпорацийг гэмт хэрэг үйлдэх зорилгоор, эсвэл гэмт хэргээс олсон орлогыг нь угаах зорилгоор тээврийн хэрэгсэл болгон байгуулж болно. Дэлхийд гарч буй гэмт хэргээс олж буй орлого нь дэлхийн худалдааны 20 хувьтай тэнцэж байгаа бөгөөд<sup>8</sup> корпорацийн гэмт хэрэг, олон контекстээс харахад гэмт хэрэг үйлдэх боломж нь корпораци ба төрийн хоорондын харилцаанаас үүсдэг.

## **А. Хуулийн этгээд нь эрх, үүргийн субъект болох нь**

Эрүүгийн эрх зүйн уламжлалт хандлагад эрүүгийн хариуцлагыг бие махбод, зүрх сэтгэл, сүнслэг биетэй буюу хүнд л хүлээлгэнэ гэх ойлголт давамгайлж байлаа. Нэг үгээр эрүүгийн хариуцлага хүлээх субъект нь хүн байх тухай сургаал, үзэл номлол их эдүгээ хүртэл хүчтэй байна. Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага оногдуулахын тулд уламжлалт хандлагаас өөр өнцгөөр асуудалд хандаж үзэх хэрэгтэй болно.

Хуулийн этгээд нь “гэмт хэргийн субъект” буюу “эрүүгийн хариуцлага хүлээх этгээд” байж болохыг хүлээн зөвшөөрсөн эрх зүйн үндэслэл нь 1946 оны Нюрнбергийн процесс дахь олон улсын баримт бичгүүдэд анхлан тусгагджээ<sup>9</sup>.

Төр бол “нийгмийн гишүүд”-ийн эсрэг үйлдсэн гэмт хэрэгт үндэслэн түүхэн хөгжлийн явцад бүрэлдэж ирсэн “шийтгэл” гэдэг эрх зүйн үр дагаврыг оноож “яллах, буруутгах” замаар тухайн нийгэм дэх хэв журам, ашиг сонирхлыг сахин хамгаалах тогтолцоо (нийгмийн гишүүдийн хамтын амьдралыг хамгаалах суурь тогтолцоо) юм гэдэг тал дээр нэгдмэл байна гэж үзье. Энэ нь хуульд заагаагүй бол хэнд ч гэмт хэрэг үйлдсэнд тооцож хариуцлага хүлээлгэхгүй (идэвхгүй) байх зарчим, хариуцлагын зарчим агуулагдах, агуулагдаж ирэх гэдэгтэй адил байгаа боловч энэ тохиолдолд “эрүүгийн хариуцлага” нь (жишээлбэл нийгмийн эсрэг чиглэсэн аюултай шинж чанарыг агуулаагүй) бодлоготой хүсэл зоригийн илэрхийлэлд үндэслэсэн үйлдэл (physical defendece)-ийн объектив шинж, үр дүнтэй

8 (de Brie 2000).

9 Д.Баярсайхан, “Хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлага”, УБ, 2013 он, 29 дэх тал.

холбоотой зүйл, зөвхөн “бодгаль этгээд”-д холбоотой гэж үзэх хандлага байдаг<sup>10</sup>.

Хуулийн этгээд нь хууль эрх зүйн хувьд эрх эдэлж үүрэг хүлээж, эрх зүйн үр дагаврыг бий болгодог болгодог субъект (legal fiction) гэж үзэж болно. 1980-аад оноос эрүүгийн эрх зүйн онолын салбарт хуулийн этгээдийн оршин буй тухай болон түүний үйлдэл, үйл ажиллагаа нь нийгэмд аюултай байгаа талаар хүлээн зөвшөөрч эхэлсэн байдаг. Хуулийн этгээд нь хэдийгээр улс орны эдийн засагт чухал нөлөөтэй боловч үүний хажуугаар тэдний холбогдсон мөнгө угаах төрлийн хэргүүд нь нийгэмд учруулах хохирлоороо үлэмж байсан. Ялангуяа Америкийн Нэгдсэн Улс, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс зэрэг улсууд хуулийн этгээдэд илүү анхаарлаа хандуулсан. Эдгээр улсуудад хуулийн этгээдийн фикцийн онол<sup>11</sup> ихээхэн дэлгэрсэн байсан ч хуулийн этгээд бодитоор оршин тогтнож байгааг хүлээн зөвшөөрсөн юм. Өөрийн бодгаль бие, оюун санаа, сүнслэг байдалгүй хийсвэр зүйлд гэм бурууг халдаах ёсгүй гэсэн эрүүгийн эрх зүйн уламжлалт ойлголтыг АНУ-ын Холбооны шүүх анх удаа өөрчилсөн. Гэм хор учруулснаас үүсэх үүрэг буюу ажил олгогч, ажилтны харилцаанд тулгуурлаж хуулийн этгээд өөрийн ажилтны үйлдсэн гэмт үйлдлийн төлөө хариуцлага хүлээх иргэний эрх зүйн зарчмыг эрүүгийн эрх зүйд татан авч тайлбарласнаар дам хариуцлага хүлээх (imputation doctrine<sup>12</sup>) эрх зүйн зохицуулалтыг бий болгожээ.

Дээрх зохицуулалтаас үүдээд АНУ-ын загвар буюу хуулийн этгээд өөрийн бүх ажилтнуудаас үйлдсэн гэмт хэргийн төлөө эрүүгийн эрх зүйн хариуцлага хүлээх тогтолцоо бий болсон. Харин энэхүү загварыг Их Британийн хувьд хуулийн этгээд зөвхөн өөрсдийн удирдах албан тушаалтын үйлдэл, эс үйлдэхүйн улмаас эрүүгийн хариуцлага хүлээх<sup>13</sup> болгон авч хэрэгжүүлсэн байна.

## **Б. Хуулийн этгээдэд хуулийн хариуцлага хүлээлгэх чиг хандлага ба олон улсын жишиг**

“Хууль зүйн хариуцлага гэж гэмт халдлагаас иргэд байгууллагын аюулгүй байдлыг хамгаалах, гэмт халдлагад өртөгдсөн этгээдийн зөрчигдсэн эрхийг нөхөн сэргээж, хохирлыг арилгах, эрх зүйн хэм хэмжээ зөрчсөн этгээдэд ял зэмлэл хэрэглэх төрийн албадлагын арга хэмжээ юм”<sup>14</sup> гэж тодорхойлсон.

10 Ито Кэсүкэ, (Япон Улсын Кэйогийн Их сургуулийн Мэргэжлийн хуульч бэлтгэх сургуулийн Эрүүгийн тэнхимийн багш) “Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх онолын үндэслэгээ ба практик шаардлага”, Эрүүгийн эрх зүйн шинэтгэл: Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудал, Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, УБ, 2017, 10-11 дэх тал.

11 Хуулийн этгээдийн фикцийн онолын төлөөлөгч Германы хуульч К.Ф.Савиний юм. Тэрээр 19 дүгээр зуунд үүссэн эрх зүйн дэг сургуулийн удирдагч. Хуулийн этгээдийн эрх зүйн харилцааны бодит субъект бол эрх бүхий хувь хүн юм гэж үздэг нь фикцийн онолын гол үзэл санаа байдаг.

12 V.S.Khanna, *Corporate Criminal Liability: What Purpose does it Serve*, Har.L.Rev. 109 (1996), page 1488.

13 Celia Wells, *Corporations and Criminal Responsibility*, page 85 (Oxford University press 2nd ed. 2005).

14 Ч.Нямсүрэн, Эрх зүйн онол. УБ, 2010, 394 дэх тал.

Хуулийн этгээдийн ашиг сонирхол, ашгийн төлөө зорилго, түүндээ хүрэх арга зам, хүн хүч, санхүүгийн боломж нь дэлхийн нийтийн амьдралд хүчтэй нөлөөлөх болсон энэ цаг үед тэдгээрийн үйл ажиллагааг хэрхэн хуульчилж, хууль зөрсөн тохиолдол гэдгийг яаж тодорхойлж, хариуцлагыг үр нөлөөтэй тооцох тухай асуудал улс орнуудын анхаарлын төвд ороод байна.

Судлаачид хууль зүйн хариуцлага хүлээлгэх үндэслэлийн талаар тодорхойлсон байдаг. Тухайлбал доктор Д.Баярсайхан хууль зүйн хариуцлага хүлээлгэх үндэслэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

1. Эрх зүйн хэм хэмжээний актын тодорхой заалт зарчмыг зөрчиж, эрх зүйн үр дагавар бий болсон байх;
2. Эрх зүйн зөрчилд тодорхой этгээд буруутай байх;
3. Гэм буруу нь үйлдэл хийгээд хохиролтой шалтгаант холбоотой байх;
4. Эрх зүйн зөрчилд нь хууль зүйн хариуцлагын тодорхой санкц хэрэглэх боломжтой байх;
5. Цаг хугацааны хувьд тухайн санкцийг хүлээлгэх нөхцөл хангагдсан байх зэрэг болно. Уг хариуцлагыг оногдуулахдаа тухайн факт шалгагдах, нотлогдох эсэх, хуульд заасан үндэслэл, журамд нийцсэн эсэх, хөөн хэлэлцэх хугацаанд багтах эсэх зарим нөхцөл байдлыг харгалзан тогтоох учиртай<sup>15</sup>.

Дэлхий нийтийн хууль зүйн практикт хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэдэг дараах төрлүүд байна. Үүнд:

- Эрүүгийн эрх зүйн хариуцлага
- Захиргааны болон зөрчлийн хариуцлага
- Иргэний эрх зүйн хариуцлага
- Нийгмийн болон ёс зүйн хариуцлага
- Бизнесийн хариуцлага



15

Д.Баярсайхан, "Эрх зүйн онол", УБ, 2016 он, 167-168 дахь тал.



### Хуулийн этгээдийн гэмт хэргийн үзэл баримтлал

Хуулийн этгээд тухайлбал корпорацийн гэмт хэргийн үзэл баримтлалын гарал үүслийг АНУ-ын криминологич Эдвин Саутерландтай холбодог. Америкийн Социологийн холбоонд тэрээр 1939 онд хандан нийгмийн шинжлэх ухаанд цагаан захтны гэмт хэргийн тухай ойлголтыг анх танилцуулж байсан нь энэ ойлголтыг нийтэд түгээсэн гэж үзэх боломжтой. Тэрбээр цагаан захтны гэмт хэргийг “ажил мэргэжлээрээ нийгмийн хүндлэл хүлээсэн, өндөр статустай хүний хийсэн гэмт хэрэг” гэж тодорхойлсон. Энэхүү үзэл баримтлал нь гэмт хэргийн мөн чанарын онолын үзэл бодлыг эрс өөрчлөх чиглэлийг илэрхийлсэн юм. Хожим нь Саутерланд бараг л зөвхөн корпорацийн гэмт хэрэгт төвлөрч, судалгаа шинжилгээ хийсэн байна. Тэрээр 1949 онд “Цагаан захтны гэмт хэрэг” нэртэй номыг бичиж нийтийн хүртээл болгосон байдаг. Тэрээр шүүх, комиссын албан ёсны бүртгэлийг ашиглан 40 жилийн хугацаанд шалгагдсан 70 корпораци нь дор хаяж нэг хууль тогтоомж зөрчсөн, эсвэл хуурамч зар сурталчилгаа, патентын гэх мэт сөрөг шийдвэр гаргасан болохыг олж мэдсэн. Ялангуяа дайны үеийн худалдааны зөрчил, үнийг тогтоох, залилан мэхлэх, эсхүл буруу бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх, худалдах, ихэнх хуулийн этгээд нь рецидивист (давталт гаргагчид) шинжтэй, тус бүрдээ дунджаар найман гэмт хэргийн шинжтэй шийдвэр гаргасан байдаг. Саутерланд хэлэхдээ сонины гарчгийг “Гудамжинд гарч буй гэмт хэрэг” сэдэв эзэлдэг бөгөөд “Хуулийн этгээдийн гэмт хэрэг” анзаарагдахгүй хэвээр байна гэжээ. Цагаан захтны гэмт хэрэг нь гудамжны гэмт хэргээс хамаагүй их хохирлыг нийгэмд учруулж байсан ч ихэнх хэргүүд нь Эрүүгийн хуульд хамрагдалгүй иргэний болон захиргааны зөрчил гэж тооцогддог байв<sup>16</sup> гэжээ.

### Корпорациуд ба гэмт хэрэг

Ихэнх криминологичид цагаан захтны гэмт хэргийг хуулийн этгээдийн болон гэмт хэргийн (хууль ёсны мэргэжлээрээ ажиллах явцад үйлдсэн гэмт хэрэг, өөрсдийн ашиг тусын тулд) гэсэн хоёр үндсэн төрөлд хуваадаг. Ихэнх корпорацийн гэмт хэрэгтнүүд тэдний үйл ажиллагааг гэмт хэрэг гэж үздэггүй гэдэгт итгэдэг бөгөөд учир нь ихэвчлэн тэдний ажил мэргэжлийн орчинд байдаг зөрчлөөс ялгардаггүй. Хуулийн этгээд дэх гэмт хэрэгтнүүд нийгэмд хуулийн дагуу үйл ажиллагаа явуулж байгаа мэтээр ойлгогдож, гэмт хэрэгт холбогдоогүй байдаг. Тэдний зохисгүй үйлдлийг ихэвчлэн ижил ажил мэргэжлийн орчинд л гэмт хэрэг хэмээн албан бусаар баталдаг.

Саутерландын судалгаа анхдагч байсан хэдий ч 1975-1976 онд АНУ-ын криминологич Маршалл Клинард, Питер Иегер нар “Хууль бус корпорацийн зан байдал” хэмээх анхны томоохон цогц судалгааг хийх хүртэл цагаан захтны үйлддэг гэмт хэргийн талаарх сэдвийг нийгэм бага

зэрэг анхаарч байжээ. Энэхүү судалгаанд АНУ-ын хамгийн том бөөний болон жижиглэнгийн худалдаа, үйлчилгээний байгууллагуудын эсрэг холбооны 25 агентлагаас гаргасан, дуусгавар болгосон засаг захиргааны, иргэний болон эрүүгийн үйлдлийг системтэй мөрдөн шалгах ажилд хамруулсан байна. Саутерланд гучин хэдэн жилийн өмнө нээсэн ижил төстэй хэв маягийн ихэнх нь хэвээр хадгалагдаж байжээ. Томоохон корпорациудын 60 орчим хувь нь нийгмийн эсрэг дор хаяж нэг хууль эрх зүйн зөрчлийн арга хэмжээ авсан бол хамгийн зальтай компаниуд буюу корпорациудын 8 хувь нь ихэнх гэмт хэргийг (нийт гэмт хэргийн 52 хувь) үйлдсэн байна. Бүх зөрчлийн тал хувийг нефть, эм үйлдвэрлэл, автомашины үйлдвэрлэл эзэлж байжээ. Харин хуулийн этгээдийн зөрчил гаргасан хүмүүст хүлээлгэх шийтгэл хэвээр байв.

### АНУ дахь корпорацийн гэмт хэрэг

АНУ-д бизнесийн тодорхой үйл ажиллагааг XIX зууны эхэн үеэс хууль бус гэж үздэг болсон. Тухайлбал хуурамч зар сурталчилгаа, худалдааг хязгаарлах, банкны луйвар, аюултай бүтээгдэхүүн буруу үйлдвэрлэх, хуурамч үнэт цаасны борлуулалт, патентын зөрчил, хүрээлэн буй орчны бохирдол зэрэг юм. АНУ-ын Холбооны Засгийн газраас баталсан олон зохицуулалтын хуулиудын эхнийх нь 1890 оны Шерман Монополийн эсрэг хууль байсан бөгөөд энэхүү хууль нь үнийг тогтоох, монополь байгуулахаас урьдчилан сэргийлэх зорилготой байв. Аж ахуйн нэгжийн зөрчлийг мөрдөн шалгах ажлыг гол төлөв холбооны болон муж улсын зохицуулах агентлагууд явуулдаг байна. Ийм агентлагуудын зарим жишээ бол Холбооны Худалдааны хороо (FTC), Байгаль орчныг хамгаалах газар (EPA), Холбооны төв комисс (FCC), Хүнс, мансууруулах бодисын захиргаа (FDA), Улс хоорондын худалдааны комисс (ICC) зэргийг дурдаж болно. Комисс (NRC), Үнэт цаас, биржийн комисс (SEC), Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлага (OSHA) зэрэг агентлагууд өөрсдийн хуулийг хэрэгжүүлэхэд ашигладаг хэд хэдэн хориг арга хэмжээг авдаг байв. Үүнд: анхааруулга, сануулга, тушаал, эрх хасах, мөнгөн торгууль, эрүүгийн шийтгэл орно.

Америкт төвтэй үндэстэн дамнасан корпорацитай холбоотой олон улсын дуулиантай холбоотойгоор АНУ-ын Конгресс 1977 онд бизнесийн гэрээ байгуулахдаа хээл хахуул өгөхийг хориглосон “Гадаадын авилгын тухай хууль” баталсан. 1996 онд АНУ болон бусад 26 орон авилга хээл хахуулийг хориглохоор тохиролцжээ. Төрийн албан хаагчдын ийм хээл хахууль нь олон улсын худалдааг муутгаж, шударга худалдааг алдагдуулж, төрийн албан тушаалтнуудын авилгын гэмт хэргийг өөгшүүлдэг.

### Хуулийн этгээдийн гэмт хэрэгтэй тэмцэхэд тулгамдаж буй асуудал

Корпорациуд холбооны хүнд суртлын дарамт, хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар гомдоллож болох ч гэм буруутай компаниуд Засгийн газартай заргалдах мэдлэг чадвар, боловсон хүчин, цаг хугацаа зарцуулах боломжтой байдаг. Хуулийн этгээдийн зөрчлийг шалгах агентлагууд хүчирхэг корпорациудын эсрэг хууль хэрэгжүүлэх нь үр дүнгүй байна гэж шүүмжлэлийг их өрнүүлдэг. Ихэнхдээ хууль зөрчигчдөд хүлээлгэх шийтгэл нь түүний хууль бус үйлдлийг зогсоох, учирсан хохирлыг нөхөн төлүүлэх үүрэг гүйцэтгэхэд хэтэрхий бага байдаг. Цагаан захтнуудад ял оноох нь бага бөгөөд тэд шоронд хоригдох нь ховор байдаг. Томоохон хуулийн этгээдүүд өөрсдийн салбаруудын захирал болон хуулийн хэлтсийн даргаар урьд нь хуулийн этгээдүүдийг шалгах, зохицуулах агентлагуудад ажиллаж байгаад тэтгэвэрт гарсан мэргэжилтнүүдийг ажилд авах сонирхолтой байдаг байна. Нэмж дурдахад Засгийн газраас хуулийн этгээдийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэхэд хуваарилдаг мөнгөний хэмжээ нь гудамжны гэмт хэрэгтэй тэмцэхэд зориулагдсан мөнгөнөөс хамаагүй бага байдаг<sup>17</sup>.

АНУ-ын Дээд шүүхийн 1886 оны шийдвэрээр Санта-Клара тойрогт, Номхон далайн өмнөд төмөр замын 118 АНУ 394 (1886) корпорацийг “этгээд /person/” гэж хууль ёсоор тодорхойлж болно гэж АНУ-ын янз бүрийн шүүхүүдэд мэдэгдсэн байдаг. АНУ-ын Үндсэн хуульд оруулсан арван дөрөв дэх нэмэлт өөрчлөлтөд энэ талаар дурдсан байна.

Англи улсын хуульд үүнийг *Salomon v Salomon & Co* [1897] AC 22-ийн шийдвэрээр тохирчээ. Австрали Улсын хуулиар 2001 оны корпорациудын тухай хуулийн дагуу (Cth) корпорац нь хууль ёсоор “хуулийн этгээд /legal person/” гэсэн байдаг<sup>18</sup>.

АНУ-ын хуулиар корпорацийн эрүүгийн хариуцлага хүлээх чадавхыг хүлээн зөвшөөрдөг. Францын хуулиар одоогоор компанийн эрүүгийн хариуцлага хүлээх чадавхыг хүлээн зөвшөөрдөг. Герман Улсын хууль нь корпорацийн эрүүгийн хариуцлага хүлээх чадавхыг хүлээн зөвшөөрдөггүй. Герман Улс нь корпорациудад зөрчлийн шийтгэл оногдуулдаг<sup>19</sup>. Компанийн буруутай үйл ажиллагааг зохицуулах олон улсын гэрээг ингэснээр зөвшөөрөх хандлагатай байдаг боловч корпораци эрүүгийн хариуцлага хүлээхгүй гэсэн зарчим үйлчилдэг байна.

<sup>17</sup> Frank E. Hagan.

<sup>18</sup> [https://en.wikipedia.org/wiki/Corporate\\_crime](https://en.wikipedia.org/wiki/Corporate_crime)

<sup>19</sup> (Ordnungswidrigkeiten).

## Хууль сахиулах бодлого

Корпорацийн гэмт хэрэг зарим оронд төр засгийн хэмжээнд анхаардаг болсон. Тухайлбал Их Британид төмөр замын сүлжээ болон далайд гарсан ослыг олон нийтэд корпорацийн хүн амины хэрэг гэж нэрлэн хэрэглэгддэг бөгөөд бизнесийн аж ахуйн нэгжүүдэд учирдаг технологийн аюулын талаар илүү их хэлэлцүүлэг зохион байгуулдаг байна<sup>20</sup>.

АНУ-д 2002 онд батлагдсан “Sarbanes-Oxley” хууль нь Enron, Worldcom, Freddie Mac, Lehman Brothers гэх мэт олон нийтийн дунд дуулиан шуугиан болсон бизнесийн үйл ажиллагаа, түүний дотор корпорацийн хариуцлага, санхүүгийн ил тод байдал, луйвартай тэмцэх чиглэлээр шинэчлэгдсэн<sup>21</sup>. Компанийн гүйцэтгэх захирал болон компанийн санхүүгийн захирал (CFO) нь санхүүгийн тайланг үнэн зөв, холбогдох хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхийг биечлэн баталгаажуулах шаардлагатай бөгөөд үүнийг санаатайгаар буруу үйлдсэнийх нь төлөө эрүүгийн хариуцлага оногдуулж, мөнгөн торгууль 5,000,000 доллар хүртэл, 20 жил хүртэл хорих ял оноох болсон байна<sup>22</sup>.

Өмнөд Уэльсийн Хуулийн Шинэчлэлийн Хороо ийм гэмт хэргийн үйл ажиллагааны талаар дараах тайлбарыг хийжээ. Үүнд:

Хуулийн этгээдийн гэмт хэрэг нь иргэдийн сайн сайхан байдалд ихээхэн аюул заналхийлж байна. Манай нийгэмд олон төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг корпорациуд байгааг тэдний үйл ажиллагааны нөлөөлөл нь хувь хүний үйл ажиллагаанаас илүү өргөн хүрээгээр хүмүүст нөлөөлдөг болохыг харгалзан үзвэл корпорацийн учруулсан эдийн засгийн болон бие махбодод үзүүлэх хор хохирол нь маш их юм<sup>23</sup>.

Үүнтэй адил санааг Расселл Мохибер ба Роберт Вайсман (1999) нар дэвшүүлжээ. Тухайлбал нэг түвшинд корпорациуд шинэ технологи, эдийн засгийн цар хүрээг хөгжүүлдэг. Эдгээр нь шинэ бүтээгдэхүүн, массын үйлдвэрлэлийн илүү үр дүнтэй аргыг нэвтрүүлэх замаар массын хэрэглэгчдийн эдийн засгийн ашиг сонирхолд нийцэх боломжтой юм. Өөр түвшинд, өнөөдөр улс төрийн хяналт байхгүй бол корпорациуд нь иргэний нийгмийн үндэс суурийг болон тэдгээрийн оршин сууж буй хүмүүсийн амьдралыг устгахад үйлчилдэг.

ОХУ-ын хувьд 1997 оноос мөрдөгдөж байгаа Эрүүгийн хуульд хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх заалт одоогоор ороогүй байгаа ч 1994 онд хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх төслийг

20 (see Wells: 2001).

21 «The Laws That Govern the Securities Industry». Retrieved 5 December 2016.

22 «Sarbanes-Oxley Act of 2002» (PDF). 107th Congress. Retrieved 5 December 2016.

23 Law Reform Commission of New South Wales: 2001.

боловсруулж, “гэмт хэрэг үйлдсэн хуулийн этгээдэд захиргааны хариуцлага хүлээлгэж байгаа нь үр дүнгээ өгөхгүй байна” гэж тэмдэглэсэн байдаг<sup>24</sup>.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 2000 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр баталсан “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц”, мөн уг конвенцын нэмэлт болох “Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол”-ыг баталсан юм. Уг протоколоор хүлээсэн үүргийн хүрээнд хуулийн этгээдэд хариуцлага тооцох бодит боломжийг нэмэгдүүлсэн бөгөөд үр дүнтэй болгохыг Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх түр хороо (Financial Action Task Force буюу ФАТФ)-ны тусгай бүлэг болох Олон улсын хамтын ажиллагааг хянах бүлэг (International Cooperation Review Group буюу ICRG)-ээс зөвлөмж болгож, Монгол Улсын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог өөрийн хяналтын хоёр дахь шатанд оруулсан байна.

### III. Хуулийн этгээд ба үндэсний эрх зүйн тогтолцоо

Хуулийн этгээдийн талаар ойлголт, тэдгээрийн эрхийн баталгаажилт Чингис хааны байлдан байгуулсан улсаас улбаатай. Тухайн үеийн орон орны худалдаачид Монгол Улсын нутаг дэвсгэрт худалдаа хийх, худалдааны замаар зорчих үед баталгаа буюу гэрэгэ өгдөг байжээ. Чингис хааны эрин үед улс даяар нэг л цааз, засаг мөрдөх хэрэгжүүлэхийн хамт түүнийг хянаж, хамгаалж байх эрх мэдэлтэнг бий болгосон байдаг.

Чингис хааны дараа Өгөдэй хаан орыг залгаж төр улсыг төвхнүүлсэн түүх эхэлдэг билээ.

Ельо Чуцай сайд Умард хятадын иргэний захиргааг бэхжүүлж, цэргийн хэрэг эрхэлсэн ноёдын эрх үүргийг зааглан, татвар хариуцсан албадын ажил хэрэгт цэргийн ноёд оролцохгүй болгож, иргэний захиргаа болон татварын тогтолцоог төлөвшүүлэх саналыг Өгөдэй хаанд өргөн барьсан хэмээн Юань Улсын судрын Өгөдэй хааны цадиг болон Ельо Чуцайн намтарт өгүүлдэг<sup>25</sup>.

Энэ нь өнөөгийн эрх зүйн тогтолцоонд ч хуульчилмаар тун нарийн заалтаар одоогийн хуулийн этгээд буюу татвар төлөгчдийн эрхийг баталгаажуулж байсан чухал эрх зүйн акт байжээ.

Өгөдэй хааны явуулсан татварын бодлого нь эзэнт гүрний бүрэлдэхүүнд орсон малчин нүүдэлчид хийгээд газар тариалан эрхлэгч суурин иргэд рүү чиглэсэн хоёр талтай боловч худалдаа арилжаа эрхлэгчдээс авах татвар

24 Б.Одонгэрэл, “Хуулийн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлага, Докторын зэрэг горилсон бүтээл”, УБ, 2020 он.

25 Б.Батсүрэн, П.Дэлгэржаргал, У.Эрдэнэбат, “Их Монгол Улс: Монголын эзэнт гүрний түүх”, Тэргүүн боть, УБ, 2019 он, 432 дахь тал.

гэсэн онцгой хэлбэр ч байсан байна. Түүний татварын бодлого нь тодорхой хэмжээнд өтгөс, ядууст чиглэж байсныг Монголын нууц товчоонд дурдсан мэдээ хангалттай гэрчилж байгаа бөгөөд “Өгөдэйн төр барьсан 13 жилд харц ард, ядуус, боол, шивэгчин нар ихэд жаргалтай амьдарч байсан тухай түүхийн баримт, ардын аман домог цөөнгүй тааралддаг”<sup>26</sup> гэж эрдэмтэд үзсэн байдаг.

Төрийн бодлого зөв байх нь ард иргэдийн амьдралд ямар чухал болох, татварын бодлого, хуулийн этгээдийн эрхийн баталгаажилт хангагдсанаар тэдгээрийн үйл ажиллагаа өсөн нэмэгдэж, улс гэрт оруулах татварын хувь хэмжээ сайжирч байдгийг түүх бидэнд сургаж үлдээсэн нь энэ юм.

Өгэдэй хааны үед нийгэм, аж ахуй, соёл, уламжлалын хувьд ихээхэн ялгаатай Монголын эзэнт гүрний харьяат бүс нутгуудаас авах татварын болон засаг захиргааны тогтолцоо үндсэндээ бүрэлдэн тогтсон юм. Гэвч Өгөдэй хаан нас барсны дараа Монголын төр таван жил эзэн үгүй, хаангүй байсан нь эзэнт гүрний санхүү татварын тогтолцооны нэгдмэл бодлого алдагдан, ноёд, хан хөвгүүд өөрсдийн дураар авирлан татвар хураах болсноор улс орныг дампуурлын ирмэгт аваачив. Дөргэнэ хатан засгийн эрх барьж байх үедээ зөвхөн өөрийн нөлөөг бэхжүүлэхийн тулд Монгол төрийн хуучин түшмэдийг албан тушаалаас нь зайлуулж эхлэв. Дөргэнэ хатан Чингайн оронд Ираны худалдаачин Абдул Рахман гэгчийг томилж тэргүүн сайд болгов. Түүнчлэн Умард Хятадын хэргийг Махмуд Ялавачаас авч түүнд хавсруулж эрх мэдлийг нь улам нэмэгдүүлэв. Ингэснээр Абдул Рахман нь ордны хамгийн гол нөлөө бүхий хүн болж хувирчээ. Хааны ордонд түшмэдийн ил далд өрсөлдөөн хөгжих болж заримдаа улайран хоорондоо тэмцэлдэх болсноор хааны төв засаглал суларч бүс нутгуудыг төрийн төвлөрсөн бодлогоор хангаж чадахгүйд хүрлээ. Бүс нутагт хангууд болон захирагч, даругачи нар дураараа алба татвар хураах, хаан ба өөрсдийн нэрийн өмнөөс зарлиг бичих зэргээр Их засгийг илт зөрчсөн үйлдлүүд олноор гаргах болов. Тухайлбал ертөнцийг байлдан дагуулагчийн түүхэнд өгүүлснээр Иран дахь захирагчийн албаны их бичээч Шараф ад Дин Тебризийн татварын шинэтгэлийг биечлэн удирдаж хэрэгжүүлэхдээ хүн амын тооллогод бүртгэгдсэн хүн бүрд татвар оноохоор шийдэж эл аюултай бодлогоо Шараф ад Дины тэргүүлсэн түшмэдийн баг хууль ёсны болоод мөн хүч хэрэглэх замаар хэрэгжүүлжээ.

Юань Улсын сударт өгүүлэхээр Хубилайн хаан цагт улс даяар-архи, цуу, давс, загас агнуур, алт мөнгө, төмөрлөг хайлуулалт багтсан зургаан төрлийн монополь татварыг улс дангаар авч байв. Гэхдээ зөвхөн төр л татах эрхтэй монополь татварын үндэс 1230-аад онд бүрэлдэн тогтсон бөгөөд Хубилай хааны үе хүртэл бараг өөрчлөгдөөгүй юм. Елюй Чуцайн намтарт тэмдэглэсэнээр бол Умард Хятадын хүн амд татварын хэм

хэмжээг цэгцэлж хөдөлбөргүй тогтоож өгсөн 1230 оноос Умард Хятадыг бүрэн эрхшээлдээ оруулсан 1234 он хүртэл татварын орлого байнга өсөж нэмэгдэж байсан бөгөөд 1238 он гэхэд мөнгөөр авах татварын жилийн орлого 110 түмэн ланд хүрчээ.

Их Монгол Улсын татварын бодлого цэгцэрч, татварын тогтолцоо нь хүн амд айхтар дарамт учруулахгүйгээр, зохих орлого олох болсныг тэр цагийн өөр баримтаар гэрчилж болно. Мөнхөд ашиг харж явдаг худалдаачид Монголын төрд талтай болсноо ашиглаж тодорхой бүс нутгийн хүн амын жилийн алба татварыг түрүүлж засаг төрд төлөөд улмаар алба татварын хэмжээг нэмж үлэмж ашиг олж болохыг ажиглаж мэдээд элдэв арга, саам хэрэглэж төрийн татварын эрхийг худалдаж авахыг оролдож эхэлсэн байна. Энэ баримт, үйлдэл нь эргээд Монголын төрийн татварын тогтолцоо эрүүл, хүн ардад айхтар сүрхий дарамт учруулж байгаагүй гэдгийг нотолно. Чухам урьдчилж улсын хэм хэмжээт татварыг бэлэн мөнгөөр төлөөд цаанаа гарлагаа бүрэн нөхөхийн зэрэгцээ ард түмний ашгийг хэмжээг багасгаж нэмж ашиг гаргаж маш хурдан баяжиж болохыг худалдаачид түүн дотроо эртний Согд (ху) худалдаачдын үр сад болох Дундад Азийн Исламын ертөнцийн томоохон хөлтэй худалдаачид мэдэх учраас Их хаанд айлтгал өргөх болжээ. Жишээ нь Өгөдэй хааны цагт Люхудума, Шэлефадин, Лютинюй нарын худалдаачид, саятнууд Умард Хятадаас авах татварын жилийн хэмжээг 1.4 сая лан мөнгөөр үнэлэн түрээсэлж авах хүсэлт тавихад хааны төв засгийн газрын түшмэд эсэргүүцэн хориглож, хүлээн аваагүй ажээ.

Гэвч 1239 оны 12 дугаар сард Абдул Рахман гэгч Дундад орноос (Умард Хятад) татварлан авдаг 22 мянган дин (ding) мөнгөн татварыг хоёр дахин өсгөж 44 мянган дин мөнгөөр авах санал дэвшүүлснийг хаан зөвшөөрч орхижээ. Тухайн асуудлыг ордонд хэлэлцэхэд Елюй Чуцай тэргүүт төрийн түшмэл хааны хүлээж авах саналыг хүчтэй эсэргүүцсэн ч дийлээгүй гэдэг. Өгөдэй хааны цадиг болон Елюй Чуцайн намтарт тэмдэглэсэн мөнгөн татварын хэмжээ нь зөрүүтэй боловч Абдул Рахман татварын хэмжээг хэмжээг хоёр дахин нэмсэн үнээр авах санал тавьсан гэдгийг хоёулаа нотолж байна. Татвар авах тухай саналыг хүлээн авахыг Елюй Чуцай бүхий л аргаа хэрэглэн эсэргүүцсэн бөгөөд Өгөдэй хаан “чи тэмцэлдэх гэж байна уу?”, “олон түмний төлөө дахиад уйлах нь уу?” хэмээн асууж байсан хэмээн Хятад эх сурвалжид өгүүлдэг. Өгөдэй хаан ийнхүү Абдул Рахманы Умар Хятадаас татвар авах саналыг хүлээн авахад Елюй Чуцай “ард олны гуйланчлал ингээд эхэлж байгаа юм даа” хэмээн халагласан гэдэг<sup>27</sup>.

Дээрх түүхэн сургамжаас тухайн үеийн худалдаачдын буюу одоогийн хуулийн этгээдийн үйл ажиллагаа улс гэр, ард олонд сөргөөр бас

27 Б.Батсүрэн, П.Дэлгэржаргал, У.Эрдэнэбат, “Их Монгол Улс. Монголын эзэнт гүрний түүх”, Тэргүүн боть. УБ, 2019 он, 596 дахь тал.

нөлөөлдгийг анхааруулж, хуулийн хязгаарлалт шаардлагатайг сургамжлан үлдээсэн юм.

Хуулийн этгээдийн ойлголтыг тухайн үеийн Хаант Орос Улсад үүссэн Октябрын хувьсгалын нөлөөнд Монгол Улс 1921 оноос тусгаар тогтнолоо бэхжүүлэн, эрх зүйн орчноо бүрэлдүүлсэн тэр цаг дор хуульчилсан байдгийг зарим судлаачид бүтээлдээ дурджээ. Тухайлбал 1926 оны Иргэний хуулийн 3 дугаар ангид “Аливаа, эвлэл хоршоо буюу энгийн хүмүүсийн хоршоолон байгуулсан худалдаа үйлдвэрийн газрын эрхүүдийн тухай” гээд “энэхүү газрууд болбоос ард олны боловсролын хэрэг ба аливаа худалдаа үйлдвэрийн зэрэг явдлыг гол болгосон бодлого бүхий туланх хоршоолсон хүмүүсийн завсартаан байгуулж хууль ёсоор батлуулсан дүрэм буюу гэрээ бичгийг баримталж элдэв хэрэгт бүрэн эрхтэй ард лугаа нэгэн адил үүргийг эдэлвээс зохимой гэж” заасан байдаг<sup>28</sup>.

1952 оны Иргэний хуульд<sup>29</sup> “хуулийн этгээд нь бие дааж эд хөрөнгийн эрхийг олж чадах, үүрэг авах, түүнээ хариуцах ба өөрийн эрхийн тухай шүүхэд маргаж чадах хүмүүсийн нэгдэл, албан газар ба байгууллага болох тухай” гэж заажээ.

1963 Иргэний хуулийн 18-26 дугаар зүйлүүдэд “өөртөө тусгайлан эзэмшсэн эд хөрөнгөтэй, өөрийнхөө нэрийн өмнөөс эд хөрөнгийн ба түүнтэй холбогдсон эд хөрөнгийн бус эрх олох, үүрэг бий болгож чадах, мөн шүүх, арбитрын газар нэхэмжлэгч, хариуцагч байж чадах байгууллагыг хуулийн этгээд гэнэ” гэжээ.

2002 оны Иргэний хуульд<sup>30</sup> “Иргэний эрх зүйн харилцаанд оролцогч нь иргэн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага байна” гэж тогтоосон. Иргэн гэж иргэний эрх зүйн харилцаанд оролцогч-Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг ойлгоно.

Төр, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж болох аймаг, нийслэл, сум, дүүрэг нь иргэний эрх зүйн харилцаанд хуулийн этгээдийн нэгэн адил оролцоно.

Өмчлөлдөө буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхдээ тусгайлсан хөрөнгөтэй, өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээдэг, үйл ажиллагаанаасаа бий болох үр дагаварыг эд хөрөнгөөрөө хариуцдаг, нэхэмжлэгч, хариуцагч байж чадах, тодорхой зорилго бүхий, тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг зохион байгуулалтын нэгдлийг хуулийн этгээд гэнэ.

2015 оны Эрүүгийн хуулийн 9 дүгээр бүлэгт “Хуулийн этгээдэд эрүүгийн

28 Г.Баярхүү, Н.Цэдэнбалжир, “Бизнесийн эрх зүй” УБ, 2014 он, 11 дэх тал.

29 БНМАУ-ын Иргэний хууль., 1956 он, 13 дугаар зүйл.

30 “Төрийн мэдээлэл”, УБ, 2002 он, №7.



хариуцлага хүлээлгэх”, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 20 дугаар бүлэгт “Хуулийн этгээдэд холбогдох эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа”-тай холбоотой зохицуулалтыг хуульчилсан.

Хууль хэрэглээний явцад Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт хийх шаардлага гарахыг үгүйсгэхгүй боловч хуулийн цоо шинэ зохицуулалт нь эрх зүйн шинэтгэлийн томоохон өөрчлөлт, дэвшил гэж үзэх үндэслэлтэй юм.

## **А. Хуулийн этгээдийн эрхийн баталгаажилт**

Хуулийн этгээдийн эрхийн баталгаажилт тэдгээрийн үйл ажиллагааны үндсэн чиглэл зорилгоос хамаардаг. Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 5 дахь хэсэгт “Төрөөс гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүнд газрыг төлбөр, хугацаатайгаар болон хуульд заасан бусад болзол, журмаар ашиглуулж болно.” хэмээн заасан нь хуулийн этгээдийн эрхийг баталгаажуулсан суурь заалт юм. Учир нь Монголчууд төрт улсаа байгуулсан тэртээ олон зууны өмнөөс “газар бол улсын үндэс” хэмээн төрийн бодлогын хэмжээнд тусгаж, газартай холбоотой харилцааг хамгийн ихээр чухалчилж ирсэн байна.

Иргэний хуулийн<sup>31</sup> 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт “Өмчлөлдөө буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхдээ тусгайлсан хөрөнгөтэй, өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээдэг, үйл ажиллагаанаасаа бий болох үр дагаврыг эд хөрөнгөөрөө хариуцдаг, нэхэмжлэгч, хариуцагч байж чадах, тодорхой зорилго бүхий, тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг зохион байгуулалтын нэгдлийг хуулийн этгээд гэнэ” гэжээ. Мөн хуулийн этгээд нь ашиг олох зорилготой ашгийн төлөө, хууль буюу дүрэмд заасан зорилготой, ашгийн төлөө бус байж болно, хуулийн этгээд нь нийтийн, хувийн, холимог өмчийн байна хэмээн тодорхойлжээ.

Хуулийн этгээдийн үйл ажиллагаагаа явуулах хамгийн чухал нөхцөл бол эрх зүйн орчны эрхийн баталгаажилт юм. Төр буй дор татвар буй гэдэгчлэн төр татвараар бүрдсэн төсвийг хуваарилах замаар улс үндэстний хэрэгцээ, хязгаарыг зохицуулж, зохион байгуулдаг. Дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэх, өрхийн орлогыг нэмэх асуудал нь ямагт эрх баригчдын толгойн өвчин болсоор ирсэн. Тиймээс хуулийн этгээдүүдэд ялангуяа татвар төлж, төсөв бүрдүүлдэг аж ахуйн нэгж, байгууллагын хуулийн дагуу үйл ажиллагааг дэмжих, эрх зүйн орчныг зөв бүрдүүлэх нь чухал юм. Гэвч эрх зүйн болон эдийн засгийн онолд суурилагүй хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилт нь хуулийн этгээдүүдийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж улмаар татвар бүрдүүлэгчдэд дарамт үүсч, хөрөнгө оруулагчдыг үргээх хандлагыг бүрдүүлдэг.

<sup>31</sup> “Төрийн мэдээлэл”, УБ, 2002 он, №7.

Мөн эрхийн баталгаажилтыг хуулийн этгээдийн төрөл хэлбэр, үйл ажиллагааны чиглэлд тохируулан, тодорхой хэм хэмжээгээр зохицуулах нь чухал бөгөөд үүнийг хариуцлагын болон хязгаарлагдмал хариуцлагын онолын хүрээнд авч үзэх нь зүйтэй юм.

Аливаа төрөл хэлбэрийн компанийг тодорхойлдог гол шинжүүдийн нэг нь хязгаарлагдмал хариуцлага бөгөөд энэ нь компанийн бие даасан хуулийн этгээд байх шинжээс урган гардаг. Хувьцаа эзэмшигчийн хариуцлага нь зөвхөн түүний хувьцааны хэмжээгээр хязгаарлагдаж, компани болон хувьцаа эзэмшигч нь бие биенийхээ өмнөөс хариуцлага хүлээхгүй байх боломж олгодог уг зарчим нь “орчин цагийн хамгийн шилдэг нээлт юм. Уур, гэрэл цахилгааны нээлтээс ч илүү чухал нээлт болсон” гэж тэмдэглэсэн судлаачид ч байдаг<sup>32</sup>.

Монгол Улсад үйлчилж байгаа хуулиудаас хуулийн этгээдийн эрх, үүрэг, хариуцлагын талаар заасан хэм хэмжээг харьцуулахад дараах байдалтай байна.

Хүснэгт 1. Хуулийн этгээдтэй холбоотой зохицуулалт

Д/д	Хууль	Нэр томъёо орсон зохицуулалт
1	Үндсэн хууль	1
2	Иргэний хууль	125
3	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль	43
4	Эрүүгийн хууль	221
5	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль	101
6	Зөрчлийн тухай хууль	1058
7	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль	50
8	Цагдаагийн албаны тухай хууль	38

Үүнээс үзэхэд хуулийн этгээдтэй холбоотой зохицуулалт цөөнгүй байгаа ч цаашид жижиг аж ахуйн нэгж, компанийг үндэсний хэмжээний болон үндэстэн дамнасан групп компани, корпорациудтай адилтган, нэг хэм хэмжээгээр зохицуулах боломжгүй гэдгийг анхаарах шаардлагатай болжээ. 2011 оны Компанийн тухай хуульд<sup>33</sup> заасны дагуу групп, компани нь охин компанитайгаа нэгдсэн тайлан гаргах ёстой. Улс орнуудад санхүүгийн ийм зохицуулалтыг дэмжиж, нийтлэг хэрэгжүүлдэг байна.

32 Б.Урнаа, “Компанийн хууль зүйн зохицуулалтын онолын асуудал” илтгэл, “Хууль дээдлэх ёс сэтгүүл”, 2019 он. Цуврал 4/74/.

33 “Төрийн мэдээлэл”, УБ, 2011 он. №42.

## Б. Хуулийн этгээдийн эрхийн хязгаарлалт

Монгол Улсад хуулийн этгээдийн эрх, үүргийг шууд зохицуулсан 20 орчим хууль байгаагаас эдгээрийн 1500 орчим заалт нь шууд хуулийн этгээдийн эрх, үүрэгтэй холбогддог. Хуулийн этгээдийн гол идэвхтэй төлөөлөл нь ашгийн төлөө буюу бизнесийн үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүд юм. Тиймээс эдгээр аж ахуйн нэгж, байгууллагын бизнесийн буюу ашиг орлогын төлөө чиглэл бүхий үйл ажиллагааны нийгэмд аюултай, нийтэд хохирол, хор уршиг учруулж болзошгүй үйл ажиллагааг хуулиар хязгаарлах асуудал гарцаагүй хөндөгдөж байна.

Хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгмийг цогцлоон хөгжүүлж буй сүүлийн 30 жилийн хугацаанд харьцангуй чөлөөт эдийн засгийг хөгжүүлсэн нь нийгмийн хөгжил, нийтийн амьдралын чанарт сайнаар нөлөөлж байгааг хэн ч үгүйсгэхгүй юм. Гэвч хэт ашгийн төлөө байгууллага нь дэлхийн экологи, эко системд муугаар нөлөөлж, байгалийн тэнцлийг алдагдуулан, хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг бөгөөд мал амьтны генетикт өөрчлөлт оруулах, баялаг хэт цөөнхийн мэдэлд төвлөрөх, баян ядуугийн ялгаа ихсэх, групп компани, корпораци, хуулийн этгээдүүд нь улс, үндэстэн дамнан манайх шиг жижиг эдийн засагтай улсад хяналтаа тогтоох зэргээр үндэсний аюулгүй байдалд шууд болон шууд бус нөлөөлөл үзүүлэх эрсдэл байгаа тул эдгээр том, жижиг шалтгаануудаас тэдгээрийн үйл ажиллагаанд хуулиар хязгаарлалт тогтоох зайлшгүй шаардлагатай билээ.

Хуулийн байгууллагын үйл ажиллагаа, чиг үүрэг өргөжин тэлэхийн хэрээр хууль тогтоомжийн янз бүрийн хэлбэр, мөн шүүхэд ирж буй, нэхэмжлэл буюу хэргийн янз бүрийн хэлбэр түүнчлэн тухайн төрлийн хэрэг бүрд хэрэглэж буй хуулийн арга хэмжээний хэлбэрийг ялгаж салгаж үзэх нь зүйтэй. Ихэнх иргэний зарга маргаан хувь хүмүүсийн хооронд үүсдэг бол гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэхэд Монгол Улсын төв болон орон нутгийн удирдлагын байгууллага заавал нэг тал болж оролцдог. Энэ нь нийтийн сайн сайханд хор хохирол бий болгосон гэж хориглосон хуулийг зөрчсөн хариуцагч нарыг засаглалын зүгээс нийт ард иргэдийн нэрийн өмнөөс буруутган, яллаж байгаа хэлбэр болно. Гэрээ, хэлэлцээр зөрчсөн гэх үндэслэлээр бизнесийн хоёр түнш иргэний нэхэмжлэл гарган маргалдах бол гагцхүү улсын нэрийн өмнөөс шүүх засаглалд хуулиар тогтоосон үүрэг нь хэн нэгнийг гэмт хэрэг үйлдсэнд буруутган яллах эсвэл цагаатгахад оршино.

Өнөөдөр цөөн зарим тохиолдлыг эс тооцвол АНУ, Герман, Франц, ИБУИНВУ зэрэг улсын шүүх бий болсон нөхцөл байдалд тохируулан хуулийн болон шударга ёсны арга хэмжээний аль нэгийг хэрэглэж байна.

Хуулийн байгууллагын зүгээс эрүүгийн хэрэг шалгах явцад хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага тооцох үндэслэлтэй тохиолдол үүсдэг байсан боловч хууль зүйн зохицуулалтгүйгээс хариуцлага хүлээлгэх боломжгүй байв. Тухайлбал “Аюултай хог хаягдал, химийн хорт, аюултай бодисыг хаях, Эрүүл ахуйн шаардлага хангаагүй хүнсний бүтээгдэхүүн худалдах, түгээх, Чанар муутай барилга байгууламж ашиглалтад оруулах, Байгаль орчныг бохирдуулах, Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох” гэх мэт хэрэгт хуулийн этгээдэд зөвхөн захиргааны хариуцлага хүлээлгэх төдийхнөөр арга хэмжээ тооцож байлаа.

Хуулийн этгээдийг Иргэний хуульд өмчлөлдөө тусгайлсан хөрөнгөтэй, өөрийн нэрээр эрх эдэлж, үүрэг хүлээж байдаг, үйл ажиллагаанаасаа бий болох үр дагаврыг эд хөрөнгөөрөө хариуцдаг зохион байгуулалтын нэгдэл гэж тодорхойлсон байдаг. Мэдээж хуулийн этгээдийн цаана хүн гэж бодгаль бодитоор оршин байдаг. Энэ ч утгаараа тухайн олон зүйлийн нэгдлийг ямар нэгэн хүн төлөөллийн зарчмаар хуулийн этгээдийн өмнөөс эрх эдэлж, үүрэг хүлээж эрүүгийн хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоно. Харин эрүүгийн хариуцлагыг тухайн гэм буруутай хуулийн этгээд хүлээх бөгөөд өөрөөр хэлбэл хуулийн этгээдийг эрүүгийн хэрэгт холбогдуулан шалгахад тодорхой эрх бүхий хувь хүн түүнийг төлөөлөн эрх эдэлж, үүрэг хүлээж оролцох боловч төлөөлж байгаа хувь хүн хуулийн этгээдийн өмнөөс ял шийтгэл эдэлнэ гэсэн үг биш юм.

Юуны түрүүнд тухайн хуулийн этгээдийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээд, тийм хүн байхгүй бол шүүх, прокурор, мөрдөгчөөс хугацаа өгч өөр этгээдийг хууль ёсны төлөөлөгчөөр томилохыг мэдэгдэж, тогтоосон хугацаанд хуулийн этгээд хууль ёсны төлөөлөгчөө томилоогүй бол шүүх, прокурор хууль ёсны төлөөлөгчийг тухайн хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч, хувь нийлүүлэгч, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага дундаас томилж болно.


Хуулийн этгээдийг төлөөлөн шийдвэр гаргасан эрх бүхий этгээд, эсхүл шийдвэрийг гүйцэтгэсэн этгээд нь эрүүгийн хэрэгт яллагдагчаар татагдаж, түүнээс өөр тухайн хуулийн этгээдийг төлөөлөх хүн байхгүй бол яллагдагч нь хуулийн этгээдийг төлөөлж болно. Үүнээс бусад тохиолдолд хуулийн этгээдийг төлөөлж буй хүн нь тухайн хэргийн яллагдагч байж болохгүй.

Компанийн төлөөлөн удирдах зөвлөл, хувьцаа эзэмшигчдийн хяналт сайжрах, гаргаж буй шийдвэр, явуулах үйл ажиллагаа нь хууль тогтоомж зөрчиж буй эсэхийг нягталж шалгадаг болох, компаниудын хууль тогтоомж зөрчдөг байдал багасч, хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулах зэрэг эерэг үр дүн гарна.

Хуулийн этгээдийн холбогдсон гэмт хэргийн талаар 2017 оноос хойших дүн мэдээг судлав. Цагдаагийн байгууллагад нийт 5 төрлийн 29 гэмт

хэрэг бүртгэгдсэнийг Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн статистик мэдээнээс хувиар харахад дараах байдалтай байна.

График 1. Хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг. 2019-2017 он



Үүнээс үзэхэд Монгол Улсад ашигт малтмал хууль бусаар олборлох гэмт хэрэгт хуулийн этгээдүүд ихээр холбогдож байгааг харж болно. 2017 оноос өмнөх дүн мэдээтэй харьцуулбал буурсан үзүүлэлттэй байгаа нь хуулийн этгээдийн эрхийн зохицуулалт хэрэгжиж эхэлсэнтэй шууд холбоотой гэж дүгнэж болохоор байна. Гэхдээ шүүхээр хянан шийдвэрлэгдсэн хэргийн тоо 2017 оны 7 дугаар сараас 2020 оны 9 дүгээр сар хүртэл нийт 7 хэргийг шийдвэрлэсэн бөгөөд 2019 онд 3 хуулийн этгээдэд холбогдох хэргийг шийдвэрлэжээ<sup>34</sup>.

Энэ нь хуулийн этгээдийн үйлдэж буй хэрэг бага гэж шууд ойлгож болохгүй бөгөөд хэдийгээр холбогдох хуулиуд батлагдан, хэрэгжиж эхэлсэн ч хэрэглэж буй хууль сахиулагч, хуульчдын мэдлэг, туршлага дутмаг, нотлох ажиллагааг явуулахад эрх зүйн зохицуулалт боловсронгуй бус байгаатай холбож үзэх үндэслэлтэй юм. Ялангуяа үндэсний хэмжээний болон үндэстэн дамнасан компани, корпорац, группын үйлдсэн гэмт хэргийг илрүүлэх, нотлох хэмжээнд боловсруулагдаагүй байна.

Эрүүгийн хэргээс гадна зөрчлийн хэргийн шийдвэрлэлтийн дүн мэдээнд дүгнэлт хийхэд дараах байдалтай байна.

34

<http://www.judoinstitute.mn/main/244--2019-3-.html>

Хүснэгт 2. Зөрчлийн хэргийн шийдвэрлэлтийн  
статистик мэдээ 2017-2019 он

д/д	Зөрчлийн хэргийн шийдвэрлэлт 2017–2019 он	2017	2018	2019	Нийт
1	Цагдаагийн байгууллагын эрх бүхий албан хаагч	867	448	726	2041
2	Мэргэжлийн хяналтын байцаагч	87	293	1215	1595
3	Улсын бүртгэлийн хяналтын улсын байцаагч	298	144	817	1259

Зөрчлийн хэрэг шийдвэрлэсэн статистик мэдээ нь эрүүгийн хэргийн статистик мэдээнээс харьцангуй өндөр байна. Ялангуяа зөрчил үйлдэгч хуулийн этгээдийн тоо их байгаа нь урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөө бага байгаатай холбоотой байна. Мөн зөрчил үйлдэгчдэд зөвхөн торгох шийтгэл нийтлэг байдлаар оноож байгаа тул сануулах шийтгэл оногдуулах зохицуулалт бий болгох шаардлагатай. Энэ нь зөрчлийг бууруулах, урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой. Хуулийн этгээдийн түгээмэл үйлддэг зөрчил нь Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай тухай, Эрүүл ахуйн тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Ашигт малтмалын тухай, Газрын тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай, Татварын ерөнхий хууль, Гаалийн тухай, Барилгын тухай зэрэг хуулиуд болон Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ үйл ажиллагааны журмыг зөрчиж байна.

Групп, компани ялангуяа тэдгээрийн хариуцлагын тухайд эрх зүйн онолын хандлага, чиглэлийг ерөнхийдөө гурван чиглэлд хуваан авч үзэж болохоор байна.

- **“Entity law approach” буюу группын оролцогч компанийг бие даасан этгээд гэж үзэх хандлага.** Энэ зарчим нь уламжлалт хязгаарлагдмал хариуцлагын онолд суурилах бөгөөд ямар ч тохиолдолд толгой болон охин компани нь бие биенийхээ өмнөөс үүрэг хариуцлага хүлээхгүй гэж үзнэ.
- **“Enterprise law approach” буюу группын оролцогчдыг нэг этгээд гэж авч үзэх хандлага.** Толгой болон охин компаниудыг хариуцлагын хувьд нэг этгээд мэт тооцох ба уламжлалт онолын эсрэг шинэлэг, эрс өөр зарчмыг санал болгодог.
- **“Dualist approach” буюу дээр дурдсан хоёр чиглэлийн аль алиныг нь багтаасан хоёрдмол шинжтэй хандлага<sup>35</sup>.**

<sup>35</sup> Б.Урнаа, “Компанийн хууль зүйн зохицуулалтын онолын асуудал”, Хууль дээдлэх ёс сэтгүүл, 2019 он, Цуврал 4/74/.

#### IV. Дүгнэлт

Энэхүү нийтлэлийн дагуу хийсэн судалгаа шинжилгээний хүрээнд дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

- Чингис хааны байлдан байгуулсан Их Монгол Улс, Өгөдэйн болон Хубилайн хаант Улсын үеэс өнөөгийн хуулийн этгээдийн тухай буюу тухайн үеийн худалдаа, арилжаа эрхлэгчдийн талаарх баримталж байсан бодлого нь туйлын анхаарал татсан эх сурвалж байлаа. Худалдаачид болон голлон татвар бүрдүүлэгч нарын эрхийг баталгаажуулж байсны эерэг ба сөрөг үр дагавар, эрхийн хязгаарлалт хийх ямар учир шалтгаанууд үүсдэг байсан, тэр нь улс оронд хэрхэн нөлөөлдөг байсан зэрэг түүхийн томоохон сургамжуудыг бидэнд үлдээжээ.
- Хуулийн этгээдийн эрхийн баталгаажилт ба хязгаарлалт нь Монгол Улсын тухайд шинэ ойлголт биш бөгөөд түүхэн цаг үе, нийгмийн зохион байгуулалтын онцлогоос хамааран эрх зүйн зохицуулалт нь боловсронгуй болсоор иржээ.
- Дэлхийн улс гүрнүүдийн хуулийн этгээдийн талаар баримталж буй бодлого нь хамтын хариуцлага, хязгаарлагдмал хариуцлага, хосолсон гэсэн үндсэн 3 онолын хүрээнд байж, тэдгээрийн үйл ажиллагааг хууль эрх зүйн болон нийгэм, эдийн засаг, хөгжлийн онолоор нь судалж, цаашдын чиг хандлагыг тодорхойлж иржээ.
- Монгол Улсад хуулийн этгээдийн эрхийг Үндсэн хууль болон бусад хуулиар баталгаажуулж ирсэн бөгөөд шинэ Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар эрхийн хязгаарлалт хийсэн нь дэвшилтэй боловч хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэж, тэдний холбогдсон зөрчлийн болон эрүүгийн хэргийг шалгаж шийдвэрлэсэн тоо хэмжээ цөөн байгааг тэдний зүгээс үйлдэж буй, хэрэг зөрчил бага гэж шууд ойлгож болохгүй. Хэдийгээр холбогдох хуулиуд батлагдан, хэрэгжиж эхэлсэн ч хэрэглэж буй хууль сахиулагч, хуульчдын мэдлэг, туршлага дутмаг, нотлох ажиллагааг явуулахад эрх зүйн зохицуулалт боловсронгуй бус байгаатай холбож үзэх үндэслэлтэй юм. Ялангуяа үндэсний хэмжээний болон үндэстэн дамнасан компани, корпораци, группын үйлдсэн гэмт хэргийг илрүүлэх, нотлох хэмжээнд боловсруулагдаагүй байна.
- Хуулийн этгээдүүд өөрсдийн хууль ёсны эрхийг баталгаажуулах, эрхийг ямар үндэслэлээр хэрхэн хязгаарлаж буй талаар хуулийн мэдлэг өндөр болсон нь хууль сахиулагчдын болон хуульчдын боловсрол, хуулийн этгээдтэй холбогдсон зөрчил, гэмт хэргийг шийдвэрлэх

арга зүйн сургалтыг шат шатанд нь зохион байгуулах шаардлагатайг шийдвэрлэсэн болон шалгасан хэргийн тоо, арга, арга зүй, үр дүн харуулж байна.

- Хуулийн этгээдийн эрх зүйн зохицуулалтын талаар онолын болон практик, үндэсний болон олон улсын, хууль хэрэглээний болон хуулийн хэрэгжилтийн судалгааг өргөн хүрээтэй хийж дараагийн шинэчлэлийг хийх зэрэг болно.

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН




## Ном зүй:

### 1. Монгол эх сурвалж

1. Б.Батсүрэн, П.Дэлгэржаргал, У.Эрдэнэбат, "Их Монгол Улс. Монголын эзэнт гүрний түүх", Тэргүүн боть, УБ, 2019 он.
2. Д.Баярсайхан, "Хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлага", УБ, 2013 он.
3. Д.Баярсайхан, "Эрх зүйн онол", УБ, 2016 он.
4. Г.Баярхүү, Н.Цэдэнбалжир, "Бизнесийн эрх зүй", УБ, 2014 он.
5. Ч.Далай, "Их Монгол Улс", УБ, 2006 он.
6. Ч.Нямсүрэн, "Эрх зүйн онол", УБ, 2010 он.
7. Б.Одонгэрэл, "Хуулийн этгээдэд хүлээлгэх хариуцлага. Хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл", УБ, 2020 он.
8. Б.Урнаа, "Компанийн хууль зүйн зохицуулалтын онолын асуудал", Хууль дээдлэх ёс сэтгүүл, УБ, 2019 он.
9. Эрүүгийн эрх зүйн шинэтгэл: "Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудал", Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, УБ, 2017 он.

### 2. Гадаад эх сурвалж

1. Celia Wells, *Corporations and Criminal Responsibility*, Oxford University press. 2 дахь хэвлэл, АНУ, (2005).
2. *Models of corporate criminal liability in comparative law*. Washington university global studies law review, 4 дэх хэвлэл. АНУ, (2008).
3. *Sarbanes-Oxley Act of 2002 (PDF)*. 107th Congress. Retrieved. АНУ, (2016).
4. *The Laws That Govern the Securities Industry*. 5 дахь хэвлэл. АНУ. (2016).
5. V.S.Khanna, *Corporate Criminal Liability: What purpose does it Serve*, Har.L.Rev. 1996) 109).



### 3. Эрх зүйн эх сурвалж

1. Иргэний хууль, (1956).
2. Үндсэн хууль, (1992).
3. Иргэний хууль, (2002).
4. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, (2002).
5. Эрүүгийн хууль, (2015).
6. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, (2017).
7. Зөрчлийн тухай хууль, (2017).
8. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, (2017).
9. Компанийн тухай хууль, (2011).
10. Цагдаагийн албаны тухай хууль, (2017).

### 4. Бусад:

<https://www.britannica.com/topic/corporate-crime#ref336083>

[https://en.wikipedia.org/wiki/Corporate\\_crime](https://en.wikipedia.org/wiki/Corporate_crime)

<https://advocate.mn/news/119/single/774>

<https://www.britannica.com/topic/corporate-crime#ref336083>

<http://www.judoinstitute.mn/main/-3-2019--244.html>

[https://en.wikipedia.org/wiki/Corporate\\_crime](https://en.wikipedia.org/wiki/Corporate_crime)





## ЦАГДААГИЙН ХУУЛЬ САХИУЛАХ АЖИЛЛАГААН ДАХЬ ХҮНИЙ ЭРХ: ӨНГӨРСӨН, ОДОО, ИРЭЭДҮЙ

Сара Пульман, Ричард Вильшо, Жеми Грэйс

Шеффилд Халламын Их сургуулийн эрдэм шинжилгээний архив <http://shura.shu.ac.uk/24400/> холбоосоос авч болно.

Энэ баримт бичиг нь зохиогчийн оруулсан хувилбар болно. Хэрэв үүнээс иш татахаар бол хэвлэн нийтлэгчид нь хандана уу.

### Нийтлэгдсэн хувилбар

Сара Пульман, Ричард Вильшо, Жеми Грэйс (2019). Цагдаагийн хууль сахиулах ажиллагаан дахь хүний эрх-өнгөрсөн, одоо, ирээдүй. Улс төрийн улирал тутмын дугаар.

Зохиогчийн эрх, дахин ашиглах тухайд доорх холбоосоор харна уу.


<http://shura.shu.ac.uk/information.html>

Шеффилд Халламын Их сургуулийн эрдэм шинжилгээний архив <http://shura.shu.ac.uk>

Цагдаагийн хууль сахиулах ажиллагаан дахь хүний эрх-өнгөрсөн, одоо, ирээдүй

Сара Пульман, Ричард Вильшо, Жеми Грэйс

**Хураангуй:** Энэ өгүүлэлд голчлон хууль хэрэглэгчийн үүднээс цагдаагийн хууль сахиулах ажиллагааны хүрээн дэх хүний эрхийн стандартуудыг үр нөлөөтэй ойлгож, хэрэгжүүлэх явцад гарч буй хувьслыг харуулахыг зорилоо. 2000 оны эхэн үед ИБУИНВУ-ын (Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улс) цагдаагийн ажиллагаанд "хүний эрх"-ийг арай хязгаарлагдмал хүрээнд ойлгож, ханддаг байв. Эдгээрийг одоо эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх үйл явцад оролцогч талуудын бодол, сонирхлыг тэнцвэртэй хангахад цагдаад удирдамж болж, туслах багц хэрэгсэл гэж үзэх болсон байна. Хүний эрхийн үнэт зүйлс нь ИБУИНВУ дахь цагдаад зөв зүйлийг "айдас, эсхүл ашиг сонирхолгүйгээр" хийхийг илүү эрмэлзэх боломж олгож байна.



**Түлхүүр үгс:** Цагдаагийн хууль сахиулах ажиллагаанд Хүний эрхийн тухай хуулийг хэрэглэхэд гарч буй хувьсал, өрсөлдөгч эрхүүдийн тэнцвэрийг хангах, хамгийн эмзэг хэсгийг хамгаалах үүрэг, хүний эрх ба эсэргүүцэл, нийгмийн дэг журмыг хангах ажиллагаа.

## Оршил

Энэхүү тусгай дугаарыг Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал батлагдсаны 70 жилийн ойг тохиолдуулан гаргаж байна. Уг тунхаглал нь ирээдүйд батлагдах заавал биелэх шинжтэй хүний эрхийн гэрээдийн суурь болсны нэг нь Их Британид 1998 оны Хүний эрхийн тухай хуулиар дамжин шууд хэрэгжих боломжтой болсон Европын Хүний эрхийн конвенци (ЕХЭК) зэрэг юм. Хүний эрхийн тухай хууль 2000 оны 10 дугаар сард хүчин төгөлдөр болсноос хойш ИБУИНВУ-д цагдаагийн үйл ажиллагаанд улам бүр чухал шалгуур баримт бичиг болж байна.

Хорин жилийн хугацаа өнгөрч, Хүний эрхийн тухай хуулийг Британийн эрхийн Биллээр<sup>1</sup> солихыг уриалсан дуудлагаас үүдсэн маргааны хүрээнд, ИБУИНВУ Европын Холбооноос гарах нь гарцаагүй болж буй энэ мөчид (Европын Холбоо Суурь эрхийн тухай дүрэм боловсруулаад буй)<sup>2</sup>, бид Хүний эрхийн тухай хууль зорилгоо биелүүлсэн үү, ЕХЭК-д туссан эрхүүдийг хангаж, хүндэтгэх нөхцөлийг сайжруулж чадсан уу гэж асуух зүйтэй юм.

Энэ асуултыг өөрсдөдөө тавьснаар бид ИБУИНВУ-ын цагдаагийн хууль сахиулах ажиллагаа Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын агуулгыг хэр сайн сахиулж, дээдэлж, хүндэтгэж байгаа вэ гэдгийг гарцаагүй тодорхойлох юм: цагдаагийн талбар дахь ажиллагаатай холбоотойгоор энд бидний авч үзэх ЕХЭК-ын олон эрхийг өмнө нь Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалд тодорхойлсон болно. ЕХЭК-ын үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн талаарх 10 дугаар зүйл нь Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 19 дүгээр зүйлтэй дүйдэг бол эвлэлдэн нэгдэх эрхийн талаарх 11 дүгээр зүйл нь Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 20 дугаар зүйлд туссан байна.

Цагдаагийн үйл ажиллагааны хүрээнд Хүний эрхийн тухай хууль хэр амжилт олсон болохыг үнэлэхийн тулд сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд цагдаагийн үйл ажиллагаанд үзүүлсэн нөлөөллийг бүдүүвчилэн гаргалаа. Бид тулгарсан сорилт, мөн тодорхой болсон болон бидний бодоход цагдааг хүний эрхийн стандартуудыг ойлгож, хэрэглэхэд нь илүү уян нарийн, мэргэжлийн болоход хүргэсэн сургамж, боломжуудыг авч үзэв.

1 Эрхийн Биллийн талаарх Комиссоос 2012 онд гаргасан сүүлчийн тайланг дараах холбоосоор харна уу: <http://webarchive.nationalarchives.gov.uk/20130206021312/http://www.justice.gov.uk/about/cbr/>

2 Брекситийн дараа 2018 оны Еврпын Холбооноос гарах тухай хуулийн 5(4) дэх заалтын дагуу "Европын Холбооноос хадгалан үлдэх хууль"-аас Суурь эрхийн талаарх Дүрмийг хасах юм.

2000 онд улс даяар ажиллаж буй 140,000 орчим цагдаагийн алба хаагчдад хууль тогтоомжийн нарийн ярвигтай хэсгийг таниулах сургалтыг зохион байгуулах томоохон сорилтыг голлон цахим сургалтын аргаар болон сургалтын цахим хэрэглэгдэхүүн тараах байдлаар туулсан юм. Эдгээр нь алба хаагчдад гол зүйл, заалтуудын талаар өнгөцхөн мэдлэг, ЕХЭК-ын зүйлүүд хоорондын нарийн ярвигтай харилцан үйлчлэлийн талаар хязгаарлагдмал ойлголт өгчээ. Эргээд харахад цагдаагийн үйл ажиллагаанд ЕХЭК-ын аль нэг элементийг тусад нь авч үзэх боломж өгдөггүй байснаас үзвэл өрсөлдөх эрхүүдийн талаар гүнзгийрүүлсэн мэдлэг, таниулга дутмаг болсон нь тухайн үед тэрхүү аргачлалын дутагдалтай тал байв. Энэ ээдрээт байдлыг энэ өгүүллийн зорилгод дараах гурван элементээр тоймлож болно: тэнцвэр, үүрэг, уян хатан байдал.


### **Бидний мэргэжлийн агуулга**

Цагдаагийн үйл ажиллагаа нь бараг бүх талаараа шийдвэр гаргах үйл явцад хүргэдэг бөгөөд хүргэж ирсэн болно. Одоо өөрчлөгдсөн зүйл гэвэл үүнийг ЕХЭК-д заасан эрхүүдийг бие биетэй нь тэнцвэрийг хангах шаардлагын хүрээнд хүний эрхэд суурилсан байдлаар хэрэгжүүлж байна. Энэ нь нэг талаас голлон цагдаагийн үйл ажиллагаа, стратеги, тактикийн нөлөөлөлд ордог сэжигтэн, буруутай этгээдийн эрхийг харгалзан үзнэ гэсэн үг юм. Нөгөө талаар цагдаагийн хамгаалал шаардлагатай хохирогч болон нөлөөлөлд өртсөн, нийгмийн өргөн хүрээний гишүүдийн эрхийг цагдаа анхаарах ёстой.

Эн тэргүүнд үүнийг харгалзахаас гадна суурь эрхийг дээдлэн хамгаалах цагдаагийн шууд үүрэг хариуцлагын нарийн онцлог ялгаа бий. Өөрөөр хэлбэл цагдаа нь бусад нийтийн албан байгууллагын адил иргэд суурь эрхээ бодитоор хамгаалуулж, эдлэх баталгааг хангах үүрэгтэй. Энэ үүрэг, хариуцлагын нөгөө талд илүү уламжлалт шинжтэй шууд бус үүрэг хариуцлага байдаг нь хүний эрхийг зөрчихөөс зайлсхийх замаар хүний эрхэд хөндлөнгөөс шаардлагагүй нөлөөлөхөөс түдгэлзэх үүрэг юм.

Өөр нэг ээдрээт зүйл нь ЕХЭК-оор цагдаа Европын аль нэг эрх зүйн харьяалал дахь хүний эрхийг нөгөө харьяалах бүс нутагт хүндэтгэх ёстой гэсэн нийтлэг уялдаа бий болохгүй гэсэн зарчимд оршино: Европын Хүний эрхийн Шүүх нь нэг ижил асуудлаар нэг улсаас нөгөө улсад зарим нэг уян хатан байдлаар хандах боломж олгодог. ("ойлголтын ялгаа" гэдэг)

Ийм нарийн ээдрээ нь олон тооны цагдаагийн албан хаагчид сургалт зохион байгуулахад практикийн болон логикийн сорилт бий болгодог. Гэхдээ 2000 оны эхэн үед Хүний эрхийн тухай хуулийг нэг мөр хэрэгжүүлэхэд хүндрэл учирч байлаа. Хэдий олонх нь "Цагдаа"-г байгууллага гэж ханддаг боловч голлон хувь хүн болохынх нь хувьд цагдаагийн алба хаагчдын хамтлагийг буюу хамтран ажиллагчдын багийг ойлгох бөгөөд тэдгээрийн зарим нь өөрчлөлтөд хойрго ханддаг. Хувь хүний шинжтэй тийм хойрго хандлагаас гадна хязгаарлагдмал хүрээтэй сургалтаар ЕХЭК-ыг "гэмт хэрэгтнүүдэд



зориулсан журам”<sup>3</sup> гэсэн хэвлэл мэдээллийн хэрэгслээс үүдэлтэй буруу төсөөллийг арилгаж чадаагүйгээс шалтгаалан хүний эрхийн ойлголтод итгэл үнэмшил дутмаг болоход хүргэж байлаа. Энэ нь цаашилбал цагдаагийн үзэл ойлголтод нөлөөлж, улмаар цагдаагийн өдөр тутмын мэргэжлийн ажиллагааны арга барил дахь ЕХЭК-ын анхны нөлөөлөл тун хязгаарлагдмал дутуу болоход хүргэсэн юм.

Гэвч 2000 оны эхэн үеийн Хүний эрхийн тухай хуулийн талаар цагдаагийн ойлголт, хэрэглээг хэт доогуур үнэлэхээсээ өмнө тухайн үед уг хууль нь зарим талаараа ИБУИНВУ-д цагдаагийн үйл ажиллагаанд цоо шинэ суурь бий болгож байсныг тэмдэглэх нь шударга болно. Тухайн үед цагдаагийн нэгжийн дарга нарт ЕХЭК-д заасан эрхүүдийн хамрах хүрээ, практик хэрэглээний талаар мэргэжлийн хөгжлийн томъёоллын хувьд хялбар ашиглаж болох, эсхүл илүү үр өгөөжтэйгээр шийдвэр гаргах агуулгын хүрээнд хангалттай таньж мэдэх буюу учир холбогдол бүхий хэрэг хянан шийдвэрлэсэн эрх зүйн түүх байсангүй. Хүний эрхийн талаарх өргөн нийтлэг мэдлэг ойлголт, хэрэг хянан шийдвэрлэсэн байдал дутмаг байснаас цагдаагийн ажлын тэргүүн эгнээнд ажиллаж буй алба хаагчдад их төлөв давчуу цаг хугацаанд хүнд шийдвэр гаргахад тус болох зүйл хомс байлаа.

Энэ байдал удаан үргэлжлээгүй юм. Удалгүй гарсан олон тооны эмгэнэлт үйл явдлуудын үеэрх цагдаагийн үйл ажиллагаа, эс үйлдэхүй нь Хүний эрхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийг анхаарлын төвд баттай оруулсан юм. Уг зүйлд “Төрийн эрх бүхий этгээд конвенцод заасан аль нэг эрхэд нийцээгүй байдлаар үйлдэл хийхийг хориглох” бөгөөд “Үйлдэл” гэдэгт эс үйлдэхүй” орох ажээ.

2000 онд гарсан Викториа Климбиэгийн, 2003 онд Хермитэйжэд гарсан Жулиа болон Виллиам Пембертоны зэрэг дуулиант аллагын хэргүүдээр ЕХЭК-ын 2 дугаар зүйлд заасан хүний амьд явах суурь эрхийг хамгаалах төрийн эрх бүхий этгээдийн шууд үүрэг хариуцлагад онцгой анхаарал хандуулсан юм. Эдгээр аллагын дараа цагдаа зэрэг төрийн байгууллагуудын үйл ажиллагааны хангалтгүй байдлаас хохирч буй эмзэг нөхцөл байдалд байгаа хүмүүсийг үхэхээс нь өмнө болон үхэх үед нь хамгаалж чадаагүйн төлөө шүүмжилж байлаа. Хоёр хэрэгт хоёуланд нь үхэж болох мэдэгдэхүйц нөхцөл үүссэн байгааг төрийн байгууллага мэдэж байсан ч хохирогчдыг хамгаалах хангалттай арга хэмжээ аваагүй болохыг шалгалтаар тогтоожээ<sup>4</sup>.

Ийм дуулиантай хэргүүдээр хэрэв цагдаа амьд явах эрхийг хамгаалах арга хэмжээ авч чадаагүй гэж үзэх тохиолдолд Хүний эрхийн тухай хуулийг зөрчсөн гэж хариуцлагад татаж болох нь тодорхой болсон юм.

3 <https://ukhumanrightsblog.com/wpcontent/uploads/2014/09/the-monstering-of-human-rights-adam-wagner-2014.pdf>

4 See “Викториа Климбиэгийн шалгалт: Лорд Лемингийн шалгалтын тайлан” (2003 он): <https://www.gov.uk/government/publications/the-victoria-climbié-inquiry-report-of-an-inquiry-by-lordlaming>; “Жулиа болон Виллиам Пембертоны амь үрэгдсэн гэр бүлийн хүрээний хүн амины хэргийг шалгасан нь” (2008 он), : <https://aafda.org.uk/wp-content/uploads/2015/07/Pemberton-Homicide-Review-2008.pdf>

Гэхдээ 2 дугаар зүйлд заасан иргэний эрхийг баталгаатай хамгаалж байгаагаар цагдаагийн байнга хэрэгжүүлж буй тэнцвэрийг хангах нарийн үйл ажиллагааны нэг жишээ болж байна. Хэн нэгний амьд явах эрхэд өөр нэгэн заналхийлж буй нөхцөл бүрт холбогдох цагдаагийн алба хаагчид амь насанд учирч байгаа аюул заналыг сэжиглэгдэж буй талын эрхтэй (ялангуяа 5 дугаар зүйлд заасан (халдашгүй чөлөөтэй байх) болон 8 дугаар зүйлд (хувийн хэрэгтэй байх) харгалзуулан авч үзэж, үнэлэх мэргэжлийн үйл ажиллагааны шаардлага тулгардаг байна. Энэхүү байгаа тэнцвэрийг хангах үйлдэл нь цагдаагийн мэргэжлийн үйл ажиллагаан дахь хүний эрхийн гол сорилт юм. Хар, цагаан дангаар оршдоггүй.

Галт зэвсгийг гэнэт болон төлөвлөж хэрэглэхийн алинд ч, хэн нэгний амь насанд заналхийлсэн аюул болон нийтийн дэг журам сахиулах үйл ажиллагааны алинд ч цагдаагийн удирдах алба хаагчид бүрэн бус тагнуулын зураглалд найдахаас өөр гарц байдаггүй. Удирдлагууд нийгмийн нэг гишүүнд чиглэсэн аюул заналыг үнэлэхийн тулд үндэслэл бүхий таамаглал хийх, хэр хэмжээ таарсан, гарцаагүй шаардлагатай, ЕХЭК-д заасан сөргөлдөх эрхүүдэд нийцсэн цагдаагийн үйл ажиллагаа явуулах шийдвэр гаргах ёстой болдог.

### **Хамгийн эмзэг, сул доройг хамгаалах цагдаагийн шууд үүрэг**

2000 оны үеийн дуулиант эмгэнэлт явдлуудаас үүдэн цагдаагийн үйл ажиллагааны хүрээнд ЕХЭК-ын талаар мэдлэг ойлголт, хэрэглээ нэмэгдэж цагдаагийн албанд үр дүнд тулгуурлан хийсэн ахиц дэвшил гарах болсон байна. Жишээлбэл Хүний эрхийн тухай хуулийн талаарх гүнзгийрүүлсэн сургалтыг удирдлагад зориулсан сургалтад тусган зохион байгуулж байна. Мөн амь нас хамгаалахад санаачлагатай байхад чиглэсэн байдлаар галт зэвсэг хэрэглэсэн ажиллагаа болон аминд халтай нөхцөлд зориулсан хүний эрхэд суурилсан үндэсний стандартуудыг боловсруулж, ажилд нэвтрүүлжээ.

Янз бүрийн эмгэнэлт хэргүүдээс шалтгаалан ЕХЭК-ын 2 дугаар зүйлд заасан шууд үүрэг хариуцлагаа биелүүлэх, эмзэг сул хохирогчдын амь насыг хамгаалахад нь цагдаад туслах хууль тогтоомжийн болон бодлогын өөрчлөлт гарав. Хүүхдэд бэлгийн хүчирхийлэл үйлдэгчийг илрүүлэх схем (Сарагийн хууль) 2010 онд, Гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх схем (Клейрийн хууль) 2012 онд, Гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах мэдэгдэл/тушаал 2015 онд бий болж, аливаа ажиллагаанд хүний эрхэд тавих анхаарал, ялангуяа амьд явах эрхэд тавих анхаарлыг нэмэгдүүлэв. Ингэхдээ эрсдэлт нөхцөлд байгаа хохирогчийг хөнөөлөөс хамгаалах зорилгоор урьдач санаачлагатай цагдаагийн үйл ажиллагаанд урьд үеэс илүүтэй ач холбогдол өгөх болов. Эдгээр схемд ч хязгаарлагдмал тал бий бөгөөд нөлөөлөгч бүлгүүд, эрдэмтэн судлаачдын зүгээс жишээ нь нууцлал нь хамгаалагдаж чаддаггүй гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид их төлөв харилцааныхаа талаар "илүү урьдач мэдээлэлтэй сонголт" хийх боломжтой нэгэн болж таардаг тул зарим хэсэгт нь Клейрийн хуулийг

ямар нэг хэмжээгээр "хохилогчийг буруутгах"<sup>5</sup> шинжтэй гэсэн шүүмжлэл гардаг. Гэхдээ бодит байдалд "асуух эрх" (боломжит хохирогч цагдаад хандах үед) эсхүл "мэдэх эрх"-ийн (цагдаа санаачилгатайгаар ил болгоход) дагуу ил гаргах нь хохирогчид хамтран амьдрагчийнх нь өнгөрсөн үеийн талаар баримтыг танилцуулж туслах зорилготой байдаг бөгөөд тун ховор тохиолдолд цагдаа болон хамтран амьдрагчийн зүгээс хохирогчид дэмжлэг үзүүлэх зорилгоор авч оролцдог байна. Бусад хэлбэрийн хөндлөнгийн оролцоонд Байгууллага дундын эрсдийг үнэлэх бага хурал (MARAC)-ын бүрээ болон улс даяар байх итгэмжлэгдсэн Гэр бүлийн хүчирхийллийн хараат бус өмгөөлөгчид (IDVA)-ийн алба зэрэг болно.

Дээд шүүх 2018 оны хавар Хотын цагдаагийн комиссарыг хариуцагчаар татан, DSD нарын нэхэмжлэлтэй<sup>6</sup> хэргийг шийдвэрлэснээр Конвенцын 2 болон 3 дугаар зүйлд туссан ноцтой хор хөнөөлд өртсөн хохирогчийг хамгаалах шууд үүрэг хариуцлагыг нэмэгдүүлсэн юм. Энэ хэрэгт Жон Ворбойс ("Хар хөлсний тэрэгтэй хүчиндэгч")-ын хохирогчдод 3 дугаар зүйлд туссан эрх нь зөрчигдсөний нөхөн төлбөр олгохоор шийдвэрлэсэн DSD нарын нэхэмжлэлтэй шүүхийн шийдвэрт цагдаагийн байгууллага хяналтын шатанд гомдол гаргасан тухай юм. Конвенцын 3 дугаар зүйлд "хэнийг ч эрүүдэн шүүх буюу хүнлэг бус, нэр төрийг нь гутаан доромжилж харьцах буюу шийтгэх ёсгүй" хэмээн заажээ. Ворбойсын хохирогчдод үйлдсэн бэлгийн халдлага нь энэхүү 3 дугаар зүйлийг зөрчсөнд хамаарна. Хотын цагдаагийн газрын хөндсөн маргаантай асуудал нь 3 дугаар зүйлд туссан шууд үүрэг хариуцлага нь тогтолцооны алдаанаас цааш ажиллагааны болон мөрдөн шалгах ажлынханд хамаарах ёстой юу гэдэгт оршиж байлаа. Дээд шүүх хотын цагдаагийн газар мөрдөн шалгах ажлын явцад ноцтой гэж болохоор алдаа гаргаснаар ялангуяа энэ хэрэгт нөхөн төлбөрийн хэлбэрээр гомдол гаргагчид эрх сэргээх үйлчилгээ үзүүлэх ёстой хэмээн тогтоожээ. Дээд шүүх мөнөөх хэрэгт гэмт хэрэг гарсан талаар мэдээллийг бичиж баримтжуулж аваагүй, гэрч нараас даруй мэдүүлэг аваагүй, хяналтын камерын бичлэг (ядаж л цагдаагийн газраас)-ийг цуглуулж аваагүй, олон хохирогчоос нэг хүний талаар ирж буй гомдлыг хооронд нь холбож чадаагүй зэргийг тэмдэглэв. Шүүгч Лорд Керр "мөрдөн шалгах явцад гарсан алдаа ноцтой гэж үзэхүйц байгаа нь цагдаагийн байгууллагын талаас хариуцлага хүлээх үндэслэл бий болгоно" гэсэн байна.

Хэдийгээр Ворбойсийн хэрэг нь 2003-2008 оны хооронд болсон үйлдлүүдтэй холбогддог ч өдгөө, ирээдүйд цагдаагийн хувьд мөрдөн шалгах ажиллагаанд "илэрхий" алдаа гаргаснаас хохирогчид ноцтой хор хохирол учирвал хариуцлага хүлээх болно гэдгийг илэрхий болгожээ. Төрийн эрх мэдэлтнүүдийн үүрэг хариуцлагын талаар тодорхой болгож өгдөг үүн шиг шийдвэрүүд нь эцэстээ цагдаад тавих шаардлагыг нэмэгдүүлж, бидэнд Хүний эрхийн тухай хуульд туссан үнэмлэхүй эрхүүдийг хамгаалах хүрээнд илүү санаачилгатай

5 М. Дуган баЖ. Грейс, 'Гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх схем дэх эрсдлийг үнэлэх нь', (2018 он) 2 Хүүхдийн болон гэр бүлийн эрх зүйн улирал тутмын дугаар 145

6 <https://www.supremecourt.uk/cases/uksc-2015-0166.html>.



байхад зүй ёсоор урам зориг өгөх юм. Ноцтой хэргүүд болон авсан сургамжийн үр дүнд цагдаагийн бэлгийн халдлага, эрсдэл бүхий хохирогч зэргийг хариуцан ажиллахаар мэргэшсэн тусгай нэгжүүдэд илүү нөөц хүч оруулах, цахим бэлгийн халдлагыг илрүүлэх нэгжүүдэд илүү их хөрөнгө оруулалт хийсээр байна. Өнөөгийн уур амьсгал дунд аюул занал, эрсдлийг бууруулах шаардлага өдөр бүр тулгарч ингэснээрээ бид хохирогчдыг ноцтой хор аюулаас хамгаалахыг зорьж байна. Хэдийгээр цагдаагийн нөөц боломжид дарамт шахалт ирж байгаа ч тэдгээр ноцтой гэмт хэргүүд тэргүүлэх анхаарлын төвд байх бөгөөд энэ мэт шүүхийн шийдвэрүүдийн үзүүлэх нөлөө болон нөөц бололцоонд тулгарч буй сорилт нь гэмт хэргийн хүрээний доод үзүүрт байх гэмт хэргүүдэд чиглэсэн хариу арга хэмжээнд илүүтэй нөлөө үзүүлэх магадлалтай болно.

Цагдаагийн удирдлагуудын аз болоход хүний амь насанд бодитоор аюул заналхийлсэн буюу ноцтой гэмт хэрэг гарсан үед сергөлдөх эрхүүдийн хооронд тэнцвэр хангахад харьцангуй ил тодорхой, амьд явах суурь эрх нь эн тэргүүнд тавигдах бөгөөд их төлөв аливаа сэжиглэгдэж буй талын хязгаарлагдмал эрхийг хөндөхөд зөвтгөх үндэслэл болдог. Ийнхүү "хэмжих нь" нийтийн хэв журмын талбарт гарч, хүний амь насанд заналхийлсэн аюул тодорхойгүй, сергөлдөгч, өргөн хүрээний бүлгүүдийн эрх Хүний эрхийн тухай хуульд туссанаараа ижил байр суурьтай байдаг тодорхой үйл явдал, эсэргүүцэл зэргийн үед хэв журам сахиулах үед илүү хүнд сорилт болдог. Энэ үед холбогдох хэрэг шийдвэрлэлтэд гарах өөрчлөлт болон ЕХЭК-ын талаарх оновчтой мэдлэг ойлголтоо сайжруулж, үнэлэх цагдаагийн нэгдсэн хүчин чармайлт нь эсэргүүцэл болон нийтийн хэв журмыг сахиулах цагдаагийн үйл ажиллагааны мэргэжлийн байдалд эрс өөрчлөлт гаргах боломж олгоно.

### **Хүний эрх ба нийтийн дэг журам сахиулах, нийтийг хамарсан эсэргүүцлийн үед ажиллах**

2001 онд нийтийн хэв журмыг хангах ажиллагаанд оролцдог алба хаагчдад зориулан гаргасан хувийн аюулгүй байдлын гарын авлагад Хүний эрхийн тухай хуулийн талаар туссан ганц зүйл нь хүч хэрэглэх болон нэгжлэг, үзлэг хийхтэй холбоотой байв. Нийтийн хэв журам сахиулах ажиллагааны үеэр удирдлагуудын хэрэглэх шийдвэр гаргах/мэдээлэл өгөх загварыг нь тухайн үед IIMARC (Intention, Intelligence, Method, Administration, Risk and Communications) гэдэг байсан бөгөөд Хүний эрхийн тухай хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлмэгц "хүний эрх" гэдгийг илэрхийлэхийн "Н" үсгийг төгсгөлд нь нэмж IIMARCH багцыг бий болгосон байна. Энэ үед олон баримт бичиг, ажиллагааны тушаалуудын төгсгөлд "Энэ баримт бичгийг ЕХЭК-д нийцүүлэн гаргав" гэсэн мөр оруулж бодлого болон ажиллагааны тушаалууд дахь хүний эрхийн өөр дүн шинжилгээ, туссан зүйлгүй байлаа. Одоо бол бид энэ хандлагыг сэтгэл ханасан, эсхүл ЕХЭК-ын талаар мэдлэг дутмаг байгаагийн, эсхүл аль алиных нь шинж гэж үзэж болох юм. Эргээд 2019 оны нүдээр, мөн Хүний эрхийн тухай хуулийн талаарх тогтворжсон сургалт болон уг хуулийг

тусгасан, сайжруулсан шийдвэр гаргах загвар (Шийдвэр гаргах үндэсний загвар)-ын үр нөлөөн дээр тулгуурлан харвал, тухайн үед дагаж мөрдөж байсан загвар болох IIMARCH нь эрсдэл, хүний эрх хоёрыг аль алиных нь арга зүйг тодорхойлсны (жишээ нь тактик, нөөц боломж гэх мэт) дараа авч үзэхээр байснаас гадна үнэндээ нийтийг хамарсан эсэргүүцлийн талаарх цагдаагийн ажиллагааны хандлага аль хэзээний тогтсон байсан зэргээрээ үндэс сууриараа алдаатай байлаа.

2000-аад оны туршид ахиц дэвшил гарахын зэрэгцээ нийтийн хэв журмыг сахиулах ажиллагаа нь 2009 онд Лондон хотод болсон G20-ийн уулзалтыг эсэргүүцсэн арга хэмжээний үр дүнд үндсээрээ өөрчлөгдсөн юм. Эдгээр эсэргүүцлийн үеэр хэв журмыг сахиулах ажиллагааг Айан Томлинсоны үхэл болон цагдаа нар кеттлингийн тактик хэрэглэсэн, хүч хэтрүүлэн хэрэглэсэн зэрэгтэй холбогдуулан хэвлэл мэдээллийн хэрэгслээр өргөн хэмжээгээр нэвтрүүлсэн юм. Мөн оны 11 дүгээр сард Хатан хааны Цагдаагийн Хянан шалгах газраас Эсэргүүцлийн үеэр тохируулан ажиллах нь-Цагдаагийн хууль сахиулах ажиллагааны Биртани загварыг бэхжүүлэх нь хэмээх зааварчилгааг хэвлэж, нийтийн хэв журмыг сахиулахтай холбоотой нарийн, байнга өөрчлөгдөх хууль зүйн дүрслэлийг хүлээн зөвшөөрснөөс гадна тэмдэглэсэн нь:

«Онцгой сэтгэл түгшээж байгаа зүйл бол 1998 оны Хүний эрхийн тухай хуулийн дагуу цагдаагийн хүлээх болсон хүний эрхийн хариуцлагын талаар мэдлэг маш доогуур байгаад оршино. Цагдаагийн алба хаагч бүр албаны эрх мэдлээ хэрэгжүүлэхдээ, ялангуяа хүч хэрэглэхдээ хуулийн дагуу хүлээх хариуцлага байгаа үед алба хаагч хуулийг ойлгохын ач холбогдлыг хэтрүүлэн үнэлэх нь хэцүү юм»<sup>7</sup>.

Зөвлөмжүүдийнхээ дунд Цагдаагийн Хянан шалгах газар нийгмийн хэв журмыг сахиулах ажиллагааг цагдаагийн дарга төлөвлөх эхлэх цэг нь ЕХЭК-д туссан эрхүүд болох үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх (10 дугаар зүйл) болон чөлөөтэй эвлэлдэн нэгдэх (11 дүгээр зүйл) эрхийг харгалзан олон нийтийн газар тайван эсэргүүцэл илэрхийлэх жагсаал цуглааныг дэмжин төлөвлөх юм гэж мэдэгджээ. Үр дүнд нь тэр даруй Эсэргүүцэлд зохицох зааварчилгаанд тохируулан нийтийн хэв журмыг сахиулах үндэсний удирдлагын сургалтын "Хүний эрх ба хүч хэрэглэх" асуудлаар тусгайлсан хичээл бүхий томоохон өөрчлөлтүүдийг тусган хөтөлбөрийг бүхэлд нь шинэчлэн боловсруулав. Эдгээр хичээл нь ЕХЭК-ын 9 дүгээр зүйл (шүтэх, эс шүтэх эрх чөлөө) 10, 11 дүгээр зүйлд заасан эрхүүд болон Цагдаагийн Хянан шалгах газраас гаргасан "Цагдаагийн хүч хэрэглэх ажиллагааг журамлах арван зарчим"-д тулгуурлажээ<sup>8</sup>. Стратегийн болон тактикийн түвшний шинэ болон хуучин дарга нарыг бүгдэд нь зориулсан удирдлагын энэ шинэ сургалтын үр дүнд "Эсэргүүцэл илэрхийлэх

7 <https://www.justiceinspectors.gov.uk/hmicfrs/media/adapting-to-protest-nurturing-the-britishmodel-of-policing-20091125.pdf> 14 дэх тал.

8 <http://library.college.police.uk/docs/APPref/use-of-force-principles.pdf>.

эрх"-ийн талаарх дарга нарын мэдлэг ойлголтод бодитой дэвшил гарсан нь эргэлзээгүй юм.

Гэвч санаатай, санамсаргүй аль нь боловч энэ 9, 10, 11 дүгээр зүйлүүдэд конвенцын бусад зүйлүүдээс тусад нь авч үзэж үлэмж ач холбогдол өгснөөр эдгээр "эсэргүүцлээ илэрхийлэх эрх"-ийн ач холбогдлыг бараг үнэмлэхүй байр сууринд өргөсөн юм. Бидний санаснаар тухайн үед ашиглаж байсан сургалтад тусгадаггүй байсан зүйл нь конвенцын 17 дугаар зүйл болон түүний "Эрхийг зүй бусаар гуйвуулан хэрэглэхийг хориглох" заалт байсан нь:

«Энэ конвенцод туссан ямар ч заалтыг аль нэг улс, бүлэг, эсхүл хүн конвенцод туссан эрх, эрх чөлөөний аль нэгийг устгахад чиглэсэн аливаа үйл ажиллагаанд оролцох, аливаа үйлдэл хийж болохоор тайлбарлаж болохгүй.»

ЕХЭК-ын 17 дугаар зүйл болон эсэргүүцэл илэрхийлэгчдийн эрх болон мөн адилхан чухал нийгмийн гишүүдийн эрхийг хамгаалах шууд үүрэг хариуцлагын хооронд тэнцвэрийг хангах шаардлагын талаарх харилцан холбоотой үзэл санаанд эрүүлээр анхаарсан бол цагдаагийн удирдлагууд чухам юуг хууль ёсны, "тайван эсэргүүцэл" гэж үзэж болох/үзэх ёстой талаар илүү тодорхой ойлголттой байхсан билээ. Жагсагчдын зүгээс нийгмийн гишүүдийн, эсхүл бизнесийнхний хуульд нийцсэн үйл ажиллагаанд саад учруулахад шууд чиглэсэн үйлдлийг бусдын эрх, эрх чөлөөг устгахад чиглэсэн үйлдэл гэж үзэж болох байсан бөгөөд сонирхол бүхий бүх талын эрхийн тэнцвэрийг хангахад нь цагдаагийн дарга нарт туслах арга хандлага болох байсан юм. Өдгөөгийн зөв (боловч ярвигтай) байр суурийг Шүүгч Мейлс Шеффилд дэх моддыг орон нутгийн засаг захиргаанаас гэрээгээр гүйцэтгэгч сүйтгэхэд саад учруулсан жагсагчдын эсрэг авсан албадлагын шийдвэрийн талаарх хэрэг дээр тоймлон дүгнэсэн байна. Эрхэм шүүгч Мейлс Шеффилд Хотын Зөвлөл болон Элис Фэйрхилл нарын холбогдох хэргийн (2017)<sup>9</sup> 88 дахь хэсэгт тэмдэглэсэн нь:

"Эсэргүүцлийн хуульд нийцсэн шинж нь цаг хугацаа өнгөрөхөд өөрчлөгдөж болно. Зарим нөхцөлд зөрчлийн шинжтэй, эсхүл бүр гэмт хэргийн хэмжээнд хүрсэн үйлдэл байх тохиолдолд ч, тухайн үйлдэл нь бусдын эрхэд сөргөөр нөлөөлөх, эсхүл, энэ тохиолдолд гарсан шиг, бусдад хууль ёсны ажил хэргээ явуулахад нь саад болох үйлдэл байсан ч үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, эсхүл тодорхой хязгаарлагдмал хугацаанд тайван замаар цуглаан хийх эрх чөлөөг хязгаарлахыг зөвтгөж огт болохгүй юм. Тэр нь төрийн эрх бүхий этгээд болон бусад нь ардчилсан нийгэмд эдгээр эрхийн ач холбогдлын үүднээс тэвчин өнгөрүүлэх ёстой болох зүйл юм. Гэхдээ 10, 11 дүгээр зүйлийг хууль ёсны дагуу хэрэгжүүлж эхэлсэн

эсэргүүцэл илүү уртасгасан хугацаанд үргэлжлэх аваас хууль бус болж хувирч болно. Тухайн зөрчлийн буюу гэмт хэргийн шинжтэй үйлдэл илүү ноцтой бөгөөд бусдын эрхэд үзүүлэх нөлөө нь их байх тусам хугацаа нь тэр хэрээрээ эхэндээ хууль ёсны байсан эсэргүүцэл хууль бус болж хувирхааргүй богино байх нь зүйтэй. Мөн нэгэн адилаар төрийн эрх бүхий этгээд, ялангуяа ардчилсан байдлаараа хариуцлага үүрч чадахуйц этгээдээс маргаантай шийдвэрээ эргэн харахыг шаардах зорилготой эсэргүүцэл болон тийм эрх бүхий этгээдийг удаан үргэлжилсэн маргаан хэлэлцүүлгийн дараа хүрч, тогтсон хууль ёсны шийдвэрийг гаргахад нь саад учруулах гэсэн эсэргүүцэл хоёрын хооронд ялгаа бий."

Эхэн үед конвенцын 17 дугаар зүйлд цагдаагийн зүгээс анхаарал хандуулж байсан байдал нь "тайван замаар эсэргүүцэл илэрхийлэх төлөв"-д яг шаардлагатай өнгө ялгааг нь нэмж өгөхөд туслах байв. Гэтэл оронд нь энэ төлөв таамаг нь, ялангуяа Айан Томлинсонын хууль бус үхлийн талаар гаргасан шийдвэрийн дараа, хойших хэсэг хугацаанд цагдаа асуудал ихтэй, нөлөөлөл бүхий эсэргүүцлүүдийг "зохицуулах"-аа үргэлжүүлсээр байх уур амьсгалыг бий болгосон байна. Цагдаа олон нийтийн газруудад цуглаан зохион байгуулах, үзэл бодлоо илэрхийлэх эрхэд хэт их анхаарал хандуулсан нь олон талыг хамарсан бүлгүүдийн зүгээс тэдний өөрсдийн эрхэд саад болно гэж үзэх байдлаар эсэргүүцлийн жагсаал, цуглаан зохион байгуулах "зөвшөөрөл" өгч байна гэх шүүмжлэл дагуулах болов. Цагдаагийн нэгжийн удирдлагууд бүгд их төлөв ийм маягаар "зөвшөөрч зохицуулах" байр суурийг эсэргүүцэж байгаагүй бөгөөд магадгүй тун саяхных гэхээр нутгийн олон нийт Белфаст дахь жагсаалыг хянах цагдаагийн үйл ажиллагааг эсэргүүцэж 8 дугаар зүйлд туссан хувийн хэрэг, гэр оронтой байх эрхээ хүлээн зөвшөөрүүлж, хамгаалуулахаар шаардсан R (DB) болон Умард Ирландын Цагдаагийн албаны хооронд үүссэн (2017) хэрэг<sup>10</sup> гарах хүртэл ингэх эрхтэй мэтээр амар итгэчихээгүй юм. Энд 8 дугаар зүйлийг хөндсөний учир нь жагсаалын зам дагуух хувь хүмүүсийн гэр оронд сүйтгэл учирдаг байсанд оршиж байв. Лорд Керр уг хэргийн талаарх товч дүгнэлтдээ мэдэгдсэн нь:

«цагдаа өөрсдийгөө ЕХЭК-ын 11 дүгээр зүйлээр хүлээсэн зарчмын хувьд хууль бус байсан ч болж байгаа эсэргүүцлийн үйл ажиллагааны үед зохицуулалт хийх үүрэг хариуцлагаа биелүүлж байна хэмээн буруу бодсон байна. Эсрэгээрээ ... боломжтой бол илт хууль бус жагсаалыг таслан зогсоох, конвенцын 8 дугаар зүйлд заасан эрхүүд нь зөрчигдөж байгаа хүмүүсийн эрхийг хамгаалах зайлшгүй үүрэгтэй юм.»

Цагдаагийн байгууллага эсэргүүцлийн үйл ажиллагаа явуулж байгаа хүмүүсийн эрхийг хамгаалахаар үл хязгаарлан бусдын буюу өөрөөр хэлбэл олон нийтийн

эрхийг хамгаалах шууд идэвхтэй үүргээ ухамсарлаж, биелүүлэхэд 2017 оны DV-ийн хэрэг чухал түлхэц болсон юм. Цагдаа ЕХЭК-ын 17 дугаар зүйлд илүүтэй тулгуурлаж, заримдаа эсэргүүцэл зохион байгуулагчдын эрхийг илүү хязгаарлахыг зөвтгөх байдлаар эрхүүдийн тэнцвэрийг илүү ялгаатайгаар хангаж эхэлсэн байна. Үр дүнд нь ердөө л "тайван замаар зохион байгуулж байгаа эсэргүүцлийг зөвшөөрч зохицуулах" гэсэн 2009 оны байр суурьнаасаа эрс өөрчлөгджээ. Цагдаад "айх, эсхүл тал харах" гэж огт байж болохгүй бөгөөд харин эсэргүүцлийн болон сөрөг эсэргүүцлийн бүлгүүдийн эрх төдийгүй нөлөөлөлд өртөж буй ердийн олон нийтийн эрхийг тун хянамгай тэнцвэртэй авч үзэх ёстой боллоо.

Бид мөн цагдаагийн үйл ажиллагаанд ашиглаж буй технологийн шинэчлэл ч мөн хүний эрхийн цоо шинэ сорилтын нэг болж байгааг анхаарах нь зүйтэй. Лондон хотын Цагдаагийн газраас Gangs Matrix хэмээх Алгоритмт мэдээллийн сан, эрсдэл үнэлэх системийг ашиглаж буйг Мэдээллийн комиссарын газраас хууль бус гэж 2018 оны 11 дүгээр сард үзсэн юм. Gangs Matrix нь ИБУИНВУ-ын хувийн нууцыг хамгаалах тухай хууль тогтоомжийн хүрээнд хамаарах, ЕХЭК-ын 8 дугаар зүйлд туссан хамгаалал, хувийн болон гэр бүлийн амьдралд зайлшгүй байх хүндэтгэлд холбогдох өгөгдөл цуглуулах хэд хэдэн зарчмыг зөрчиж байгаа тул гүйцэтгэх хуудас гаргажээ. ИБУИНВУ-ын Мэдээллийн комиссар Элизабет Денхэм мэдэгдсэн нь:

«Миний явуулсан шалгалтаар Gangs Matrix-аар тоймгүй олон тооны хар арьст залуу хүмүүст хохирол, аюул учруулж олзошгүй өгөгдөл хамгаалах хуулийг зөрчсөн хэд хэдэн ноцтой зөрчил илэрсэн болно. Миний үзэхээр хүмүүс, сэжиглэгдэж буй бүлэглэлийн гишүүд ч, хохирогчид ч яаж уг матрицэд орчихсон юм. Тэдний хувийн мэдээллийг хэн хэрхэн ашиглаж байгаа, хэр зохистой ашиглаж байгаа гэх зэргээр шударга ёсонд энэ бүхэн хамаарна. Миний шалгалтаар илэрснээр бол матрицэд орсон хүмүүст хохирол, аюул учруулж болзошгүй, өгөгдөл хамгаалах хуулийг зөрчсөн 12 ноцтой зөрчил байна. Хүмүүсийн үндсэн өгөгдөл, мэдээллийг хайхралгүй өнгөрөөх нь итгэлцэл үгүй болгоно. Хотоос үйлчилгээ авч буй хүмүүсийг цааш түлхэх эрсдэлтэй. Зохион байгуулалттай бүлэглэлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд олон нийттэй итгэлцэл бий болгох нь хүмүүс цагдаад хандсанаар сөрөг үр дагавар гарахгүй гэж бүрэн мэдэж байгаа тохиолдолд үүсдэг. Матрицэд орсноосоо болоод л хувийн мэдээлэл нь онц шаардлагагүй хүн хүнд дамжихгүй гэдгийг мэдсэнээр, орон сууц, ажил албатай болох боломжид нь сөргөөр нөлөөлөхгүй гэдгийг мэдсэнээр, ялгаварлан гадуурхагдахгүй гэдгээ мэдсэнээр энэ бүхэн боломжтой.»<sup>11</sup>

11

<https://ico.org.uk/about-the-ico/news-and-events/news-and-blogs/2018/11/informationcommissioner-s-investigation-into-the-metropolitan-police-service/>

## Дүгнэлт

Хүний эрхийн хууль хүчин төгөлдөр болсноос хойш хорин жилийн хугацаанд уг хуулийн талаарх цагдаагийн хандлага хязгаарлагдмал ойлголттой байсан үеэс манай хүчний дотор дуудлага хүлээн авагчаас стратегийн дээд удирдлага хүртэл байгууллагын бүхий л түвшинд гарч буй шийдвэр бүрт уг хууль тусгалаа олдог болтол илт хувьсан өөрчлөгдсөн байна. Мэдээж Хүний эрхийн тухай хуулийг ойлгож, хэрэглэхэд бүс нутгийн болон хувь хүний шинжтэй ялгаа гардаг бөгөөд бид байнга шийдвэр гаргах хэдхэн секундын боломжтойгоор хэцүү алба гүйцэтгэх үүрэг хүлээсэн хүн төрөлхтөн болохын хувьд алдаа ч бас гарах л болно. Гэхдээ сүүлийн хорин жилийн хугацаанаас үзвэл Хүний эрхийн тухай хуулийг ойлгоход гарсан эдгээр алдаа, хувьсал л үлэмж хэмжээний ахиц дэвшил гаргах боломж олгожээ. Заримдаа цагдаа ажилдаа хүний эрхийг хүндэтгэн сахихаасаа гуйвдаг нь үнэн ч ИБУИНВУ-ын цагдаагийн ажиллагаанд хүний эрхийн үнэт зүйл улам бүр гол байр суурь олох болсон байна. Бодит байдлаар авч үзвэл ИБУИНВУ-ын цагдаагийн алба хаагчийг одоо хүний эрхийн оролцогч гэдгээр хүлээн зөвшөөрөх нь зүйтэй юм. Энэ нь ИБУИНВУ-ын цагдаагийн ажиллагаа хэвлэл мэдээллийн хэрэгслээр гаргаж байгаагийн ихэнх хувь нь алдаа, дутагдлыг нь (заримдаа үнэнээр) ширүүн шүүмжилж, хэт олон давтан гаргаж байгаагаар үгүйсгэгдэж болох юм. Төрийн бус байгууллагуудын хийж байгаа мэдэгдлүүд цагдаагийн хүчин хүний эрхийг зөрчсөн байдлаар мэдээлэх, энэ улсад өдөр бүр цагдаа хүний эрхийн талаар гүйцэтгэж буй хүнд хөдөлмөрийг барагтай л бол хүлээн зөвшөөрөхгүй хандлагатай байдаг.

Цагдаагийн албаны хувьд 2019 онд тулгарч буй олон сорилт байсныг Дотоод хэргийн хорооны "Ирээдүйн төлөө цагдаагийн ажиллагаа"<sup>12</sup> нэрт тайланд тоймложээ. Гэхдээ бид Хүний эрхийн тухай хуулийг сайтар ойлгож авсан нь бидэнд аюул занал дээд зэрэгт хүрсэн, амь нас хамгаалах гол үүргээ гүйцэтгэх шаардлагатай болох тохиолдлуудыг илүү бодитой тодорхойлж, хариу арга хэмжээ авах боломж олгох юм. Хүний эрхийн тухай хууль нь бидэнд ёс суртахууны чиг заагч болж, хэн нэгний амь насанд аюул заналхийлсэн шуурхай ажиллагаа шаардлагатай нөхцөл байдалд ч, зөв, буруу аль болох нь тодорхой бус мөрдөн шалгах болон нийтийн хэв журмын алгуур нөхцөлд ч замнахад тус болж байна. Эдгээр өөрчлөлтийн зарим хэсэг нь эмгэнэлт явдал, шударга шүүмжлэлээр дамжиж цагдаагийн байгууллагад цохилт болж ирсэн нь тодорхой ч цагдаагийн албаны дотор ажиллаж буй хүмүүс Хүний эрхийн тухай хуулийг хүлээн авч, уул зорилгодоо хүрэхийн тулд үүнийг хэрэглэх эрмэлзлэл, мэргэшсэн чанартай байдгаараа ач холбогдолтой нь юм. Үүний үр дүнд ИБУИНВУ-ын цагдаагийн үйл ажиллагаа болон Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалд туссан зарчмуудыг тогтмол дэмжсэний үр нөлөөгөөр хүн бүрийн хувьд ЕХЭК-д туссан эрхүүдийн

12

<https://www.parliament.uk/business/committees/committees-a-z/commons-select/home-affairscommittee/news-parliament-2017/policing-for-the-future-report-published-17-19/>

хэрэгжилтийг сайжруулахад түлхэц болж байна. Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал нь заавал биелүүлэх шинж бүхий баримт бичиг биш боловч түүнд цагдаагийн байгууллагын манлайлал, цагдаагийн үйл ажиллагааны бодлогын хүрээг тодорхойлж, боловсруулж болох үнэт зүйлс оршдог юм.

Энэхүү өгүүлэлд илэрхийлсэн санаа нь зохиогчдынх бөгөөд Цагдаагийн байгууллагынх биш болохыг анхаарна уу.

*Орчуулсан: Хүний эрхийн Үндэсний Комиссын  
Олон улсын гэрээ, эрх зүй, хамтын ажиллагааны  
хэлтсийн дарга Ө.Ундрах*

UIN.MN  
СУДАЛГААНЫ САН



## Д.ДОЛГОРСҮРЭН

Цагдаагийн Ерөнхий газрын Соён гэгээрүүлэх, албаны сургалтын хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа

“ЦАГДААГИЙН АЛБАНЫ ОНЦЛОГ НЬ СААД БЭРХШЭЭЛИЙГ ГОМДОЛЛОХГҮЙГЭЭР ДАВАН ТУУЛАХ, АЖЛЫН АЧААЛАЛ ДААХ, БИЕ БОЛООД СЭТГЭЛ ЗҮЙН ХАТ СУУЛГАДАГ”

“POLICE SERVICE IS PEQUILIAR AS IT BUILDS FOR ITS SERVICE PERSONS PHYSICAL AND MENTAL STRENGTH TO OVERCOME ANY OBSTACLES WITHOUT QUESTION AND TO BEAR BURDEN”

“Хүний эрх” сэтгүүл энэ удаагийн дугаарын зочноороо Цагдаагийн Ерөнхий газрын Соён гэгээрүүлэх, албаны сургалтын хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа Д.Долгорсүрэнг урьж ярилцлаа.

**Юуны өмнө манай сэтгүүлд ярилцлага өгөхийг зөвшөөрсөн танд баярлалаа. Цагдаагийн байгууллагын ажилтан, алба хаагчид хүний эрхийн хамгаалагчдын эгнээнд багтдаг. ХЭҮК ЦЕГ хамтарч ажиллаад 17 жил өнгөрсөн байна. Та цагдаагийн байгууллагад олон жил ажиллажээ. Ажлын гараагаа хаанаас эхэлж байв?**



Миний хувьд 1998 оноос хойш буюу МУИС-ийн Хууль зүйн сургуулийг эрх зүйч мэргэжлээр суралцаж төгссөн цагаасаа эхлэн цагдаагийн байгууллагад 22 жил тасралтгүй ажиллаж байна. Цагдаагийн ахлагчаас хурандаа цолтой болтлоо ажиллажээ. Сүүлийн жилүүдэд цагдаа, дотоодын цэргийн байгууллагын соён гэгээрүүлэх, албаны сургалтын чиглэлээр ажиллаж байна. Цагдаагийн байгууллагын ажил алба цаг наргүй ч хоёргүй сэтгэлээр, шантарч халшрахгүйгээр гүйцэтгэх хатуу тангарагтай, нэр төртэй сайхан ажил. Ийм сайхан цагдаагийн хамт олны дунд мөр зэрэгцээд ажиллаж ирсэн. Хүн ажил хөдөлмөртөө эерэг, зөв бодолтой, чин сэтгэлээсээ үнэнч шударга чиг шугамыг баривал амжилт гаргана. Хүнлэг байх, хүн чанартай байх, нийгэмд эерэг үр нөлөөтэй байх нөлөөллийн олон сайхан аянг цагдаагийн байгууллагаас санаачилаад төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулаад иргэдээс сайшаал, төр засгаас үнэлэмж аваад, ажлын үр дүн ч дээшлээд явж байгаад баяртай байна.

**Таны ажлын онцлог уу? Ярилцахдаа дандаа баг хамт олноо ярилаа. Цагдаагийн алба иргэдийн амар амгалан амьдралын төлөө зогсолтгүй үйлчилдэг онцлогтой ажил. Энэ төрлийн ажил мэргэжилтэй хүмүүст сургалт явуулахад амаргүй байдаг уу?**

Бид алба хаагчдынхаа мэдлэг, ур чадварын хөгжүүлэлтэд байнга анхаарч сургалтын хөтөлбөр төлөвлөгөөг жил бүр баталж, хэрэгжүүлж ирсэн. Нэг алба хаагчийг үлдээхгүйгээр сургалтуудад хамруулахын тулд хүн тус бүрт цахим бүртгэл нээж, хаана, хэзээ, ямар сургалтад хамрагдсан талаарх мэдээллийн нэгдсэн санг үүсгэн ажиллуулж, тогтмол хөтөлж байна. Энэ нь ч эхнээсээ үр дүнгээ өгч байгаа гэж хэлж болно. Тухайлбал алба хаагчдыг чадавхжуулах, сургагч багш бэлтгэх зорилгоор Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисстой хамтран жил бүр тогтмол сургалтуудыг явуулж ирлээ. Улсын хэмжээнд цагдаагийн албан дахь хүний эрхийн сургагч багш 100 гаруйг бэлтгэн гаргаж, эхнээсээ тэд дотооддоо сургалт, мэдээллийг заагаад явж байгаа. Энэ жилийн хувьд Хууль зүй, дотоод хэргийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Авлигатай тэмцэх газар зэрэг байгууллагатай хамтран хөдөлмөр аюулгүй байдлын 40 сургагч багш, авлигын эсрэг сургалт, сурталчилгаа явуулах 64 сургагч багш, биеийн хүч, тусгай техник, хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх, бэлтгэл хангах ур чадвар эзэмшүүлэх 113 сургагч багш, нийт 285 алба хаагч сургагч багшаар бэлтгэгдлээ.

**Хүн бүрт цахим бүртгэл үүсгэх нь хөгжүүлэлтээс хоцрохгүй байх давуу талтай гэж та хэллээ. Бусдад үлгэр болгох үүднээс дэлгэрүүлж тайлбарлавал сайн байна?**

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас сүүлийн 20 жилийн хугацаанд сургалтын мэдээллийн нэгдсэн бүртгэлийг Microsoft Excel программ дээр

боловсруулан үйл ажиллагаандаа ашиглаж, өнөөг хүрсэн бөгөөд энэхүү асуудлыг шийдвэрлэх зорилгоор Сургалтын мэдээллийн цахим бүртгэлийн сан “E surgalt” программыг 2019 оны 1 дүгээр сард боловсруулж, үйл ажиллагаандаа ашигласнаар гадаад, дотоодын урт болон богино хугацааны сургалтад суралцаж төгссөн болон одоо суралцаж буй алба хаагч, суралцагчдын судалгаа, сургалтын бүртгэл, сургалтад хамрагдсан байдал, диплом, гэрчилгээний бүртгэл зэргийг цахим хэлбэрт оруулснаар сургалтын бодлого, төлөвлөлт үр дүнтэй, зөв тодорхойлогдож, сургалтын мэдээллийн нэгдсэн цахим бааз бий болж, энэ оны эхний 9 дүгээр сарын байдлаар цагдаа, дотоодын цэргийн байгууллагууд нийт 2,344 удаагийн сургалт зохион байгуулж, 305,738 алба хаагчийг (давхардсан тоогоор) хамруулж, 496 хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан, 351 аудио, видео бичлэг, богино хэмжээний кино бүтээж, 5,412 ширхэг гарын авлага, тараах материал, бодлого, аргачлал хэвлүүлэн тараасан байна.

### **Дэлхий нийтийг хамарсан цар тахал “Ковид-19”-ын үед сургалтууд олноороо хойшилсон. Цагдаагийн байгууллага энэ үед хэрхэн асуудлыг шийдвэрлэв?**

Мэдээж ийм хүнд сорилттой хаа сайгүй тулгарч, олон арга хэмжээг хойшлууллаа. Цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулах, хариу арга хэмжээг шуурхай авах талаар төр засаг, Улсын онцгой комиссоос гаргасан шийдвэрийн хүрээнд олон нийтийн арга хэмжээ, хурал цуглаан, сургалт, спортын арга хэмжээг зохион байгуулахыг түр хугацаагаар зогсоосон хэдий ч цагдаагийн байгууллагаас мэдээллийн технологийн өргөн боломжийг ашиглан алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх давтан, мэргэшүүлэх сургалтуудыг цагдаагийн байгууллагын цахим сургалтын сан “Testserver Moodle” программыг ашиглан зохион байгуулсан нь үр дүнгээ өгсөн.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагад анх орох иргэнийг бүртгэх, албаны сургалт, шалгалтыг онлайн хэлбэрээр авах, хүний нөөцийн цахим сантай холбох ажлын хүрээнд Цахим сургалтын нэгдсэн системийн программыг боловсруулан ашиглаж эхэлснээр сургалттай холбоотой мэдээ, мэдээллийг алба хаагчдад цаг алдалгүй хүргэж, алба хаагч бүр ажлын байран дээрээ цахимаар мэдлэг ур чадвараа дээшлүүлж, үнэлүүлж, дүгнүүлэх болсон төдийгүй Ковид-19 цар тахлын үед хүний нөөцийн хэрэгцээ шаардлага, алба хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх зорилгоор нөхцөл байдалтай уялдуулан “Цагдаа”, “Харуулчин” мэргэжил олгох сургалтыг анх удаа цахимаар болон тухайн нутаг дэвсгэр хариуцсан анги, байгууллагыг түшиглэн зохион байгуулсан нь тухайн байгууллагын удирдлагын зүгээс алба хаагчаа таньж мэдэх, ажил үүрэг гүйцэтгэх чадвар, тогтвор суурьшилтай ажиллаж чадах эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөхөөс гадна суралцагчийг ажлын байранд нь дасан зохицох хугацааг давхар олгож, орон зай, цаг хугацаа, суралцагчдаас гарах зардал(замын болон хувцас,

хоолны гэх мэт)-ыг хэмнэсэн, тэдний аюулгүй байдлыг хангасан зэрэг олон талын ач холбогдолтой байсан.

### **Танай үе үеийн удирдлагууд ч боловсон хүчнээ чадавхжуулах талаар ихээхэн анхаарч, ач холбогдол өгч ирсэн харагддаг. Сургалтуудын үр дүнг юугаар тодорхойлдог вэ?**

Үнэхээр тийм шүү. Аливаа ажил мэргэжлийн өсөлт, дэвшилд сургалт, хөгжүүлэлтийн арга хэмжээ чухал үүрэгтэй. Манай ажлын онцлог нь баг хамт олны хүчээр, хамтдаа даван туулах, хамтдаа хөгжих хэрэгцээ байдаг. Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын соёл, соён гэгээрүүлэх ажил, алба хаагчдад гоо зүйн хүмүүжил олгох, урлаг, спортын арга хэмжээ зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх, алба хаагчийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, зорилгоор Цагдаагийн Ерөнхий Газрын даргын тушаалаар 2018 онд “Байгууллагын соёлыг төлөвшүүлэх хөтөлбөр”, “Эрүүл цагдаа хөтөлбөр”, 2019 онд “Харилцааны соёлыг дээшлүүлэх дэд хөтөлбөр”, “Ахмад, дунд, залуу үеийн залгамж холбоог хөгжүүлэх хөтөлбөр”, 2020 онд “Өнгө нэмцгээе” аян болон иргэд олон нийтийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тэдний эрх зүйн мэдлэг боловсролыг дээшлүүлэх зорилгоор “Ятгах тусам нягтал”, “Ойлгое, хүндэлье”, “Яараад яахав дээ”, “Сүүдэр бүү тусга”, “Нэг хором”, “Цэнхэр алт ус”, “Ой модоо хамгаалъя” зэрэг ухуулга, нөлөөллийн аянуудыг хэрэгжүүлэн ажилласан нь үр дүнгээ өгч, гэмт хэргийн гаралт буурсан эерэг үзүүлэлттэй байна. Энэ бол бодит үр дүн.

### **Ганц хоёр өдрийн сургалтаар тухайн хүнд зорилтот мэдээллийг өгснөөр үр дүн нь дорхноо гарна гэсэн төсөөлөл хүн бүрт харилцан адилгүй байх. Тэгэхээр та бүхэн цагдаагийн алба хаагчдыг чадавхжуулах сургалтуудаа хэрхэн төлөвлөдөг бэ?**

Мэдээж, тухайн сургалтад сууснаар тухайн хүний хандлага, харилцаа шууд өөрчлөгдөнө гэхэд хэцүү ч тодорхой хугацаа, давтамжийн ард үр дүнд хүрэх нь зайлшгүй юм. Тухайлбал, хууль эрх зүйн үндэслэлийн хүрээнд хүний нөөцийн хэрэгцээ шаардлага, алба хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх зорилгоор Дотоод хэргийн их сургуулийн Ахлагчийн сургуулийн сургалтын хөтөлбөртэй уялдуулан “Цагдаа”, “Харуулчин” мэргэжил олгох сургалтын хөтөлбөрийн агуулгад цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн чиглэлийн, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журмыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангахад цагдаагийн алба хаагчийн гүйцэтгэх үүрэг, тусгай хэрэгсэл хэрэглэх, харилцааны ёс зүй, соёл, хувь хүний хөгжил, сэтгэл зүй зэрэг ур чадвар олгох, цагдаа, олон нийтийн хамтын ажиллагаа, хүний эрхийг ханган ажиллахад чиглэгдсэн сургалтуудыг зохион байгуулж, амжилттай суралцан төгссөн 476 иргэнийг албан тушаалд томилуулан ажиллуулж байна. Энэ мэтчилэн тоочвол олон төрлийн сургалтуудыг зохион байгуулж байгаа. Мөн Дотоод хэргийн их сургуулийн төгсөгчид, сонсогч болон багш нарын хоорондын

эргэх холбоог бий болгож, цагдаагийн байгууллагын соёл, онцлог, үнэт зүйлийг сонсогчдод сурталчлан таниулж, итгэл, үнэмшлийг бий болгох, туршлага солилцох, чиглэлээр хамтран ажиллах болно. Гадаадын их, дээд сургууль, академид төгссөн алба хаагчдын холбоог үүсгэн зохион байгуулах, тэдний суралцсан орчинд сургалт явуулах арга барил, алба хаагчдыг хөгжүүлэх боломж зэргийг судалж байна.

**Танай өрөөнд анх орж ирэхэд л тэр зураг сонирхол татаж байлаа. 500 гаруй харчуулын дунд ганцхан бүсгүй сууж байна.**

Манай цагдаагийн байгууллагын мөрдөн байцаах албаны 70 жилийн ойн арга хэмжээний үеэр авахуулсан зураг байгаа юм. Анх ажлын гараага мөрдөн байцаагчаас эхэлж байлаа.

**Цагдаагийн хурандаа цолтой эмэгтэй танаас өөр хэд байдаг вэ? Тэсвэр тэвчээр, хатуужил шаарддаг онцлогтой ажлыг хүйс харгалзахгүйгээр хашихад тулгамддаг зүйл байдаг л байх даа?**

Цагдаагийн албаны онцлог давуу тал нь нэгэнт энэ албыг хашиж л байгаа бол ямар ч саад бэрхшээлийг гомдоллохгүйгээр даван туулах, ажлын ачаалал даах, бие болоод сэтгэл зүйн хат суулгадаг явдал юм. Миний хувьд хамт олноороо маш их бахархдаг. Ялангуяа халуун цэгт албан үүргээ өдөр шөнөгүй гүйцэтгээд явж байгаа цагдаа нараа хараад маш их хүндэтгэдэг. Хайр татам шүү дээ. Өөрийн тань асуусан цолны хувьд цагдаагийн байгууллагаас нийт 13 эмэгтэй хурандаа төрөн гарсан. Энэ нь цагдаагийн сайхан албатай салшгүй холбоотой төдийгүй бидний дундаас Монгол Улсын “Гавьяат хуульч” анхны эмэгтэй алба хаагч, мөн манай ахлагч бүрэлдэхүүнээс саяхан “Үйлчилгээний гавьяат ажилтан”-аар 2 алба хаагч төрсөн нь бахархалтай бөгөөд гайхамшигтай санагддаг. Цагдаагийн алба хаагч бидний хувьд хүний итгэлийг алдахгүй, хуулийн хүрээнд туслах боломжтой бол хэнд ч тусламжийн гараа сунгадаг байх юм сан гэсэн бодолтой байдаг. Цагдаагийн албанд мөр зэрэгцэн он удаан жил жаргал, зовлонгоо хуваалцан хамтран ажиллаж ирсэн хамт олноороо үргэлж бахархахын зэрэгцээ энэхүү албандаа хүндэтгэлтэй зүтгэж, албаараа гоёж яваадаа миний бие туйлаас баяртай явдаг. Цаашид цагдаагийн байгууллагын үнэт зүйл болсон алба хаагчид маань байгууллагынхаа хөгжил, дэвшил, сайн сайханы төлөө зөв хандлага, сэтгэл, зүтгэл гарган ажиллахыг уриалж байна.

Цагдаагийн байгууллагын яруу алдар, сүр хүч өнө мөнхөд мандан бадрах болтугай.

**Цаг, зав гаргаж ярилцсан танд баярлалаа.**

*Ярилцсан: Монгол Улсын Хүний эрхийн  
Үндэсний комиссын референт З.Бадмаарга*



UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс  
Тусгаар тогтнолын талбай, Засгийн газрын XI байр, V давхар  
Утас: 51-266506, 51-262902, Факс: 976-11-320284  
Цахим хаяг: [www.nhrct.gov.mn](http://www.nhrct.gov.mn), Цахим шуудан: [info@nhrct.gov.mn](mailto:info@nhrct.gov.mn)  
Иргэдээс гомдол хүлээн авах, хууль зүйн зөвлөгөө өгөх утас: 7000-0222  
Хүний эрхийн цахим номын сан: <https://lib4u.net/?lib=nhrct>

ISSN: 2617-9288